



*МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН*  
**2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН**

*2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 12-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ*

**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**  
**НЭГДСЭН ХУРАЛДААН**

**ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС**

---

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр, Пүрэв гараг

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	<b>1</b>
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	<b>2-17</b>
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	<b>18-81</b>
<i>1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан нарын 3 гишүүн 2023.10.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	<b>18-33</b>
<i>2.Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.03.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	<b>33-46</b>
<i>3.Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай асуудал</i>	<b>46-47</b>
<i>4.Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<b>47-49</b>
<i>5.Татварын мэргэисэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар 2022.10.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<b>49-69</b>
<i>6.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан нарын 3 гишүүн 2023.10.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<b>69-72</b>
<i>7.Улсын Их Хурлын гишүүнийг чөлөөлөх тухай</i>	<b>72-81</b>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
10 дугаар сарын 12-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 73 гишүүнээс 38 гишүүн хүрэлцэн ирж, 52.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 08 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адъяаа, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Г.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Н.Учрал, Ж.Чинбүрэн, Ц.Цэрэнпунцаг;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Ц.Даваасүрэн, Б.Жавхлан, Л.Оюун-Эрдэнэ, Д.Сарангэрэл, Г.Тэмүүлэн;

Эмнэлгийн чөлөөтэй: М.Оюунчимэг, Б.Саранчимэг, Ц.Сэргэлэн;

Тасалсан: Д.Батлут, Н.Наранбаатар, Б.Энх-Амгалан;

Хоцорсон: А.Адъяасүрэн-01 минут, Ц.Анандбазар-36 минут, С.Батболд-2 цаг 44 минут, Б.Баярсайхан-13 минут, Х.Булгантуяа-36 минут, С.Ганбаатар-13 минут, Д.Ганбат-17 минут, Н.Ганибал-16 минут, Д.Өнөрболор-30 минут, Ц.Сандаг-Очир-01 минут, Ж.Сүхбаатар-09 минут, Д.Цогтбаатар-09 минут, Б.Чойжилсүрэн-04 минут, Н.Энхболд-10 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатараас албан бичиг ирүүлснийг, Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагаас Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороог хуралдуулах горимын санал гаргасныг тус тус танилцуулав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Б.Чойжилсүрэн, Ц.Мөнх-Оргил нарт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

**Нэг.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан нарын 3 гишүүн 2023.10.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, С.Одонтуяа, Ц.Туваан, Н.Алтанхуяг нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Д.Ганбат, Н.Ганибал нар дэмжээгүй, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн дэмжиж үг хэлэв.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн:	32
Татгалзсан:	13
Бүгд:	45

71.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 11 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.03.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Батлан хамгаалахын сайд, дэслэгч генерал Г.Сайханбаяр, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг, мөн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа Ч.Гандирваа, Хуулийн хэлтсийн дарга Г.Энхболд, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал С.Ганбямба, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Ганхүү, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын

Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Т.Аубакир, Н.Ганибал нарын тавьсан асуултад Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Б.Бейсен нар үг хэлэв.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 34  
Татгалзсан: 12  
Бүгд: 46  
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 11 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.*

#### ***Гурав.Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай асуудал***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөхийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг танилцуулав.

Нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Занданшатар:** Хууль зүйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатарыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 33  
Татгалзсан: 12

Бүгд: 45  
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2-г заасны дагуу хуралдаанд оролцсон гишүүдийн олонх томилох саналыг дэмжсэн тул “Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./12.00/

*Уг асуудлыг 12 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.*

*Дөрөв. Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсдэлгэр, мөн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Дархлаажуулалтын албаны дарга О.Дашпагма нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Занданшатар:** Байнгын хорооноос гаргасан Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 19  
Бүгд: 46  
58.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 12 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.*

***Тав.Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар 2022.10.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, мөн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга Б.Болормаа, Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн ерөнхийлөгч Г.Алтанзаяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Дэд дарга Ц.Батбаатар, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Х.Ганхуяг нарын тавьсан асуултад Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн ерөнхийлөгч Г.Алтанзаяа хариулж, тайлбар хийв.

*Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

### **Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1. Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Х.Булгантуяа нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.4.Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээг зөвхөн татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд эрхэлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	18
Татгалзсан:	24
Бүгд:	42

42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын гишүүдийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Занданшатар:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	22
Татгалзсан:	19
Бүгд:	41

53.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Х.Булгантуяа нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.4.Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээг зөвхөн татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд эрхэлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 20

Бүгд: 41

51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, С.Ганбаатар, Ц.Сандаг-Очир /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.7.татварын тайлангийн нийцлийг хянах, шинжилгээ хийх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18

Татгалзсан: 23

Бүгд: 41

43.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханы тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нар үг хэлж, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн тайлбар хийв.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 10.1.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.1.9.хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч нь Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын, хувь хүний нууцад халдах, хувь хүний нууцыг задруулах, залилах, хөрөнгө завших болон эдийн засгийн гэмт хэрэг үйлдэж, шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16

Татгалзсан: 25

Бүгд: 41

39.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

*Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 46 минут үргэлжилж, 12 цаг 54 минутад завсарлав.*

*Үдээс хойших хуралдаан 14 цаг 23 минутад Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх санал хураалтаар үргэлжлэв.*



Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын гишүүдийн ирц хүрээгүй учир дэмжигдээгүй дээрх 3 дугаар санал хураалтыг хүчингүй болгож дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Занданшатар:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 18

Бүгд: 41

56.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** 3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 10.1.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.1.9.хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч нь Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын, хувь хүний нууцад халдах, хувь хүний нууцыг задруулах, залилах, хөрөнгө завших болон эдийн засгийн гэмт хэрэг үйлдэж, шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 18

Бүгд: 41

56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар тайлбар хийж, Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Б.Баттөмөр нар үг хэлэв.

**Г.Занданшатар:** 4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 11.2, 11.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.2.Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд нь татвар төлөгчийг татварын эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар татвар төлөгчдөд мэдээлэл өгөх үүрэгтэй бөгөөд Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн гишүүн байна.

11.3.Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд нь даатгалын байгууллагаа өөрөө сонгож, мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулна.” гэсэн саналыг хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

**Г.Занданшатар:** 5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 12.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.1.8.хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч, орон тооны татварын мэргэшсэн зөвлөх нь ёс зүйн зөрчилгүй талаарх Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн тодорхойлолт.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 19

Бүгд: 41

53.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын “12.1.9”, 10 дахь заалтын “18.2.9” дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 19

Бүгд: 41

53.7 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 14.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.7.Татварын улсын байцаагчийн ажил, албан тушаалд 10-аас дээш жил ажилласан бол татварын албаны тодорхойлолтыг үндэслэн энэ хуулийн 15.1.3-т заасан хоёроос дээшгүй шалгалтаас чөлөөлж болох бөгөөд уг харилцааг татварын мэргэшсэн зөвлөхөд эрх олгох, сунгах, шалгалт авах журмаар зохицуулна.” гэсэн саналыг хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтын 16.1.7, 9 дэх заалтын 17.1.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.1.7.татварын хууль тогтоомж, түүний өөрчлөлт, татвар төлөгчийг татварын эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар татвар төлөгчдөд сурталчлан таниулах, мэдээлэл өгөх.

17.1.6.Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаал, хувь хүний нууцад халдах, хувь хүний нууцыг задруулах, залилах, хөрөнгө завших болон эдийн засгийн гэмт хэрэг үйлдэж, шүүхээр ял шийтгүүлсэн, хувь хүний орлогын албан татварын тайланг хуульд заасан хугацаанд гаргаагүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 20

Бүгд: 41

51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 18.2.10 дахь заалтын “шаардлагын хэм хэмжээг” гэснийг “шаардлагад холбогдох журмыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 19

Бүгд: 41

53.7 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалт болгон шилжүүлж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.5.тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд нь өөрчлөн байгуулагдсан, татан буугдсан, эцсийн өмчлөгч өөрчлөгдсөн болон энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан

мэдээлэл өөрчлөгдсөн бол энэ тухайгаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр мэдэгдэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20  
Татгалзсан: 21  
Бүгд: 41  
48.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 18  
Бүгд: 41  
56.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** 10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалт болгон шилжүүлж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.5.тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд нь өөрчлөн байгуулагдсан, татан буугдсан, эцсийн өмчлөгч өөрчлөгдсөн болон энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан мэдээлэл өөрчлөгдсөн бол энэ тухайгаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр мэдэгдэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 20  
Татгалзсан: 21  
Бүгд: 41  
48.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 18  
Бүгд: 41  
56.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** 10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалт болгон шилжүүлж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.5.тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд нь өөрчлөн байгуулагдсан, татан буугдсан, эцсийн өмчлөгч өөрчлөгдсөн болон энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан мэдээлэл өөрчлөгдсөн бол энэ тухайгаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр мэдэгдэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 17  
Бүгд: 41  
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 3.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.3.“зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд” гэж татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хязгаарлагдмал хариуцлагатай компани, нөхөрлөлийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 16  
Бүгд: 41  
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Х.Булгантуяа нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 9 дүгээр зүйлийн гарчиг болон 9.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

#### **“9 дүгээр зүйл.Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд**

9.1.Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд нь татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хязгаарлагдмал хариуцлагатай компани, нөхөрлөл байх бөгөөд зөвлөх үйлчилгээ эрхлэхдээ бусад татварын мэргэшсэн зөвлөхтэй гэрээгээр хамтран ажиллаж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 17  
Бүгд: 41  
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 10.1.1, 10.1.2, 10.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.1.1.эцсийн өмчлөгч нь татварын мэргэшсэн зөвлөх байх;

10.1.2.эрдэм шинжилгээ, сургалтын чиглэлээс өөр ажил давхар эрхэлдэггүй 2-оос доошгүй орон тооны татварын мэргэшсэн зөвлөхтэй байх;

10.1.8.хуулийн этгээд салбартай бол түүнд нэгээс доошгүй орон тооны татварын мэргэшсэн зөвлөхтэй байх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 16  
Бүгд: 41  
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалтын 11.1.4 дэх заалт, мөн зүйлийн 6 дахь заалтын 12.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.4.үйлчлүүлэгчийн өмнөөс үйлдсэн, шалгасан татварын тайлан, холбогдох бусад баримт бичигт зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал болон орон тооны татварын мэргэшсэн зөвлөхийн эрхтэй албан тушаалтан гарын үсэг, эсхүл тоон гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулах;

12.2.Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай олгох, сунгах бөгөөд энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 17  
Бүгд: 41  
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 14.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.5.Татварын мэргэшсэн зөвлөхийн эрхийг гурван түвшний зэрэглэлтэй олгох бөгөөд нэг, хоёрдугаар түвшний зэрэглэл тус бүрийг 5 жилийн хугацаагаар, гуравдугаар түвшний зэрэглэлийг хугацаагүй олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 18  
Бүгд: 41  
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 8 дахь заалтын 15.1.1, 15.1.2, 15.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.1.1.их, дээд сургуулийг нягтлан бодогч, эдийн засагч, санхүүч мэргэжлээр болон татварын чиглэлээр бакалавр, түүнээс дээш зэрэгтэй төгссөн, эсхүл 5-аас доошгүй жил их, дээд сургуульд татвар, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр багшилсан, татварын асуудал эрхэлсэн төрийн байгууллагад ажилласан байх;

15.1.2.нягтлан бодогч, эдийн засагч, санхүүч мэргэжлээр болон татварын чиглэлээр 4-өөс доошгүй жил ажилласан туршлагатай байх;

15.1.4.зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч нь зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд давхар үүсгэн байгуулахгүй байх;

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалтын 18.2.5, 18.2.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18.2.5.энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан этгээдийг мэргэжил, арга зүй, үйл ажиллагаандаа мөрдөх гарын авлага, татварын хууль тогтоомжийн талаарх мэдээллээр хангах, бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, холбогдох мэдээллийг төрийн байгууллагад хүргүүлэх;

18.2.6.татварын тусгай мэдлэг бүхий шинжээчийг нийтэд мэдээлэх.” гэсэн дээрх 16, 17 дахь саналуудыг хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

**Г.Занданшатар:** 18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 13.3 дахь хэсгийг төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт болгон шилжүүлж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.3.Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийн орон тооны татварын мэргэшсэн зөвлөх ёс зүйн зөрчил гаргасан талаарх Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн тодорхойлолт болон бусад этгээдээс мэдээлэл ирсэн тохиолдолд тусгай зөвшөөрөл олгосон эрх бүхий этгээд түдгэлзүүлэх, хүчингүй болгох эсэхийг шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 17  
Бүгд: 41  
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг төслийн 2 дугаар зүйл болгон шилжүүлж, “авахад” гэсний дараа “болон татварын мэргэшсэн зөвлөхийн эрхтэй холбогдсон харилцаанд” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 16  
Бүгд: 41  
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт болгон шилжүүлж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.1.6.хуулийн этгээд, түүний эцсийн өмчлөгч нь татварын өргүй талаарх тодорхойлолт;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 18  
Бүгд: 41  
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн дагаж мөрдөх хугацааг “2024 оны 01 дүгээр сарын 01 -ний өдрөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 18  
Бүгд: 41  
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

### **Найруулгын санал:**

**Г.Занданшатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын “4.3, 4.4 дэх заалт” гэснийг “4.3, 4.4 дэх хэсэг” гэж өөрчилж, 3 дугаар зүйлийн “хэсэг,” гэсний өмнө “зүйл,” гэж нэмж, төслийн 4 дүгээр зүйлийн “зөвлөх үйлчилгээ эрхлэх” гэсний ард тохиолдол бүрт “хуулийн” гэж нэмж, мөн зүйлийн “11.1 дэх хэсэг” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 18  
Бүгд: 41  
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг хөндөхгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 16  
Бүгд: 41  
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

### **Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал:**

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.3.Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн татвар хариуцсан ажилтан нь татварын мэргэшсэн зөвлөх байна.” гэсэн саналыг хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар үг хэлэв.

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.*

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 15 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.*

**Зургаа. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан нарын 3 гишүүн 2023.10.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, мөн хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын тавьсан асуултад Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн хариулж, тайлбар хийв.

**Г.Занданшатар:** Байнгын хорооноос гаргасан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	24
Татгалзсан:	17
Бүгд:	41

58.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 15 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.*

*Хуралдаан 15 цаг 10 минутад түр завсарлаж, 17 цаг 06 минутаас үргэлжлэв.*

**Долоо. Улсын Их Хурлын гишүүнийг чөлөөлөх тухай**

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.



Улсын Их Хурлын гишүүнийг чөлөөлөх тухай асуудлаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан, Ц.Мөнхцэцэг, Х.Ганхуяг, Б.Энхбаяр, С.Бямбацогт, Ц.Идэрбат, Ц.Туваан нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлт гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар үг хэлэв.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар Улсын Их Хурлын гишүүн Хишгээгийн Нямбаатарын Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	26
Татгалзсан:	17
Бүгд:	43

60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасны дагуу хуралдаанд оролцсон гишүүдийн олонх чөлөөлөх саналыг дэмжсэн тул “Улсын Их Хурлын гишүүнийг чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Улсын Их Хурлын гишүүнийг чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./17.45/

**Бусад.** Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулууны урилгаар Дорнод аймгийн Халхгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг, Б.Баярсайхан нарын урилгаар Завхан аймгийн Цагаанхайрхан сумын ахмадын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболорын урилгаар Мал эмнэлгийн “100 жил”-ийн ойн хүрээнд ахмад малын эмч нар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Н.Энхболд, Ц.Туваан нарын урилгаар Төв аймгийн Сэргэлэн сумын ахмадын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн урилгаар Баянгол дүүргийн “Скаут” хүүхдүүд, Нийслэлийн ерөнхий боловсролын 84 дүгээр сургуулийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын 51 дүгээр сургуулийн 11<sup>б</sup> ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн багш, сурагчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

*Чуулганы нэгдсэн хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.*

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 4 цаг 14 минут үргэлжилж, 73 гишүүнээс 53 гишүүн хүрэлцэн ирж, 72.6 хувийн ирцтэйгээр 17 цаг 47 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр,  
Пүрэв гараг Төрийн ордон “Их  
хуралдай” танхим 10 цаг 08 минут.

### НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Г.Занданшатар:** ... Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Хоёрт нь, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Гуравт, Хууль зүйн байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай асуудал

Дөрөвт, Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл.

Тавд, Татварын мэргэжсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Нямбаатар сайд хаана байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-т гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлын тов, дарааллыг өөрчлөх, хойшлуулах, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдаанаас өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Хишгээгийн Нямбаатараас үг хэлэх тухай албан бичиг ирүүлсэн байна.

Нямбаатар гишүүн. Үгийг ацаглаж илжжүүлж болохгүй гээд дээт заачихсан учраас хууль зөрчинө. Тэгэхээр манай Салдангийн Одонтуяа гишүүний зүгээс бас энэ Агаарын бохирдлын дэд хороог хуралдуулах ийм горимын санал гаргаж байгаа, Даргын дэргэдэх зөвлөлд саналаа илэрхийлсэн.

Энэ Улаанбаатар хотын агаарын бохирдлын асуудал нэн ялангуяа энэ агаарын бохирдолтой холбоотой гомдол санал иргэдээс ихээхэн ирж байгаа. Нүүрсний хэрэглээ газын хэрэглээтэй холбоотой асуудлаар яригдаж байгаа учраас. Хассуурийн Ганхуяг дарга энэ нэлээн их санал гомдол иргэдээс ирж байна. Агаарын бохирдлын дэд хороогоо хуралдуулж энэ нүүрсний хэрэглээ угаарталт, агаарын үнэртэй холбоотой асуудлаар. Ганхуяг гишүүн биш Ганболд гишүүн Гочоогийн Ганболд гишүүн. Гочоогийн Ганболд гишүүн Агаарын бохирдлын дэд хороогоо бас хуралдуулах асуудлыг та Байнгын хороотойгоо яриад тавиад ингээд хуралдуулъя.

Хэлэлцэх асуудалдаа орё. *Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.*

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Энхтайваны Бат-Амгалан танилцуулна аа. Индэрт урьж байна.

**Э.Бат-Амгалан:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 23 дугаар тогтоолоор Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн санал авах өдрийг 2020 оны 10 дугаар сарын 15-ны өдөр байхаар тогтоож мөн хугацаанд ээлжит сонгууль зохион байгуулагдсан билээ. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1-д орон нутгийн ээлжит хурлын сонгуулийн санал

авах өдрөөс өмнөх нэг жилийн хугацаанд аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно гэж хуульчилсан нь 2023 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хугацааг тодорхойлжээ.

Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж тухайн нутгийн өөрөө удирдах байгууллагыг өөрсдийн төлөөллөөр бүрдүүлэх, сонгуулийг нээлттэй, хяналттай зохион байгуулж явуулах удирдлага зохион байгуулалтын эрх зүйн орчныг сайжруулахад чиглэсэн нэмэлт өөрчлөлт оруулах байдлаар боловсронгуй болгох зайлишгүй хэрэгцээ шаардлагатай байна.

Тухайлбал сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчдээс зарцуулах зардлын хэмжээг бууруулах чиглэлээр Сонгуулийн сурталчилгааны хуулиар зөвшөөрсөн арга хэлбэр, түүний тоо хэмжээг 50 хүртэлх хувиар бууруулах, зардлын дээд хэмжээг тогтоохдоо сонгуулийн зардлыг бууруулах чиглэлийг баримтлах. Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, давхардлыг арилгах, нягтлан шалгах үйл ажиллагааны ил тод хяналттай байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигч, сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт мониторинг хийх, төрийн бус байгууллагуудын оролцоог хуульчлах. Сонгогч нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхээ шалгах. Буруу бүртгэгдсэн тохиолдолд гомдол гаргах хэлбэрүүдийг нэмэгдүүлэх санал тоолох төхөөрөмжөөс гаргасан санал хураалтын үр дүн 100 хувь гар аргаар давхар тоолж хяналтын тооллого хийх зэрэг сонгууль зохион байгуулалтын үйл ажиллагааны ил тод хяналтыг нэмэгдүүлэх чиглэлийн

нарийвчилсан зохицуулалтуудыг нэмж тусгах шаардлагатай байна.

Иймд аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулах үйл ажиллагааг болон эрх зүйн орчныг сайжруулах тал дээрх шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг оруулахад уг хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэгт хуульчилсан дээрх хугацаанд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзсэн тул хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулсан. Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах бөгөөд аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэгт хуульчилсан нэг жилийн хугацааг 6 сар болгон өөрчлүүлэх хуулийн зохицуулалтыг тусгасан. Хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд танилцуулна. Индэрт урьж байна.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Бат-Амгалан, Амартүвшин, Энхтүвшин нараас 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 10 сарын 11-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ. Аймаг, нийслэл, сум, дүүргийн

иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тогтолцооны суурь өөрчлөлт хуулиар зохицуулах харилцааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагыг үндэслэн хууль санаачлагч нар аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах хугацааг өөрчлөх зохицуулалтыг тусган хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төслийг Dparliament.mn цахим хаягт байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байгаа. Байнгын хороодын хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж үг хэлээгүй болно оо. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 58.3 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэж гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя СЕХ-ны Хуулийн хэлтсийн дарга Доржсүрэнгийн Бат-Эрдэнэ, хууль санаачлагчийн илтгэл болон байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд. Туваан гишүүнээр тасаллаа.

Жамбын Батсуурь гишүүн асуулт асууна. Норовын Алтанхуяг гишүүнийг нэмье.

**Ж.Батсуурь:** Бүгдэд нь өглөөний мэнд Орон нутгийн сонгуулийн тухай хуулийг өөрчлөх талаар санал оруулж байна. Тэгээд энэ бол угаасаа хуулийн хугацаа нь өнгөрсөн. Тухайн сонгуулийг явахаас нэг жилийн өмнө тухайн хуульд өөрчлөлт оруулсан байх ёстой. Тэгэхээр энэ хуулиа өөрчлөхийн тулд хуульд өөрчлөлт оруулах замаар хуулийг өөрчлөх ийм ажлын эхлэлүүдийг тавьж байх шиг байна. Үүнийг энийг хийсний дараа бол Орон нутгийн сонгуулийн хуулийг өргөн барих байх шинэчлэн. Тэр өргөн баригдаж байгаа төслүүдийг бас сонсоод үзэхэд бол ер нь одоо орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага гэж байхгүй боллоо.

Энэ төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай төвлөрсөн удирдлагатай ийм коммунист, социалист систем рүү Монгол Улс гулсан орох ийм одоо нөхцөл байдал бүрдлээ. Монголын төрийн эрх дээд байгууллага Улсын Их Хурлын хуучин 76 тойргийн чинь 52 нь орон нутагт байдаг аа. Одоо 26 тойргийн чинь 78 энэ чинь мөн одоо 54, 55 нь орон нутагт байна. Монгол Улс ямар том газар нутагтай билээ. Цөөн хүн амтай. Энэ газар нутагт энэ цөөн хүн тархан байршиж 300 гаруй сум мянга гаруй баг хороонд хуваагдан ажиллаж байгаа. Тэр хүмүүсийн эрх мэдлийг сонгуулийн аргаар булааж авах энэ нөхцөлийг бүрдүүлж байгаа учраас би энэ хуулийн төслийг үндсэндээ дэмжихгүй байна, дэмжихгүй байна.

Өнөөдөр салбарын хуулиуд орж ирж Засгийн газрын гишүүд бүх одоо байгууллагуудыг босоо удирдлагатай болгочихлоо. Сонгуулиар дамжуулж аймаг нийслэлийн эрх мэдлийг үгүйсгэх, аймаг нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн сонгууль гэж байхгүй болох, аймгийн хэмжээний орон нутгийн хэмжээний нэгдсэн бодлого зангидагддаг

энэ системийг үгүй хийх ийм нөхцөлийг бүрдүүлж байна.

Тэгээд ер нь одоо хуулийг өөрчилж болохгүй гэж Үндсэн хуульдаа ч тэр органик хуульдаа ч тэр, дагавар хуульдаа ч оруулчихаад тэгээд цагаа болохлоор хуульд өөрчлөлт оруулах замаар хуулийг өөрчлөдөг энэ хуулийн хулгайгаа болиоч ээ. Энэ төрийн дээрмээ болиоч ээ.

Өнөөдөр Монгол Улсыг зөвхөн Улаанбаатараар төсөөлж болохгүй. Зөвхөн нэг намаар төсөөлж болохгүй. Өнөөдөр ард иргэдийн эрх ашиг, нөгөө олонхын оролцоо, нийгмийн бүх бүлгүүдийн санаа сэдэл чинь энэ төрд тусаж байх ёстой юм байгаа биз дээ. Сая та бүхэн Улсын Их Хурлын сонгуулийг Үндсэн хуульд өөрчлөлт оруулах замаар хүч түрэн өөрчилсөн. Тэгвэл одоо орон нутгийн сонгуулийн яг энэ аргаараа бүх ард түмний эрх мэдлийг булааж авах гэж байна.

Тэгэхээр энэ хуулийн өөрчлөлтийг хийж болохгүй ээ гээд хуульд заачихсан байхад л хийж болгодог. жилийн дотор өөрчилж болохгүй гэнгүүт энийг 6 сард болгодог ийм хуулийн өөрчлөлт өргөн барьж байгаад хийнэ гэдэг нь бол хуулийн аргаар дандаа дээрэм тонуул хийдэг, төвлөрлийг нэмэгдүүлдэг эрх мэдлээ хадгалах гэсэн ирэх жилийн сонгуульд одоо яаж бид нар олонх болох вэ? Яаж одоо Их Хурлын сонгуульд дэм болох вэ л гэсэн ийм л хувь тавилан ийм л үзэл санааг энэ хуульд цухалзаж байгаа юу гэхээс өөр ард иргэдэд ашигтай тустай нийгэмд хэрэгтэй хүмүүсийн үзэл санаа суусан энэ хууль үгүй болох гэж байгаад харамсаж байна аа. Ийм учраас энэ хуулийн төслийг үнэхээр эсэргүүцэж байна гэж ингэж хэлж байгаа юм.

### **Г.Занданшатар:**

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ сайд, Эрүүл мэндийн сайд Чинзориг 2 энэ хүн асуулт асуугаад байхад суудалдаа сууна шүү.

Энхтайваны Бат-Амгалан гишүүн хариулна. Тэрний өмнө зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Хаянгаагийн Болорчулууны урилгаар Дорнод аймгийн Халхгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Ирэх онд одоо бид Халх голын ялалтын 85 жилийн ойгоо тэмдэглэнэ. Тэгээд манай зүүн хязгаар Халхын голын сумын иргэдийн төлөөлөгчид та бүхнээрээ уламжлаад нийт Халх голчууддаа болон та бүхэнд эрүүл энх сайн сайхныг Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

Энхтайваны Бат-Амгалан хууль санаачлагч асуултад хариулна аа.

**Э.Бат-Амгалан:** Батсуурь гишүүний асуултад хариулъя аа.

Энэ 2023 оны 6 дугаар сард Улсын Их Хурлаар та бүхэн бид бүхэн Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулаад 2024 оны Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг баталсан. Энэ 7 сарын 8-ны өдөр баталсан. 7 сарын 8-ны өдрөөс хойш энэ намрын чуулганаар аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулахаар хуулийн төсөл бичиж орж ирж байгаа. Ээлжит бус сонгууль зарлаж, энэ аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн төслийг танилцуулах цаг хугацаа байгаагүй ээ. Цаг хугацаа нь нэг ёсондоо хэлэх юм бол цаг хугацааны хайчинд орсон. Бид бүхэн Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиа батлах гэсээр байтал хаврын чуулган өндөрлөсөн.

Ингээд намрын чуулганаар өргөн бариад явж байгаа. 10 дугаар сарын 15-наас өмнө уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ёстой боловчиг энэ олон түмний хэрэгцээ шаардлага улс төрийн олон

намуудын бичгээр ирүүлсэн шаардлагын хүрээнд энэ асуудал маань бас яригдаж байгаа. Ер нь бол зүгээр таны хэлж байгаагаас би бол эсрэг саналтай байр суурьтай байгаа юм.

Анхан шатанд энэ улс төржилтийг багасгах суман дээр, аймаг дээр, дүүрэг дээр, нийслэл дээр давхар нэр дэвшдэггүй энэ байдлыг 1 дүгээрт одоо давхар нэр дэвшдэг энэ байдлыг буюу давхар улс төржилтийг зогсоох нэг гол асуудал байгаа юм.

Дараагийн гол асуудал бол ерөөсөө энэ Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль нэлээдгүй дэвшилттэй хууль болсон. Та бид бүгдээрээ маш сайн хууль болсон гэж үзэж байгаа. Маш сайн хууль гэдэг нь юугаар тодорхойлогдож байна гэвэл энэ сонгуулийн тухай хуульд зааснаар зардлын хэмжээг даруй 2 дахин буюу 50-аас дээш хувиар багасгаж байгаа. Ухуулагч нарын зардал мөн самбарын зардал гэх мэтчилэн орон нутгийн сонгуульд, Их Хурлын сонгуульд нэр дэвшигч нарын энэ зардлыг бас багасгах энэ концепцтой бас орж ирснийг танд хэлэх нь зүйтэй байх гэж ингэж бодож байна.

**Г.Занданшатар:** Жамбын Батсуурь гишүүн тодруулж асууна. Нэг минут.

**Ж.Батсуурь:** Бат-Амгалан гишүүн одоогоор аймаг, сумын иргэдийн хуралд давхар нэр дэвшдэг зүйл бол одоо энэ хууль нь үйлчилж байгаа хуульд байхгүй ээ. Тэгээд ч одоо энэ орон нутгийн төсвөөс явдаг, орон нутаг анхан шатын сонгууль бол тийм ч их зардал гараад байдаг зүйл биш.

Өнөөдөр 1992 оноос хойш 8 удаагийн сонгууль хийсэн. Орон нутагт 7 удаагийн тохиолдлыг бид нар туршиж үзсэн.

Өнөөдөр та нар энэ хуулийг батлуулах замаар 1992 оны хууль руу оруулах гэж байгаа юм. Яагаад вэ гэхлээр аймгийн иргэдийн төлөөллийг ард иргэдээс нь сонгодог энэ зарчмыг болиулах гэж байгаа юм. 1992 онд яадаг байсан юм гэхлээр сумын иргэдийн хурлаас аймгийн иргэдийн хурлыг сонгох ийм төлөөллийн зарчмаар энэ сонгуулийг хийж байсан. Тэр үр дүнгүй гээд дараагийн 7 удаагийн сонгуулийг хийсэн. Гэтэл өнөөдөр зардал гэж.

**Г.Занданшатар:** Энхтайваны Бат-Амгалан. Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга эрхлэгч Нямаагийн Энхболд дарга.

**Н.Энхболд:** Мэдээллийг жоохон залруулах талын тайлбар хийе. Энэ хуульд бол зөвхөн Орон нутгийн сонгуулийн тухай хуулийг хэзээ батлах вэ гэдэгтэй холбоотой л асуудал байгаа. Түүнээс Батсуурь гишүүний яриад байгаа шиг 1992 онд баталсан хуульд заасан эрхийг орон нутгаас булааж авах, хурлыг нь байхгүй болгох нэг ч үг үсэг элдэв юм байхгүй, 1 дүгээрт байхгүй.

Хоёрдугаарт, Орон нутгийн сонгуулийн хуульд нь өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хаана ч байхгүй байгаа. Засгийн газар дээр яригдаж байгаа гэж мэдээлэл байгаа. Улсын Их Хуралд орж ирээгүй байгаа. Тэндээс ямар төсөл орж ирэхийг бол бид нар мэдэхгүй байна. Зүгээр Батсуурь гишүүн ямар хаанаас юу харчхаад одоо энэ орон нутгийг эзгүйдүүлэх гэж байна, хурлын эрхийг байхгүй болгох гэж байна гэж яриад байгааг би лав мэдэхгүй байна. Байнгын хороон дээр ийм асуудал яригдаагүй. Энд бол зөвхөн Орон нутгийн сонгуулийн тухай хууль.

**Г.Занданшатар:** Хууль санаачлагч, тодорхой хариулчих. Энэ өөр хуультай нөгөө сургаар биш, судалгаатай ярихгүй бол. Энэ тийм нэг хуулийн сураг сонсогдсон гээд. Энэ хуульд тийм заалт

байхгүй юм байна лээ уг нь. Тэр Бат-Амгалан хууль санаачлагч, бас давхар нэмээд хэлчих, 2 талаас ойлгох уу.

**Э.Бат-Амгалан:** Өнөөдрийн Улсын Их Хурлаар өргөн барьж байгаа энэ хуульд бол ерөөсөө 1 жилийн хугацааг 6 сар болгож өөрчлөх энэ хуулийн төсөл орж ирж байгаа шүү дээ. Батсуурь гишүүн ээ. Өөр яг таны ярьж байгаа шиг аймаг нийслэлийн хурлыг байхгүй болгох ийм заалтууд байхгүй ээ. Сая хуулийн төслийн танилцуулга дээр хүртэл та сонссон байх.

**Г.Занданшатар:** Жамбын Батсуурь гишүүн тодруулж асууя.

**Ж.Батсуурь:** Нэг жилийн дотор өөрчилж болохгүй гээд хуульд заачихсан байхад тэрийг 6 сарын дотор өөрчилж болгоно оо гэсэн. Энэ хууль өргөн барина гэдэг чинь тухайн хуулийг өөрчилнө гэсэн үг. Та нарыгаа нэг мэдэлгүй яах вэ дээ. Эхэлж угтвар нөхцөлийг нь хангачхаад тэгээд гуя дагаж хүзүү оруулж ирэх гэж байгаа гэдгийг чинь ганцхан би ч биш Монголын ард түмэн бүгдээрээ харж байгаа. Хэдхэн хоногийн дараа өргөн баригдах хуульд энэ санаанууд орж ирнэ гэдгийг ажлын хэсэг олон энэ зүйлүүдийг мэдэж байна. Тийм учраас та бүхэн энэ хуульд нэг жилийн дотор энэ хуулийг өөрчилж болохгүй гээд заачхаад байхад чинь болгодог ийм хууль өөрчилнө гэдэг чинь хуулийн аргаар хуулийг хулгайлдаг энэ арга барилаасаа болиоч ээ л гэж хэлж байгаа юм.

**Г.Занданшатар:** Үг хэлээд байна. Нямаагийн Энхболд Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга хариулъя. Тодруулга асуулт асуусан.

**Н.Энхболд:** Энэ бол сая хууль санаачлагч хэллээ. Батсуурь гишүүн ч өөрөө мэдэж байна. Ерөөсөө 1 жилийн өмнө өөрчлөлт оруулж болохгүй ээ гэснийг 6 сар болгож байгаа юм. Тэгээд энэний цаана бас Байнгын хороон дээр

байсан хууль санаачлагчдын зүгээс гарсан тайлбаруудыг сонсоход яг таны санаа зовоод байгаа шиг хэрэв үнэхээр тийм хууль орж ирэх гэж байгаа бол тэрийг одоо өнөө маргааш хоёр, гуравхан хоногийн дотор хэлэлцээд буцаж болохгүй. Ер нь ямар ч заалт орж ирсэн.

Тэгэхээр энийгээ хэдүүлээ тал талаас нь ярья санал бодлыг нь сонсъя иргэд сонгогчдоос асууя. Орон нутгаас энэ юу саналуудыг нь авах энэ бололцоог нь бүрдүүлэх гэж л хугацааг нь хугацааг нь хойшлуулж байгаа юм. Түүнээс одоо таны ярьж байгаа шиг эрхийнхээ дагуу хардаж байгаа шиг юм хийе гэсэн бол нээрээ тийм хууль орж ирэх гэж байгаа бол өнөөдөр орж ирээд л маргааш юм уу нөгөөдөр батлаад явахад аягүй бол таны хардаж байгаа шиг тийм хууль гарахыг бас үгүйсгэх арга байхгүй. Тэгэхээр энэ.

**Г.Занданшатар:** Салдангийн Одонтуяа гишүүн.

**С.Одонтуяа:** Тэгэхээр энэ маш чухал хуулийн талаар ярьж байна. Би сая энэ хавар 6 дугаар сард, намар 9 дүгээр сард энэ ард иргэдтэйгээ уулзлаа л даа. Тэгэхээр яг одоо энэ хуультай холбоотой маш их гомдол иргэд саналаас ирж байна. Жишээлэхэд манай БГД гэхэд одоо 8 сар Засаг даргагүй байж байх жишээтэй. Яагаад Засаг даргагүй болсон юм бэ гэхээр энд нөгөө орон нутгийн өөрөө удирдах ёс алдагдсан байна. Хороон дарга нар 3-аас 4 удаа солигдсон байна. Хороон дээрээ ажил мэддэг хүн байхгүй. Уг нь бол энэ хуулиар хорооны иргэд нь өөрсдөө хуралдаад хороон даргаа сонгодог. Гэтэл одоо яаж байна гэхээр нэг ч хороон даргыг иргэдээс нь сонгохгүй дээрээс нь босоогоор томилдог. Ингээд үүрэг гүйцэтгэгч гэсэн ийм нэр өгөөд дандаа дээрээс нь намын дарга нар нь томилж байгаа.

Тэгэхээр энэ үүрэг гүйцэтгэгч нар яадаг юм бэ гэхээр ажилдаа ирэхгүй байна, дүүрэгтэй холбоотой, хороотой



холбоотой иргэдийн гомдлыг авч шийдвэрлэх боломжгүй байна. Ямар ч эрх мэдэлгүй байна. Тэгээд ажилдаа ирэхгүй ингээд маш их олон иргэдийг хохироож байгаа ийм юм гарч байгаа. Манай БГД-ийн бүх хороон дээр шүү бүх хороон дээр. Би бас БГД-ийн Засаг даргаар ажиллаж байсан юун 8 сар энэ чинь даргагүй байх байтугай 8 өдөр ажилдаа очихгүй байна гэдэг бол аймшигтай асуудал шүү дээ. Энэ чинь дүүргийн даргын асуудал гэдэг бол том жижиг маш олон асуудалтай.

Тэгэхээр энэ орон нутгийн энэ хууль дээр бид нар маш болгоомжтой хүрэх ёстой юм. Сайжруулах гэж байгаа нь энэ гээд ёстой нөгөө нуухыг нь авах гэж байгаа нь нүдийг нь сохолчих вий гэж бид нар цөөнх дандаа айдаг болсон. Тэгэхээр одоо орон нутгийн өөртөө удирдах ёс гэж ер нь байхаа больчихож. Засаг даргын шийддэг юм бараг байхгүй болох гэж байна шүү дээ. Боловсрол босоо, нийгмийн халамж бүх юм ингээд босоо тогтолцоотой болчихсон.

Тэгэхээр энэ хуулийг бид нар маш болгоомжтой харилцах ёстой юм гэдгийг хэлэх гэсэн юм.

Дээрээс нь өнөөдөр ингээд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуралдах гэж байгаа юм байна. ингээд бас орон нутгийн эрх мэдлийг бас ингээд шууд дээрээс нь дандаа Засгийн газраас шийддэг байдлыг иргэд маш их эсэргүүцэж байгаа. Улаанбаатарынхаа даргыг өөрсдөө сонгодог больё, дүүргийн Засаг даргаа өөрсдөө сонгодог больё гэдэг энэ асуудлуудыг ярьж байгаа. Жишээлэхэд одоо өнөө өглөө босоод ирэхэд л сошиалаар дүүрэн энэ агаарын бохирдолтой холбоотой асуудлуудыг иргэд асуусан байна шүү дээ. Тэгэхэд энийг хэн ч хариулж чадахгүй байгаа байхгүй юу. Хэн хариулах ёстой юм, эзэн байхгүй энэ улсад эзэн байна уу ер нь. Ийм ийм учраас өнөөдөр агаарын чанар ингэж ингэж алдагджээ. Уучлаарай энд ийм аваар осол гарчээ. Энийг тэдэн цагийн

дотор засах гэж ажиллаж байна гэдэг ч юм уу ингээд иргэдэд мэдээлэл өгөх хэрэгтэй шүү дээ.

Дээрээс нь угаартаж нас барсан хүний тоо тоймоо алдсан. Энийг бол дандаа нуун дарагдуулдаг. Энийг хаанаас яг зөв тоо олох вэ гэдгийг бол мэдэхэд маш хэцүү болсон. Энэ улсад ерөөсөө үгээ чөлөөтэй хэлэх нөгөө Ардчилал ил тод байдал гэдэг юм чинь байхгүй болсон. Энэ орон нутгийн хууль дээр бас би зүгээр нэг зүйлийг Улсын Их Хурлын сонгуулийн хуульд оруулах гээд дийлээгүй юм л даа. Энэ юу вэ гэхээр одоо яадаг вэ гэхээр энэ орон нутгийн сонгогдсон дүүрэг, аймаг сумын төлөөлөгч чинь юу ч хийхгүй байж байгаад л тэгээд 1 сонгууль дөхөхөөр баахан бэлэг сэлт тараадаг, баахан шинэ жил, март, цэргийн баяр тэмдэглэдэг. Энийг нь бол энэ хуулиар бүгдийг нь хориглох хэрэгтэй. Зөвхөн сонгуулийн жил биш.

Би энийг Тогтохсүрэн даргад бас Сонгуулийн хууль хэлэлцэж байхад хэлсэн л дээ. Тэгээ Тогтохсүрэн дарга бол энийг бас энэ нэг Орон нутгийн хууль, Улсын Их Хурлын хууль ярихад бас хэлэлцье, ярилцъя. Бас зөв зүйтэй саналууд байна.../минут дуусав/.

**Г.Занданишатар:** Үг хэлчихлээ Цэвэгдоржийн Туваан гишүүн.

**Ц.Туваан:** Энэ бас аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль гээд. Энэ тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэгтээ бас л Улсын Их Хурлын гишүүнийг сонгохтой адил өөрсдийнхөө төлөөллийг сонгох ийм чухал хууль. Тэгээд энэ хуулийн хугацааг сунгах гээд орж ирж байна. Хугацааг сунгах гэж байгаа чинь дараа нь өөрчлөлт энэ саяын гишүүдийн хэлээд байгаа хардаж асуугаад байгаа өөрчлөлтүүдийг хийнэ ээ л гэсэн үг шүү дээ. Тэрийг хийхгүй юм бол энэ хугацаа ч сунгах ийм шаардлага байхгүй ээ. Тэгэхээр энийг яг тухайн үед нь бас энэ Их Хурлын

сонгуулийн тухай хууль энэ тэрийн үед ядаж хэлэлцэж эхлээд яахгүй. Яг ингээд цагийг нь тулгаж орж ирээд л тэгээд л цаг хугацааны ийм хайчинд оруулаад ингээд сунгах гэж байгааг би бол дэмжихгүй байна. Энэ орон нутагт чинь яг энэ маш их асуудлууд байгаа үнэн. Одоо энэ бид нарын өмнө нь баталсан энэ нэгжийн тухай хууль гээд ярьж байгаа энэ хууль. Энэ хууль дээр орсон өөрчлөлтүүдээс чинь амьдралд сумын иргэдийн хурал дээр, багийн иргэдийн хурал дээр маш их саад болж байгаа тэр тэргүүлэгчдийг байхгүй болгоод тухай тухайн үед нь дарга нарыг сонгож хуралдуулна гээд.

Дарга хийж сонгогдох хүн байхгүй. Асуудлаа яг аваад яваад шийдээд гарчих ийм асуудал байхгүй болоод гацаанд орсон ийм асуудал байна. Тэгэхээр энэ зүйлүүдээ бид нар бас урьдчилж яг энэ хуульд өөрчлөлт оруулах гэж байгаа шиг биш анзаарч шийдмээр байгаа юм. Тэгээд энэ хууль дээр мэдээж хугацааг нь 6 сар болгоод оруулаад ирэхээр 6 сар нь дөхөөд ирэхээр орон нутгийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулна. Ийм ийм заалт гээд мэдээж яригдах байх. Тэгэхээр яах вэ энэ дээр бас одоогоор бол нөгөө хугацаа сунгах гэж байгаа учраас яг тодорхой орсон зүйл байхгүй байх л гэж ингэж ярих байх. Зүгээр бодсон зүйл бол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиа бид нар энэ холимог тогтолцоотой болгоод ингээд явчихсан.

Тэгэхээр энийгээ бас президент болгоод орон нутгийн сонгууль руу, Сонгуулийн хууль руу буулгах юм уу яах юм. Хүмүүс асуугаад байна шүү дээ. Их Хурлаа ийм болгочоод аймаг, нийслэл, сум, дүүргээ яах юм бэ? Энэ чинь бас нэг улс юм бол ингээд нэг зарчмаар ингэж явдаггүй юм уу гэж маш олон хүн асууж байна.

Хоёрдугаарт энэ орон нутгийн сонгуульд энэ төрийн байгууллагууд оролцдог асуудлуудыг бид нар дараагийн

удаад ярих нь зүйтэй. Цагдаагийн байгууллага тэгээд одоо бас энэ захиргааны, сумын Тамгын газрын ажилтнууд, босоо тогтолцоотой агентлагууд гээд бүгд оролцоод л сонгуульд оролцоод л явчихдаг. Энэ асуудлыг нь хааж тэнд улс төржилтийг багасгах тал руу асуудлыг нь шийдэх хэрэгтэй. Нөгөө талаараа тэр улсуудаа ч гэсэн тайван амгалан ажлыг нь хийлгэмээр байгаа юм. Тэр улсуудад улс төрийн хараат байдлыг нь бас бууруулах ийм шаардлага байгаа юм аа. Зардлын тал дээр бол хэн ч дэмжих байх. Энийг бол ер нь дэмжихгүй бол ер нь бас л Улсын Их Хурлын сонгууль гэлтгүй орон нутгийн сонгууль бол дутахгүй л мөнгөний сонгууль болж байгаа юм. Телевизээр самбарт тэгээд ухуулагч шадар туслагч авахаас өгсүүлээд энэ юмаа бас бууруулаад энэ зардал бууруулах тал дээр нь бүүр дорвитой арга хэмжээ авах нь дээр байх гэж ингэж ойлгож байгаа юм. Би бас Батсуурь гишүүнтэй адилхан мэдээлэлтэй байгаа. Тэр нь юу вэ гэхээр нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг бол дүүргээс нь сонгох юм байна аа.

Аймгийн иргэдийн Хурлын Төлөөлөгчийг сумаас нь сонгох юм байна гэдэг асуудал яригдаж байгаа юм байна. Яригдаж байна гэдэг чинь байна л гэсэн үг. Тэгэхээр энэ нийслэлийн иргэдийн гол асуудлыг шийддэг Нийслэлийн иргэдийн Хурал, аймгийнхаа асуудлыг шийддэг аймгийн иргэдийн Хурлын асуудал чинь нэг шат доошоо буух юм байна шүү. Тэгэхээр энийг дараа хууль санаачлагчид бас анхаарна биз ээ гэсэн.

**Г.Занданшатар:** Үг хэлчих вүү?

Норовын Алтанхуяг гишүүн асуулт асууя.

**Н.Алтанхуяг:** Энэ Монгол Улсад энэ ардчилал гэдэг юмнаасаа ч ухраад яваад өглөө л дөө. Би та нарт нэг жишигээ хэлж өгье. Энэ ялангуяа Сонгуулийн

хуулийг батлах хугацааг хойшлуулна гэдэг бол ардчиллаас мянган алхам ухарч байгаа юм. Энэ яах вэ гэхээр хэн нэгэн эрх барьж байгаа нь цагийг нь тулгаж байгаад өөртэйгөө ашигтай хуулийг батална л гэсэн үг. Би яаж өөрчлөх гэж байгааг нь мэдэхгүй байна л даа. Өнөөдөр та нарын ярьж байгааг сонсоход янз янзын санаа хэлж байна. Ер нь бол энэ Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн дагуу бусад хуулиуддаа өөрчлөлт оруулах ажлыг бол манай энэ эрх баригчид хийх ёстой юм аа. Та нарын ажлаа хийгээгүйн төлөө энийг 6 сараар ухраадаг ийм юм баталж болохгүй ээ, Энхболд дарга аа. Энэ дотор бас нэлээн олон жил явсан нь та бид 2 байх.

Та бид 2 одоо Мах комбинатын улаан ямаа болж ийм юм ингээж санаачилж, ингээж хийж болохгүй. Энэ ардчиллаас ухарсан алхам дөнгөж саяхан болсон юмыг би хэлээд өгье. Улсын Их Хурлын сонгуулийн хуулийг нэг жилийн дотор гар хүрч болдоггүй байсныг 6 сар болгосон. Дараагаар нь амьдрал дээрээ яасан гээч дараагаар нь ҮХЦ-д өгч байгаад 2 сарын өмнө Сонгуулийн хуульд өөрчлөлт оруулсан. Энэ маш буруу юмны жишгийг ингээд нээгээд өгчихсөн ингээд яваад байгаа. Энийгээ засчхаж болохгүй юм уу?

6 сараар ерөөсөө сунгаж болохгүй. Хэрвээ та нар ажлаа хийж чадаагүй байна гэх юм бол сарын дотор батлах хэрэгтэй. Энхболд дарга та хар л даа. Одоо 6 сараар сунгахаар би ингээд багцаалах нэг хаврын чуулган эхлэхэд энэ хуулийг батлах юм байна. Хаврын чуулган эхлэхэд сонгуулийн уур амьсгал орчихсон. Яаж тухтай хууль батлах вэ дээ.

Тэгэхээр энэ бол ийм ардчиллаас ухарсан нэг нам өөрөө дахин дахин ялахын тулд хуулиа өөрчилж байгаа хоорондоо нөгөө өрсөлддөг аргаа өөртөө ашигтайгаар өөрчилж байгаа хэлбэр гэж би үзэхээс өөр арга алга. Би хэллээ шүү. Та нар одоо жишээ нь Үндсэн хуульд

өөрчлөлт оруулаад байгаа юм. Бүүр тэрний өмнөх өөрчлөлтийн дагуу Эрдэнэт хот Дархан хотын тухай хуулийг батлах ёстой. 4 жил өнгөрлөө батлахгүй байна. Яагаад тэгээд Үндсэн хуульд өөрчлөлт оруулаад байгаа юм бэ? Үндсэн хууль зөрчиж Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулдаг тэгсэн мөртөө тэр өөрчлөлтөө хийдэггүй. Одоо 6 сараар хойш нь шидчихье сүх далайтал үхэр амар. Хавар 4 сард юу ч болох юм билээ ингээж болохгүй ээ. Ингээж энэ 1990 онд Монголчуудын хүсээж хүлээж олж авсан ардчилсан энэ ах алхмуудаас ингээж хуульд хулгай хийх замаар хуулийн хугацааг сунгах замаар хулгай хийх замаар ингээж өөрчлөлт оруулж болохгүй. Би хатуу хэлж байна шүү. Энэ нээрээ яагаад ингээж байгаа юм бэ? Би энэ үнэхээр ойлгохгүй байна. Болохгүй шүү дээ жил байсныг 6 сар болгосон 6 сар чинь тэгээд цагаа тулаад юу ч биш болно оо.

Гэдэс дотор нь ороод яах вэ? Та нар янз янзын санаа гаргаад маргаж байх шиг байна. Ер нь бол Үндсэн хуульд орсон өөрчлөлтийг чинь дагаж сонгуулийн систем чинь бас өөрчлөгдөх л учиртай юм л даа.

Төгсгөлд нь би нэг санаа хэлчихье. Одоо та бүхэн жаран хэд дахиад хулгай хийх гэж байгаа бол энэ Улсын Их Хурлын сонгуулийн хуулийг ямар тойргоор явуулах чинь тодорхойгүй байгаа. Тэр хууль чинь бас орж ирээгүй. Тэгээд цагийг нь тулгаад тойргоо жижижгэдэг янз бүр болгодог энэ хулгайг дахиад хийх гээд ингээд сууж байгаа. Одоо ингээд хулгайч гэдэг нэрээр нь бид нараас салахаа болилоо шүү. Энэ Улсын Их Хурал гэж байх юм бол нэг жаахан замбараатай хууль ном, Үндсэн хууль элдэв юмаа сахиад жаахан ажлаа хиймээр байна. Тэгэхгүй юм бол больсон нь дээр.

**Г.Занданшатар:** Хариулт хангалтгүй нэмэлт авна. Нямаагийн Энхболд гишүүн.

**Н.Энхболд:** Энэ хуулийн төслийг Улсын Их Хурлын нэр бүхий 5 гишүүн тэр тусмаа яг орон нутагт Засаг даргаар ажиллаж байсан тэр ажлынхаа онцлогуудыг сайн мэддэг ийм гишүүд санаачилсан юм. Байнгын хороо тэр миний зүгээс санаачилсан юм байхгүй. Тэрний дагуу хэлэлцээд олонх нь ер нь энэ хугацааг нь ингэхгүй бол болохгүй байна гэдэг ийм дүгнэлтэд хүрээд л Байнгын хорооны санал дүгнэлт гарсан.

Зүгээр Алтанхуяг гишүүний санаа зовж байгаа нэг зүйл дээр би бол хувьдаа манай Байнгын хороон дээр ярилцсан нэг байр суурь юу вэ гэхээр энийг хойтонгийн 4 сар хүргэх гээд байгаа юм ерөөсөө байхгүй. Бид нар болж өгвөл төсөвтэй учиргүй их давхцаад байхгүй, аль болохоор түргэн энэ ондоо багтааж баталчихсан байх ёстой л гэсэн ийм байр суурьтай байгаа. Хууль нь орж ирээгүй байна. Орж ирэх хууль дотор ямар санаанууд яг бичигдэж орж ирэхийг би мэдэхгүй байна гэж түрүүн хэлсэн. Гэхдээ жишээ нь сая Туваан гишүүний хэлсэн үг дотор гарч байна лээ л дээ. Орон нутгийн сонгууль таны үгэнд ч гарлаа. Адилхан холимгоор байх уу яах вэ гэдгээс эхлээд асуудлууд гарна гээд. Тэгэхээр энэ юмнуудаа л тал талаас нь сайн хэлэлцье гэж л энэ хугацааг нь түр хойшлуулаад тэгэхдээ хурдхан шиг баталъя гэсэн ийм л байр суурьтай байгаа. Байнгын хороон дээр ч ингэж яригдсан. Саяын яг тодорхой асуудлуудын хувьд бол би бас сая орон нутгаар нэлээн явсан хүмүүстэй уулзсан. Их Хурлын сонгууль бусад асуудлаар ярьж байхад мэдэхгүй надад таарвал тэгж хэлсэн юм уу, эс үгүй бол янз бүрийн л хүмүүстэй уулзсан. Аль аль намын хүмүүстэй л уулзсан. Энэ зүгээр миний сонссоноо л ярьж байгаа юм шүү. Түүнээс миний байр суурь биш. Орон нутагт, хүмүүсийн дийлэнх нь за даа орон нутгийн сонгуульд ч жагсаалт бараг хэрэггүй биз дээ. Урьд нь бид нар ингэж хийж үзсэн. Тэгээд энүүгээр бодоход бол хурал их тэр хүмүүсийн л үг шүү, онцгүй бүрдэж байсан шүү гэсэн ийм яриатай байсан.

Тэгээд тэр тал талаас гарч байгаа саналуудыг л бид нар хууль хэлэлцүүлэгтээ ярина шүү дээ. Би бол сая зүгээр нэг өөрийн авсан дийлэнх олонхоос ярьж байсан нэг л асуудал дээр байж байна. Гэх мэтчилэн юмнуудаа хэдүүлээ их сайн ярих хэрэгтэй байгаа юм.

Тийм учраас хэдүүлээ бага ч гэсэн цаг хэрэгтэй байгаа. Түүнээс 4 сар 5 сар хүртэл энэ явахгүй ээ болохгүй ээ. Тэрний улс төрийн үр дагаврыг нь бид нар ойлгож байгаа.

**Г.Занданшатар:** Норовын Алтанхуяг гишүүн нэг минут.

**Н.Алтанхуяг:** Энхболд дарга та бид 2 сууж байгаад ийм юм хийлгэж болохгүй ээ. Энэ зүгээр сагасан, дараачийн сонгуульд дахиад гарчихна гэсэн энэ ард түмний итгэл найдвар бүх юмыг уландаа гишгэсэн ийм амьтдыг би лав дэмжихгүй, та ч бас дэмжихгүй байх хэрэгтэй. Та наад ямар амаараа яриад байгааг би мэдэхгүй байна б сараар сунгана гэж оруулж ирчхээд тэгээд нөгөө амаараа болохоор оны дотор батална. Тэгвэл оны дотор батална гэж хий л дээ. Та нар боль л доо. Ингэж болохгүй шүү дээ энэ улс орноороо тоглохоо боль л доо. Дахиад тэгээд энэ ер нь сонгууль гэдэг дээр 3 юм хэдүүлээ ярих ёстой тогтолцоо.

Та нар Үндсэн хуульд өөрчлөлт оруулсан. Хоёр дахь нь зардал мөнгийг хэмнэе. Одоо үндсэндээ энэ залуучуудаас хэн нь ч сонгуульд нэр дэвших эрхгүй болчихсон шүү. Энэ зардлыг чинь дийлдэг хүн байхгүй. Хэдэн хулгай хийсэн мөнгөтэй амьтад л нэр дэвшдэг болсон.

Гурав дахь нь хар машинаа яг ингээд ил харуулаад одоо энэ техник хөгжчихсөн байна. Саналын хуудас нэг бүрийг олон нийтэд харуулж тоолдог ийм нээлттэй тооллого гэж би томъёолчихоод байгаа. Тэгээд ийм ийм жаахан.

**Г.Занданшатар:** Үг хэллээ.

Санал хураалт явуулна.

Хэлэлцэх эсэхийг шийднэ.

Тэрний өмнө дэмжсэн дэмжээгүй үг хэлэх хүн байна уу гэж асуухаар.

Санал хураалт явуулна. Санал хураалт явуулахын өмнө санал хураалтыг дэмжсэн дэмжээгүй үг хэлнэ. Энэ хооронд үгүй ээ ярьж байхын оронд та Ганбат гуай таныг ер нь хурлын дэг удаа дараа зөрчиж байгааг чинь зүгээр үг хэлүүлээд байхад чинь үг хэлэх хооронд л бачимдаад л, сандраад л, тэвдээд л. Түрүүн та ингээд үг хэлье ээ гэхэд чинь дараа нь үг хэлүүлнэ гэж хэлсээр байхад чинь. Ингээд больсон нь дээр больсон нь дээр ээ.

Дэмжсэн, дэмжээгүй 3 хүртэл үг хэлж болно. Санал хураалттай холбогдуулж үг хэлэх гишүүн байна. Ингээд дэмжсэн дэмжээгүй 3 хүртэл үг хэлнэ. Жамбын Батсуурь, Тогтохсүрэн, Дашидондогийн Ганбат, Наянтайн Ганибалаар тасаллаа. Жамбын Батсуурь гишүүн.

**Ж.Батсуурь:** Сүүлийн үед судалгааны байгууллагууд, төрийн бус байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, энэ Монгол Улс ардчиллын индексээрээ дэлхий дээр огцом ухарч байна гэсэн энэ зүйлүүдийг байнга яригдаж байгаа. Энэний гол амин сүнс сонгуулийн ардчилал байх ёстой. Сонгууль ер нь ардчилсан орны гол илтгэх зүйл бол олонхын саналаараа л төр барьдаг шат шатынхаа төрийг барьдаг байх ёстой. Гэтэл нөхцөл байдал шал өөр болж ирж байгаа. Энийг бид нар хүч дийлэхгүй байгаа арваннэгүүлэхнээ. Үндсэн хуулийг яаж өөрчиллөө. Их Хурлын сонгуулийн хуулийг яаж өөрчиллөө. Зардлыг яаж багасгана гэж донгodoж байлаа.

Өнөөдөр улсын төсөв дээр яаж орж ирж байгааг бид нар бүгдээрээ харж байгаа. Тэгээд хүнд таалагдахын тулд өргөн барихдаа заавал мөнгөтэй холбож ярьдаг. Зардлыг нь багасгаж байна. Хэдэн самбар ч гэх шиг. Яг үнэндээ хуульд тухайн хуулиудыг хэлэлцэж байхад үнэхээр нэг жилийн өмнө энэ хуулиудыг өөрчлөхгүй бол нэг жилийн дотор бол өөрчилж болохгүй ээ. Сонгуулийн уур амьсгал орчихно оо. Нийт хүмүүсийн санаа сэтгэл өөр болчихно оо.

Тийм учраас энийг цоожилж байгаа шүү дээ. Энэ цоожийг тусгай эрх мэдлийн түлхүүр гаргаж ирж нээгээд ингээд 6 сараар, хагас жилээр өөртөө дуртай нөхцөл байдлуудаар дуртай хуулиа батлуулдаг энэ бол ардчиллын зарчмаас үнэхээр ухарч байна. Биднийг зөвхөн та бид бие биеэ харж байгаа биш олон нийт харж байгаа. Олон улс харж байгаа. Мөд Монгол Улс сонгуульгүй болох юм байна. Сонгуульгүй болох юм байна. Мөд ер нь дунд шат гэж байхгүй болох юм байна. Анхан шат гэж байхгүй болох юм байна. Та бүхний салбаруудын хуулиудыг харахад өнөөдөр Боловсролын хууль гарч ирээд Боловсролын сайд боловсролын чиглэлийн бүх томилгоог мэддэг болсон. Бүх мөнгийг нь мэддэг болсон. Байгаль орчин газар гээд бүгд шат дараалаад хүлээж байна. Нөгөө орон нутагт, дунд шатанд, анхан шатанд цонхны хагархайг Сангийн сайд мэддэггүй болъё гээд уран донгodoод байсан зүйлүүд юу болов. Өнөөдөр томилгоогоор дамжиж л бүх эрх мэдлийг татаж авч байгаа юм, томилгоогоор давтаж.

Тийм учраас энэ хуулийг хэрхэвч 6 сараар сунгаж болохгүй ээ. Ингээж хуульд өөрчлөлт оруулах замаар хуулийн хулгай хийдгээ боль оо. Энэ бол ганцхан одоо орон нутгийн сонгууль дээр ч гарч байгаа зүйл биш харагдаж байгаа зүйл биш. Үндсэн хуулийг ингээж хийсэн Их Хурлын сонгуулийн хуулийг ингээж хийсэн бусад хуулиудыг ч өөрчилж болохгүй гэсэн заалтуудыг өөрчилж болгодог. Хууль

батлах замаар хуулийн баталгаа хийж байна. Та бүхэн ноднин Төсвийн тухай хуулийг батлахад төсвийн тухай дагасан хуульд Шадар сайдын орон тоо оруулаад л ирж байсан шүү дээ. Хүмүүс гуя дагаж хүзүү гэдэг юм билээ. Та бүхэн дандаа хүзүү дагаж гуя хийж байгаа шүү дээ. Хүзүү дагаж гуя хийж байгаа. Тийм учраас аливаа зүйлийг бага дээр нь болих хэрэгтэй.

Энхболд гишүүн гараад явчхаж байна. Төрийн байгууллагын байнгын хороо. Сая Энхболд гишүүнийг Алтанхуяг дарга гуйж байна. Үнэхээр зургаа сонгогдсон нь үнэн. Энэ парламентад 24 жил суусан нь үнэн юм бол энэ сонгуулийн тогтолцоог хадгалъя цаашид бас ардчилсан орон байя гэж бодож байгаа энэ хуулийг хийж болохгүй ээ болохгүй. Би та нарын хүзүү дагаж гуя орж ирэхийг чинь аль хэдийн мэдэж байна, мэдэж байна.

Тийм учраас орон нутгийг санхүүгийн эрх мэдэлгүй болгож байна. Томилгооны эрх мэдэлгүй болгож байна. Одоо ард иргэдийг сонгох эрх мэдэлгүй болгоно оо гэдэг өөрөө энэ ардчилсан Монгол оронд байж болохгүй үзүүлэлт ээ. Ер нь хөдөөд Дарханд сууж байгаа ард иргэдийн төрд оролцож байгаа ганцхан боломж бол сонгууль байгаа. Багийн даргаа сонгох, сумын иргэдийн хурлаараа дамжиж сумын даргаа сонгох. Аймгийн иргэд нь аймгийн иргэдийн Хурлын Төлөөлөгчдөөрөө дамжиж аймгийн даргаа сонгодог зарчмыг та нар болиулж байгаа шүү дээ бараг. Тэр Ховд аймаг бусад аймгуудыг хар.

Дээрээс томилдог болчихсон дээрээс болиулдаг болчихсон. Энэ төвлөрсөн тогтолцоот үеийн социализмын үеийн одоо үйл ажиллагаанаас ялгарах юм юу байгаа юм. Гаднын орнууд Монгол Улсыг ардчилсан орон гэдгийг нь нэг сонгуулийн тогтолцоогоор нь сүүлийн итгэл найдвар байсан бол одоо энэ үгүй болж байна ийм

учраас энэ асуудлаа боль оо, савраа татаа, хуулиа татаж ав гэж хэлж байна аа. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн. Баярлалаа.

**Д.Тогтохсүрэн:** Тэгэхээр орон нутгийн сонгуулийн хуульд өөрчлөлт оруулах шаардлага үүсчихсэн юм Батсуурь гишүүнээ. Яагаад вэ гэхээр бид нар энэ жилийн Улсын Их Хурлын Сонгуулийн хуулийг батлахдаа хэдэн томоохон өөрчлөлт хийчихсэн. Энэ өөрчлөлтийг бид нар орон нутгийн сонгуулийн хуульд хийхээс өөр арга байхгүй ээ. Гэтэл орон нутгийн сонгуулийн хуулийг нэг жилийн өмнө өөрчилж болохгүй гээд 2020 онд баталсан. Энэ хуулийн өөрчлөлтийг хийж байж бид нар өөрчлөлтийг нь хийхгүй бол болохгүй байгаа юм. 10 дугаар сарын 15-нд сонгууль болсон юм байна лээ. Орон нутгийн сонгууль тэгэхээр нөгөөдөр юм уу, 2 өдрийн дараа дуусаж байгаа байхгүй юу нөгөө хугацаа нь. Гэтэл Орон нутгийн сонгуулийн хуульд чинь Батсуурь гишүүн өөр юм ярьж болохгүй л дээ. Зардал бууруулах зайлшгүй шаардлагатай байгаа, зардал бууруулах. Зардал бууруулах зайлшгүй шаардлагатай байгаа. Бид нар Их Хурлын сонгууль дээр зардал бууруулчихсан. Тэр олон орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдийг нэг самбартай байлгахгаас эхлээд энэ чинь зардлыг бууруулах хэрэгтэй байгаа шүү дээ. Сонгогчид бид нар энийг л хүсэж байгаа. Нэг хүйсийн төлөөллийг нэмэгдүүлнэ гээд бид нар орчихсон тэрийгээ нэмэгдүүлэх шаардлагатай. Орон нутгийн сонгуулийн хуульд чинь 20 хувьтай л явж байгаа шүү дээ. Нэг хүйсийн төлөөлөл чинь. Энийг нэмэгдүүлэх хэрэгтэй байгаад байгаа юм.

Улсын Их Хурлын сонгуулийг холимог тогтолцоонд оруулсан. Орон нутгийн сонгуулийг холимог тогтолцоо байх уу үгүй юу гэдгийг Их Хурал дээр ярьж хагалах хэрэгтэй болж байгаа. Энэ

мэтчилэнгийн бид нар энэ Улсын Их Хурлын Сонгуулийн хуульд орсон энэ зарим өөрчлөлтийг орон нутгийн сонгуулийн хуульд тусгах зайлшгүй шаардлага үүсчихсэн байхгүй юу. Одоо сонгууль боллоо гэж бодъё хуучин хуулиараа. Нэг хүйсийн төлөөлөл чинь 20 хувь байгаа шүү дээ. Тэгэхээр энийг чинь мэдээж зүгээр эмэгтэйчүүдийн бүлэг ч юм уу энийг эсэргүүцээд л эхэлнэ шүү дээ. Гэтэл оруулах зайлшгүй шаардлага байгаа байхгүй юу. Энэ үүднээс нь бид нар 6 сар гэдэг хугацаа болгох гээд байгаа юм аа.

Яагаад гэхээр би хэлчихлээ шүү дээ 10 сарын 15 дуусчхаж байгаа юм. Гэхдээ бид нар он гаргахгүй. 12 дугаар сарын 31 гэхэд Орон нутгийн сонгуулийн хуулийг хэлэлцэж баталж дуусгана гэдэг ийм л зорилттой байгаа. Тэгэхээр бид нар бол ийм хугацаанд шахагдчихсан учраас энэ 6 сар гэдэг энэ хуулийн төслийг манай Их Хурлын гишүүд өргөн барьж оруулж ирж байгаа юм аа. Тийм учраас бол Их Хурлын сонгууль, Их Хурлын сонгуулийн хуульд орчихсон, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр орчихсон тэр зарчмуудыг л бид нар сонгуулийн хуульд тусгая гэж гэж ингэж л үзэж байгаа асуудал байгаа юм.

Би сая эмэгтэйчүүдийн квотыг эхэлчихлээ шүү дээ гарц гарна гэж. Гэх мэтчилэнгийн ийм нэлээн олон асуудлууд байгаа зардал бууруулахтай холбоотой гээд. Тийм учраас бол энэ Сонгуулийн хуулийг дэмжиж өгөхийг та бүгдээс хүсье.

12 дугаар сарын 31 гэхэд бол Сонгуулийн хуулийг Орон нутгийн сонгуулийн хуулийг батална гэдэг ийм л чиглэлтэй явж байгаа.

**Г.Занданшатар:** Дашдондогийн Ганбат гишүүн.

**Д.Ганбат:** Би нэг үг хэлчихье. Энэ орон нутгийн сонгуулийн хугацааг нааш цааш нь болгох асуудлыг ярьж байх шиг

байна. Хуулийн тийм ээ тийм хуулийн хугацааг нааш цааш нь болгох асуудлыг ярьж байх шиг байна. Бид бүхэн бас энэ нэг юмыг нэлээн тийм үндсээр нь хармаар юм шиг байгаа юм. Нөгөө та хэд чинь ном уншдаг билүү үгүй билүү? Тэр эрэлхэг цэрэг Швейкийн хэлснээр бол асуудал яаж ч дордож байсан сайн тал руугаа явж байна гэж. Үнэхээр дордчихсон байгаа. Манай Улсын Их Хурлын гишүүд маань ялангуяа хотынхон маань иргэд дээрээ очих нүүргүй болчихоод байгаа л даа. Тэгэхээр энэ хууль дээрээ бас боломж гаргаад янзлаад үнэхээр хэрэгтэй өөрчлөлтүүдийг нь хийгээд ингээд явбал бас зөв байна аа.

Тухайлбал одоо дэлхий нийтийн жишигээр бол хотын иргэд нь хотынхоо даргыг өөрсдөө сонгогхож байна шүү дээ. Иймэрхүү зүйлийн өөрчлөлтүүдийг бид нар хиймээр байгаа юм. 21 аймгаа хот болгоод тэрэнтэйгээ уялдуулаад тэгэхгүй бол энд л бид нар улс төржих нь зөв гэж бодож байна. Би энэ Бат-Амгалан гишүүд энэ дээр оруулж ирж байгаа нь бас энийг нэлээн бодож байж өөрчилъе янзалъя гэсэн санаа оноо байгаа байх. Энийг дэмжээд манай нөхдүүдийн яриад байгаа тэр зөв зүйтэй өөрчлөлтүүдийг нэмээд ингээд бид нар ул сууриар нь аятайхан юм хийх хэрэгтэй. Ганцхан одоо нам ч улс төрч байр сууриас хандахаа больё. Тэр иргэдийнхээ, олон түмнийхээ, улс орныхоо хөгжлийн үүднээс хэдүүлээ харъя. Ганцхан улс төржих ганцхан тэр бодлогын шийдвэр гаргах нь бол Улсын Их Хурлын сонгууль л байг л дээ. Бусдыг нь больё.

Өнөөдөр орон нутгийн сонгуулиар сонгогдсон тэр хүмүүсийг тэр иргэдийн хурал, орон нутгийн байгууллага нь тавьж чадаж байна уу гэвэл үгүй л байгаа шүү дээ. Хууль амьдрал дээр хэрэгжихгүй л байгаа.

Тухайлбал би одоо тэгээд л ганц нэг аймгуудаас нэрийг нь дурдаад л яривал ярихаар л байна. Тэрийг бүгдээрээ л

мэдэж харж, барьж байгаа. Тэгээд тэр биелдэггүй, биелэгддэггүй хуулиудаа өөрчлөөд үнэхээр иргэддээ хэрэгтэй одоо олон улсын дэлхий нийтийн жишиг болсон тэр хуулиудыг нь баталъя. Тэгэхгүй бол баахан сонгуулиар олон сонгууль болдог. Баахан сонгуулиар улс төржөөд л ард нь иргэд маань хоцордог. Нөгөө орон нутгийн иргэд маань хоорондоо сумдаа, багтаа хамтран амьдардаг. Тэр нөхөд маань бүтэн жилийн хугацаанд тэр улс төржсөн уур амьсгалаасаа салж чадахгүй байна шүү дээ. Ерөнхийлөгчийн сонгуулийг бид нар 6 жилд нэг хийдэг болсон гэх мэтчилэнгийн сайн өөрчлөлтүүд, эерэг үр дүнгүүд байгаа. Тэгэхээр ийм зүйлүүдийг тусгаад явъя гэдэг санаа оноо байна. Энийг одоо хууль санаачилсан гишүүд бүүр ажиллах Улсын Их Хурлын гишүүд бид хэд анхаараад энэ Улсын Их Хурлыг би бас заримыг нь талархмаар байгаа юм аа.

Энэ 2020-2024 онд сонгогдсон манай Улсын Их Хурлын энэ танхим энэ сүүлийн 76 хэдийгээр муу хэлэгддэг боловч барьцаанд ороогүй Их Хурал байсан. 2016-2020 оны Их Хурлын гишүүд бол барьцаанд орчихсон байсан шүү дээ. ЖДҮ-ээрээ есөн жорын юмаараа.

Тэгээд л бараг нэг хүний дарангуйлал дотор л дохио зангаагаар бүх юмыг нь биелүүлдэг ийм л байлаа шүү дээ энэ 2 нам чинь. Занданишатар дарга аа Баянхонгорынхон эвтэй байвал энэ улс орон болчихно л гээд яриад байдаг. Гэхдээ манай Баянхонгорынхон бусад аймгийнхан шиг тэр хулгай зэлгийн дээрээ нийлдэггүй юм аа. Зарчмын асуудлаар бид нар санал бодол зөрөлддөг л дөө. Энэ зөв зүйтэй эерэг юм байгаа юм. Гэхдээ бас тань дээр л би бас халамж анхаарал тавиад байгаа шүү дээ. Буруу зөрүү юм хийгээд огцорчих вий гээд л айн. Энэ хэд чинь таньг өөгшүүлж байгаад л араас нь инээгээд л үлдэх хүмүүс ийм хүмүүс байгаа. Байхгүй ч байж магадгүй. Би одоо бас та илүү сайн мэдэж байгаа байлгүй дээ. Тэгэхээр би бас нутаг усныхаа хүнийг

Үндсэн хуулийн цэц дээр унагаагаад огцуулах тийм хүсэл ерөөсөө алга. Тэр талаас нь хандаж байгаа шүү. Та тэгээд буруу зөрүү ойлгоод айн бас ухаан санаа чинь яагаад байв даа.

Тэгээд хоёулаа дандаа л бие биеэ хараад л уурлаж байхаар хааяа бас нэг хошин шогийн мэдрэмжтэй улсууд. Та нар чинь IQ өндөртэй болоод сонгогддог юм байгаа биз дээ айн? Тийм тийм л хүмүүс сонгогдож таараа шүү дээ. Хэдийгээр муу хэлэгддэг боловч.

**Г.Занданишатар:** Би яах вэ энэ урдах асуудлаа л ярья. Анхаарал халамж тавьсан явдалд баярлалаа.

Зочид танилцуулъя Монгол Улсын Их Хурлын гишүүн Цэдэндамбын Цэрэнпунцаг, Балжиннямын Баярсайхан нарын урилгаар Завхан аймгийн Цагаанхайрхан сумын ахмадуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа.

Эрхэм хүндэт Завханчууддаа, ахмадууддаа Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх сайн сайхныг хүсэн ерөөе.

Санал хураалт.

Наянтайн Ганибал гишүүн үг хэлнэ.

Мөнх-Оргил гишүүн байсан дуудаарай.

**Н.Ганибал:** Өнөөдөр бид нар энэ парламентынхаа бас нэг түүхэнд эргээд л нэг хар мөр үлдээхээр л хууль оруулж ирж байна. Нэг л заалттай хугацаа өөрчлөх. Энэ хугацааг анх бий болгоход бас л энийг энэ хугацааг өөрчлүүлэхгүй байхын тулд энэ хууль орж ирсэн байх. Энэ 6 сарын дотор сонгууль төгссөн цаг хугацаа нь Сонгуулийн хуулийг өөрчилж байгаа нь эрх баригч нар өөрсдөдөө зориулсан



хуулийг хийдэг энэ заалтаар л энэ тухайн асуудлыг хорьж байсан байх. Одоо ч гэсэн тэгж л хоригдох ёстой. Үгүй ээ сайхан юмнуудыг ярьж л байна л даа. Эмэгтэйчүүдийн квотыг өөрчилье өө тэрийгээ л хийчихье. Тэгээд өнөөдрийн явж байгаа хууль Монгол Улсад хамгийн болохгүй байгаа нэг л юм байгаа. Ямар нэгэн асуудлыг цаг хугацааны хувьд байнга өөрчлөдөг. Энэ чинь аливаа асуудал чинь цаг хугацааныхаа хувьд сайжирч засарч ингэж явдаг болохоос, дүрмээ байнга өөрчлөөд байх юм бол энэ улс орон чинь өөрийн гэсэн тоглох ямар ч дүрэмгүй болоод байгаагийн мөн чанар чинь өнөөдрийн бид нарын гаргах гээд байгаа хууль яг л нэг юм.

Энэ уг нь эрх баригч нар маань та бүхэн санаж байвал сонгууль дөхүүлээд өөрсдийнхөө тоглоомын дүрмийг өөрчилсөн тэр намууд л ялагддаг шүү МАН-ынхан. Орон нутгийн сонгуульд ялах боломжгүй болчоод эргээд өөрсдөдөө зориулаад тоглоомын дүрэм зохиох гэж байгаа бол бас эндүүрэл болдог юм байна лээ шүү. Улам л их ялагдах тэр боломж чинь нээгдэнэ ээ гэдгийг хэлчихье. Ер нь ард түмэн бүгдээрээ хэлж байна даа. Энэ нүүрсний хулгай, энэ ногоон автобусны хулгай. Монголын ард түмэн ямар нэгэн байдлаар хууртагдахаа больчихсон юм байна аа. Бүх юм ил болсон.

Өнөөдрийн энэ хэвлэл мэдээлэл энэ явж байгаа энэ процессууд өнгөрсөн 4 жилийн та бүхний өгсөн амлалтууд ер нь биелж байгаа юм байгаа юм уу? Энэ болгоныгоо эсрэгээр сонгуулийн тогтолцоо сонгуулийн энэ дүрмийг тоглоомын дүрмийг өөрчлөөд ингээд ялчихна гэж бодож байгаа эндүүрэл болно оо.

Тийм учраас үнэхээр яаралтай өөрчлөх гэж байгаа тэр сонгуулийн тогтолцоонд дэвшил авчраад байгаа тэр эмэгтэйчүүдийнхээ квотыг өнөөдөр оруулаад баталчихъя л даа. Та хэд чинь 72 цагийн дотор хууль баталж чаддаг

хүмүүс юм чинь. Тэгээд харин яг энэ бүтэн жилийн өмнө энэ тоглоомын дүрэмдээ гар хүрэхгүйгээр тэгээд цааш нь явчихвал ингээд болох гээд байна л даа. Тэрнээс амь тавих гэж байгаа нь гэж байгаад сүүлчийнхээ сумыг тавих гэж байгаа гэж байгаад бүүр юу ч үгүй болчхов доо. Нийслэл дээр үнэхээр хүнд байна л даа. Зүгээр зураглал нь өөрөө тэгж харагдаад байгаа байхгүй юу. Дүүргүүдээс нийслэлийн даргыг сонгох тухай ойлголтыг та бүхэн явуулж байгаа л даа. Энийг бүгдээрээ мэдэж байгаа. Тэгээд энэ өөрчлөлтийг цаг хугацааны хувьд дөхүүлж байгаад хийнэ ч гэдэг юм уу өнөөдөр та нарт ашигтай байгаа хувилбарыг 6 сарын дараа хийе гэсэн ийм байдлаар асуудалд хандах юм бол хэн хэн нь өнөөдөр бид нар үүн дээр санал өгсөн гишүүд маань хүртэл ер нь Монголын парламентад бас хар мөр үлдээнэ шүү гэдгийг бас анхааруулчихъя.

**Г.Занданшатар:** Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна. Ирцээ бүрдүүлье.

Санал хураалтын өмнө төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүдэд мэндчилгээ дэвшүүлье.

10 дугаар сарын 11-нд Улсын Их Хурлын гишүүн Идэрбат, Жанцангийн Цагаанхүү, Гэндэнгийн Наранчимэг нарын айлын ганц хүү болж эхээс мэндэлжээ. 10 дугаар сарын 13-нд Улсын Их Хурлын гишүүн Баттогтохын Чойжилсүрэн, Мятавын Баттогтох, Замбын Нансал нарын 2 дахь хүүхэд болж эхээс мэндэлжээ. Ингээд Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбат, Баттогтохын Чойжилсүрэн нартаа төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн түшээ, ард түмний элч төлөөлөгч болсон та бүхэнд болон та бүхний гэр бүлийнхэнд нь Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх сайн сайхныг хүсэн ерөөе.

Санал хураалт явуулна. Мөнх-Оргил гишүүн ороод ирсэн байна. Мөнх-Оргил гишүүн гадаад олон улсын томилолт, төрсөн өдрийн чөлөөтэй учраас бас баярын мэнд хүргэчихье. 10 дугаар сарын 18-нд Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил Наваансодовын Цэнд, Баатарын Эвшинхүү нарын Ууганхүү болж эхэлж мэндэлжээ. Ингээд Цэндийн Мөнх-Оргил гишүүндээ төрсөн өдрийн мэнд хүргэж Монгол төрийн түшээ ард түмний элч төлөөлөгч болсон танд болон танай гэр бүлийнхэнд Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх сайн сайхныг хүсэн ерөөе. Мэндчилгээ дууслаа.

Одоо санал хураалт явуулна. Байнгын хорооны саналаар Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалт.

71.1 хувийн саналаар Байнгын хорооны саналыг дэмжлээ. Байнгын хорооны санал дэмжигдсэн учир төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хорооны шилжүүлж байна аа.

#### 11.08 цагт

Дараагийн асуудалд орно. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Ажлын хэсгийг оруулъя. Хууль санаачлагчийн илтгэлийг Батлан хамгаалахын сайд Гүрсэдийн Сайханбаяр танилцуулна.

Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Өнөрболорын урилгаар мал эмнэлгийн салбарын 100 жилийн ойн хүрээнд ахмад эмч нарын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт малын эмч нартаа ажлын өндөр амжилт сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе өө ахмадууддаа. Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс.

Одоо хууль санаачлагчийн илтгэлийг Батлан хамгаалахын сайд Гүрсэдийн Сайханбаяр танилцуулна.

Нөхөр генерал Гүрсэдийн Сайханбаярыг индэрт урьж байна.

**Г.Сайханбаяр:** Эрхэм хүндэт Улсын Их Хурлын дарга, гишүүд ээ,

Та бүхэнд Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар танилцуулж байна аа. Тус хууль нь 1994 онд батлагдаж нийгэм эдийн засгийн өөрчлөлт шинээр болон шинэчлэгдэн батлагдсан хууль тогтоомжтой нийцүүлэх хүрээнд нийт 23 удаа нэмэлт, өөрчлөлт орж байсан байна. Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэлд батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус яамнаас боловсруулан Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжиж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн болно оо.

Тус хуулийн төсөлд дараах эрх зүйн зохицуулалтуудыг тусгасан. Үүнд I дүгээрт Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуультай нийцүүлэн тус хуулийн үйлчлэлд

хамаарах байгууллагуудын эмэгтэй албан хаагчийн жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй байх хугацааг алба хаасан хугацаанд оруулан тооцох болон дээрх хугацаанд төлбөл зохих ЭМД-ын шимтгэлийг тухайн үед мөрдүүлэхээр баталсан сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцон сар бүр улсын төсвөөс хариуцан төлөхтэй холбогдсон эрх зүйн зохицуулалтыг,

Хоёрдугаарт Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбогдсон холбогдсон зааврыг батлан хамгаалах болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлахтай холбогдсон эрх зүйн зохицуулалтыг,

Гуравдугаарт, Цэргийн тэтгэвэр тогтоолгосон иргэн ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасан насанд хүрээгүй байхдаа нас барсан тохиолдолд түүнд оршуулгын зардал олгогдохгүй байгаа хуулийн хийдлийг засаж тус хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт тусгах зохицуулалтыг,

Дөрөвдүгээрт цэргийн албан хаагч хуульд заасан үндэслэлээр хувь тэнцүүлэн тэтгэвэр тогтоолгоход 18 сарын 1 удаагийн тэтгэмж авахтай холбогдсон зохицуулалтыг тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт нийцүүлэн нарийвчлан тодорхойлж хуулийн уялдаа холбоог боловсронгуй болгох эрх зүйн зохицуулалтыг,

Тавдугаарт мөн хуулийн зарим зохицуулалтыг шинэчлэн батлагдсан холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөх юм. Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу боловсруулж төрийн бус байгууллагуудаас болон байгууллагын цахим сайтад байршуулж иргэдээс санал авах ажлыг хийсэн ба төрийн захиргааны

төв байгууллагуудаас санал авахад бүгд дэмжсэн болно оо.

Хуулийн төсөл батлагдсанаар улсын төсөвт нэмэлт ачаалал үүсэхгүй, цаашид төсвийн зардал буурах эерэг нөлөөлөл үзүүлэх ач холбогдолтой гэж үзэж байгаа юм аа. Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Төслийн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбат танилцуулна.

Индэрт урьж байна.

**Ц.Идэрбат:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 3 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Нийгмийн бодлогын байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ. Хууль санаачлагч Монгол Улсын Их Хурлын 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 12 дугаар тогтоолоор баталсан улс Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэлд батлан хамгаалах чиглэлээр Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгагдаж, эмэгтэй цэргийн албан хаагчийн жирэмсний болон хүүхэд харах чөлөөтэй байх үеийн хугацааг алба хаасан хугацаанд оруулан тооцох. Цэргийн тэтгэвэр тогтоолгосон иргэн нас барсан тохиолдолд түүний ар гэрт оршуулгын зардал олгохтой холбоотой болон цэргийн албыг 10-аас доошгүй жил хаасан цэргийн албан хаагч орон тоо, зохион

байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэндээр түүнчлэн цэргийн алба хаах нас хэтэрч ажлаас чөлөөлөгдвөл түүнд 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгохоор хуулийн төслийг боловсруулсан байна аа. Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн сөрөг үр дагавар үүсгэхгүй бөгөөд улсын төсвөөс нэмэлт зардал гаргахгүй гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд хуулийн төслийг Dparliament.mn цахим сайтад байршуулж олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хоролд хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг эмэгтэй цэргийн албан хаагчийн жирэмсний болон хүүхэд харах чөлөөний хугацааны төсвийг хуулийн төсөлд хэрхэн тусгасан талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир эмэгтэй цэргийн албан хаагчийн жирэмсэн болон хүүхэд харах чөлөөтэй байх үеийн нийгмийн даатгал, ЭМД-ын шимтгэл төлөлтийг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд хэрхэн зохицуулж ирсэн, тэдгээр хүмүүсийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар төсөлд тусгагдсан Цэргийн албыг 10-аас доошгүй жил хаасан цэргийн албан хаагч орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэндээр түүнчлэн цэргийн алба хаах нас эдгэрч ажлаас чөлөөлөгдвөл түүнд 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгох заалтын хүрээнд жилд хэдэн хүн хамрагдаж хэдэн төгрөгийн төсөв зарцуулагдах талаар, өмнө нь олгож ирсэн Цэргийн цолны зөрүүг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр бодох заалт нь эрх зүйн орчныг дордуулах эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат хуулийн төслийн хамрах хүрээнд төрийн цэргийн бүх байгууллага орж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг хуулиар олгогдсон жирэмсний болон амаржсаны дараах нийгмийн даатгал, ЭМД-ын шимтгэлийг

ажиллаж байх хугацааны үндсэн цалин хөлснөөс тооцдог бөгөөд түүнээс хойш хүүхдээ 3 нас хүртэл харах тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож олгохыг ялгах, 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгох заалтыг Төрийн албаны хуультай нийцүүлэн ажилласан жилтэй нь дүйцүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар Ахмад настны тухай хуульд заасан насанд хүрээгүй байхдаа нас барсан тохиолдолд түүнд оршуулгын зардал олгогддоггүй хуулийн хийдэл байгааг хэрхэн зохицуулах талаар, цэргийн анги салбарт ажиллаж байгаа энгийн албан хаагчдын эрх зүйн байдлын талаар тус тус асууж хариулт авлаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд үг хэлээгүй бөгөөд Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 66.7 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Батлан хамгаалахын сайд дэслэгч генерал Гүрсэдийн Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга хошууч генерал Сүнрэвийн Ганбямба, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Бригадын генерал Дагвадоржийн Ганхуяг, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого,

төлөвлөлтийн газрын дарга, хурандаа Чулуунборын Гандирваа, Батлан хамгаалах яамны Хуулийн хэлтсийн дарга Гүрбадамын Энхболд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Энхтуяагийн Ганхүү, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Амарсайханы Хишигбаяр.

Хууль санаачлагчийн илтгэл болон байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Аубакир гишүүнээр тасаллаа. Ганибал гишүүнийг нэмлээ, ингээд тасаллаа. Дашидондогийн Ганбат гишүүн асуулт асууна.

**Д.Ганбат:** Ерөнхийдөө хуулийн төслийг дэмжиж байна. Манай эмэгтэй цэргийн албан хаагчид маань голдуу ямар орон тоон дээр ажиллаж байна вэ гэдэг ийм асуулт байна. Бие бүрэлдэхүүний хэчнээн хувийг эзэлж байна вэ. Тэгээд энэ хүмүүс маань хир зэрэг тогтвор суурьшилтай армид алба хааж байна гэдэг ийм асуулт байна аа.

Хоёрт нь бол ер нь геополитикийн нөхцөл байдал дэлхий дээр хүндэрч байна аа. Дэлхий нийтийн болж байгаа үйл явдлууд бол манай улс оронд ч гэсэн нөлөөлж байна. Дэлхийгээс ангид байдаг улс орон гэж нэг ч алга аа. Тухайлбал Орос-Украины дайн энэ Израиль Палестины дайн гээд ийм дайнууд явагдаж байна. Тэгээд ингээд харж байхад бол зарим улс орны цэргийн албан хаагчид, нөөцөд байгаа иргэд, цэргүүд дайчилгаа явуулах шаардлагатай үед дайчилгаа явуулах үед бол эх орноосоо зарим нь гарч зугтаж байна. Зарим нь болохоор эхний дуудлагаар өөрсдөө хүрээд ирж байна.

Манай нөхцөл байдал ямар вэ? Би мэдээж хэрэг Монгол Улс тийм дайны байдалд орчихно гэж бодохгүй байна л даа. Гэхдээ 2 орны хил гаалийн нөхцөл байдлыг аваад үзэхэд энэ дүрвэгсдийн

урсгал орж ирэх ийм магадлалтай. Өөрөө бие даасан тийм зэвсэглэсэн бүлгүүд зарим улс оронд хуулиараа ч юм уу хамгаалах алба ч гэдэг нэрээр ингээд бий болж байна аа.

Энэ нөхцөл байдлуудыг та нар маань хэр бодож байгаа вэ? Юу юугүй энэ улс оронд чинь ингээд ямар нэгэн байдлаар хамгийн наад зах нь дүрвэгсдийн урсгал ороод ирэхэд манай зэвсэгт хүчин маань бэлэн байгаа юу? Ямар байгаа юм? Тэгээд цаашаа бол техник технологийн өндөр хөгжилтэй ийм улс ийм улс орнууд өөрийнхөө тавьсан зорилго энэ үйл ажиллагаагаа биелүүлж чаддаг болсон байна шүү дээ. Тэгэхээр энэ батлан хамгаалах салбарт энэ талбар дээр бид нар анхаарч чадаж байгаа юу үгүй юу? Энэ нэлээн хоцрогдож байна гэж би бодоод байна аа. Төсвийн үлдэгдлээр тэгээд нэг аргацаасан маягаар ийм маягаар явж болохгүй байдалд орчихлоо. Яг орж байна.

Тэгэхээр бид бүхэн бас энэ дээр анхаарах ёстой. Яагаад вэ гэхээр өнөөдөр одоо цэргийн тэтгэвэр, тэтгэмжийн хууль ороод ирж байна. Энэ бас нөлөөлнө. Ингээд одоо цэрэгтээ л анхаарал тавихгүй бол өөрийнхөө цэргийг л анхаарч, өөрийнхөө цэргийг бэлдэж өнөөдөр яг байгаа шаардлага түвшинд нь бэлдэхгүй л бусдынхыг шаардлагатай, бусдын хүмүүсийг тэжээх, бусдын тэр хэмжээнд нь байх ийм байдалд орох вий.

Одоо өнөөдөр бол ямар нэгэн жижиг бага улс гэж байхгүй шүү дээ. Хэр чадвартай хэр технологитой ийм улс орон л өөрийгөө хамгаалж тэр ард түмнийхээ бодлого, хүсэл, зорилтыг нь тэр хэмжээнд нь барьж ийм байдалтай байж чадаж байна аа. Энэ тал дээр манай батлан хамгаалах байдал ямар байгаа вэ гэдгийг бас нэг асуучихъя гэж бодож байна.

**Г.Занданшатар:** Гүрсэдийн Сайханбаяр, Батлан хамгаалахын сайд, дэслэгч генерал, 80 хариулна.

**Г.Сайханбаяр:** Баярлалаа. Ганбат гишүүний асуултад хариулъя.

Монгол Улсын хэмжээнд төрийн цэргийн байгууллагууд тэр тусмаа Зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд эмэгтэйчүүдийн хувь хэмжээ бол дэлхийн дундаж хэсгийн ойролцоо байгаа. Дэлхийн дундаж бол 13-аас 15 хувьтай байдаг. Монгол Улсын хувьд зэвсэгт хүчин өнөөдөр эмэгтэй албан хаагчдын эзлэх хувь 11 орчим хувьтай байгаа. Ер нь бол эмэгтэй албан хаагчид бол ер нь хүйсийн ялгаварлал байхгүйгээр шахуу цэргийн мэргэжлийн инженерийн мөн дунд болон гүйцэтгэх албан тушаалуудад томилогдож ажиллаж байгаа. Офицерын болон ахлагчийн албан тушаалуудад. Өнөөдөр тодорхой квотоор Цэргийн дээд сургуульд болон ахлагчийн политехник коллежуудад эмэгтэй залуучуудыг элсүүлэн авч бас бэлдэж байгаа. Ер нь дийлэнх нь холбооны анги салбарууд, радио, локацын анги, салбарууд, ар талын ангиудад ажиллаж байгаа.

Ер нь бол эмэгтэйчүүдийн хувь хэмжээтэй холбоотой асуудал олон улсын хэмжээнд бас нэлээн яригддаг асуудал.

Хоёр дахь асуудал энэ геополитикийн асуудалтай холбоотой асуудал бол үнэхээр одоо цаг үе амаргүй байна, тогтворгүй байна. Бас зөрчил мөргөлдөөн ихтэй байна. Энийг маш анхааралтай ажиглаж байгаа. Энэ Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд энэ дайчилгаатай холбоотой асуудлаар ялангуяа дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх бэлэн байлгах тухай асуудлаар тодорхой ажлуудыг авч хэрэгжүүлсэн.

2021 онд бид Орхон аймагт байгаа анги салбартай, 2023 онд Төв аймагт байгаа анги салбаруудтай дайчилгааны болон орон нутгийн хамгаалалтын хамтарсан сургалтыг зохион байгуулж явуулсан. Энэ бол орон нутагт байгаа иргэдийг дайчилгааны нөөцөд байгаа иргэдийг сургаж бэлтгэх, ер нь одоо энэ бодлогын их чухал ажил болсон. Энэ дайчилгаатай холбоотой асуудал дээр Монгол Улс бол дайчилгааныхаа нөөцийн чанар тооны хувьд бас боломжийн байгаа. Ер нь бол энэ дээр бас тодорхой тоо бол хэлэх боломж байхгүй. Ер нь 1990-ээд оны үед нэлээн өргөтгөсөн хэлбэрээр хугацаат цэргийн албаны татлагыг явуулдаг байсан үеийн дайчилгааны нөөцийн бүрэлдэхүүн бол өнөөдөр тогтвортой хадгалагдаж байгаа.

Дээрээс нь бид сүүлийн жилүүдэд энэ цэргийн албаны олон төрлүүдийг хэрэгжүүлж үүнийхээ дагуу бас дайчилгааныхаа нөөцийн сэлбэлтийг нөөцийг бүрдүүлэх ажлыг бол хийж байгаа.

Дүрвэгчидтэй холбоотой бас нэг онцгой нөхцөл байдалтай холбоотой гэнэтийн асуудал дээр Монгол Улс бэлэн үү гэсэн асуудал дээр ер нь одоо Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс төрийн цэргийн байгууллагууд, хууль сахиулах байгууллагуудын хувьд сүүлийн 2 жил дараалан онцгой анхаарч нэгдсэн сургалтуудыг зохион байгуулж явуулсан. Үүний хүрээнд онцгой нөхцөл байдал үүссэн үед болзошгүй ямар ямар чиглэлээр ямархуу үйлдлүүд гаднаас болох нь вэ дотроос болох эрсдэлтэй байна гэдэг сэдвүүдээр энэ төрийн цэргийн байгууллагууд ажлын уялдаа холбоогоо хангаж ямар үүрэг гүйцэтгэх вэ? Тухайн цаг үед энэ чиглэлийн төлөвлөлт бэлтгэлийн ажлуудыг хийгдэж явагдаж байгаа.

Тэгээд энэ талаараа бол ер нь төрийн цэргийн байгууллагуудын

харилцан уялдаа холбоо мөн тусгай хүчний анги салбаруудын шаардлагатай үед үүрэг гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлэх талаар Засгийн газраас онцгой анхаарч ажиллаж байгаа.

Тэгээд энэ чиглэлээр Засгийн газраас болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс нэлээд тодорхой бэлтгэлтэй байгаа. Энэ бэлтгэлийг хангах талаар төрийн цэргийн байгууллагууд бас энэ чиглэлээр хамтарч дадлага сургалтуудыг хийсэн.

Дээрээс нь одоо бас нэгдсэн бодлого зангидагдаж байгаа гэдгийг бас энд хэлэх байна аа.

**Г.Занданишатар:** Дашдондогийн Ганбат гишүүн тодруулъя нэг минут.

**Д.Ганбат:** Тэр 18 сарын цалин гэдэг хэдэн төгрөг вэ? Тэр жирэмсэн эмэгтэйчүүд ер нь тэтгэмж нь хэд байдаг юм бэ? Тэр оршуулгын мөнгө нь өнөөдрийн яг батлагдчихвал энэ нь хэд болох юм? Нөгөө талаар бол цэргийн бие бүрэлдэхүүнд армид гадуурхах оны ялгаа, дарамт үүнээсээ болж дарга цэргийн харьцаа цэргүүдийн тайван цагт амиа алдсан, сүрьеэ энэ тэр гээд ийм асуудлууд байгаа. Эмэгтэй цэргийн албан хаагчид маань бас тэр бэлгийн дарамт, сүүлийн үед энэ Монгол улсад хүчирхийлэл гаарлаа шүү дээ. Энэнээс ангид байж чадаж байгаа юу? Өнгөрсөн 2, 3 жилд нэлээн хэдэн цэргүүдийн амь нас үрэгдсэн. Энэ дээр та бүхэн маань ямар арга хэмжээ авсан бэ? Хүмүүстэйгээ хариуцлага тооцсон уу? Ахиад ийм юм гарахгүй байна гэсэн итгэлтэй байж болох уу эх, эцгүүд?

**Г.Занданишатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, Нямаагийн Энхболд, Цэвэгдоржийн Туваан нарын урилгаар Төв аймгийн Сэргэлэн сумын ахмадуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байна. Эрхэм хүндэт ахмадууддаа Улсын Их

Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх сайн сайхныг хүсэн ерөөе.

Батлан хамгаалахын сайд, дэслэгч генерал Гүрсэдийн Сайханбаяр хариулъя.

**Г.Сайханбаяр:** Баярлалаа. Ганбат гишүүний асуултад хариулъя.

Энэ 18 сар болгохтой холбоотой энэ хуульд оруулж байгаа өөрчлөлт бол хэмжээтэй холбоотой асуудал биш. Ер нь офицер ахлагч нар хувь тэнцүүлсэн тэтгэвэр болон бүрэн тэтгэвэр гэсэн 2 тэтгэвэр тогтоолгодог. Энэ 2 тэтгэвэр тогтоолгох хувь хэмжээ нь бол офицер ахлагчийнх харилцан адилгүй. 25 жилээ гүйцэд алба хаасан нь бол бүрэн тэтгэвэр 36 сар хүртэл авна. 10 болон түүнээс дээш жил алба хааж байгаа алба хаагчид нь 18 сарын тэтгэмж авдаг. Тэр нь бол бол өөрийнх нь орлого цалингийн хэмжээнээс шалтгаалаад янз бүр тогтоогдож байгаа.

Эмэгтэй цэргийн албан хаагчидтай холбоотой энэ хуульд орж байгаа зохицуулалт бол энэ эмэгтэй цэргийн албан хаагчид жирэмсэн болоод жирэмсний хүүхэд асрах чөлөөтэй байх.

**Г.Занданишатар:** Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн асуулт асууна.

**Ж.Сүхбаатар:** Баярлалаа. Яах вэ ер нь ингээд тойрог дээрээ уулзалт хийгээд явж байхад зарим цэргийн албан хаагч нар ингээд л уулзаад л ярьдаг л даа. Одоо тэгээд асуудлууд ярьдаг. Мэдээж тэтгэврийн тогтолцоонд бид нарт асуудлууд байгаа. Ялангуяа бага тэтгэвэр авч байгаа хүмүүс бас л сая гомдол саналтай бас үлдчихсэн ингээд байдаг. Тэгэхээр асуудал ингээд шийдье гээд л явдаг бид нар. Тэгээд гомдол саналтай хүний тоо ямар нэгэн хэмжээгээр багасах биш заримдаа ингээд нэмэгдчихээд байгаа юм. Тэгээд би юу хэлэх гээд байгаа юм гэхээр зүгээр цэргийн албан хаагчийн бага

*тэтгэвэр авдаг хүмүүсийн тэр тоо багцаалбал хэд орчим байдаг бол?*

*Сүүлийн үеийн одоо бид нарын энэ иргэдийн нэг яриад байгаа бага тэтгэвэр дээр олигтой нэмэгдсэнгүй гэдэг энэ гомдол санал танай хүрээнд ямар байж байна? Өнөөдөр ингээд л Их Хурлаар ингээд л цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн хуульд нэмэлт, өөрчлөлт орох гэж байна гээд л ярингуут нөгөө яам маань энэ биднийгээ юмыг мэдэж байна уу, үгүй юу гээд л.*

*Ингээд яг орой гэхэд ингээд л зурагтаар хараад л суух байхгүй юу. Нөгөө гишүүн маань эд нарт энийгээ ярьж байна уу үгүй юу. Уг нь хэлээд л байсан даа гээд л. Тэгэхээр ингээд хуульд ингээд асуудал орж байгаа учраас ингээд нөгөө бид нарын салбар дээр тулгамдаад байгаа асуудлууд яг шийдэгдэх талаасаа явж байна уу үгүй юу гэдэг асуудал дээр хүмүүс ингээд л хүлээж байгаа юм. Тэгэхээр энд сууж байгаа улсууд бас хэлэх хэрэгтэй шүү дээ. Энэ удаагийнх нь ийм байгаа юм. Тэгээд энэ удаагийнхаар ер нь бүх тулгамдчихаад байгаа асуудлаа шийдэх гээгүй. Дараа нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтайгаа ярьж байгаад тийм бусад асуудлын хүрээнд юм шийдэх юм байна ч гэдэг юм уу ингэж авч үзэж байгаа юм юу байна гэдэг ийм асуудал байж байгаа. Тэгээд нөгөөдөх асуудал бол ер нь бол яах вэ цэргийн албаны хувьд бол мэдээж хэрэг онцгой хүнд нөхцөлд тодорхой үүрэг даалгаврыг гүйцэтгэдэг. Тэгээд эрт бас тэтгэвэр тогтоолгоод явчихдаг. Дараагийн ажил эрхлэлтийн асуудлууд гээд заримд нь гарч ирдэг.*

*Тэгэхээр манай энэ төрийн бодлогын хувьд энэ тэтгэвэр тэтгэмжийн бодлого дээрээ та хэд би түрүүний асуултуудаасаа ургуулаад хэлэхэд ер нь ойрын үед гэдэг юм уу даа 2024 онд гэхэд энэ бодлого дээрээ та хэд өөрсдөө тусгайлсан ямар нэгэн нэмэлт арга хэмжээ авахаар бодож байгаа юм*

*байгаа юу? Эсвэл Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны тэтгэвэр, тэтгэмжийг нэмэх хүрээнд бодож байгаа юм байна уу гэдэг бодлогын нэг ийм асуулт байна. Ингээд харахад яг өнөөдрийн энэ боломж бол тэтгэвэрт гарсан улсууд байж байгаа байхгүй юу.*

*Тэгэхээр өнөөдөр яг цэргийн албан хаагчийн тэтгэврээ тогтоолгочихсон яг хэдэн мянган хүн байж байна. Тэгээд жилд хэдэн хүн гарч байна. Тэгээд энийг нь ингээд бас манай би бас цөөнгүй улсуудтай цэргийн албан хаагч, цэргийн албан дээр офицер ахлагч нартай таарч байсан учраас энийг нь бас ингээд тодруулж хэлээд та хэд маань энд хэр санаа тавьж байгаа юм. Юу бодож байгаа юм. Энийг нь бас хүргүүлж гэдэг үүднээс асуулт асууж байгаа юм.*

*Баярлалаа.*

**Г.Занданшатар:** Гүрсэдийн Сайханбаяр Батлан хамгаалахын сайд дэслэгч генерал хариулна.

**Г.Сайханбаяр:** Баярлалаа. Сүхбаатар гишүүний асуусан асуултад хариулъя.

*Тэгэхээр энэ хувь тэнцүүлсэн тэтгэвэртэй холбоотой асуудал бас асууж байна. Тэгэхээр зэрэг хувь тэнцүүлсэн тэтгэвэр гэдэг бол 10 жил түүнээс дээш жил алба хаасан бүүр тэгээд цэргийн алба хаах насны хязгаарт хүрсэн офицер, ахлагч, цэргийн албан хаагч хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоолгож байгаа. Хувь тэнцүүлсэн тэтгэврийн хэмжээг бол бас л одоо ажилласан жил цалингийн түвшинээсээ шалтгаалаад харилцан адилгүй тогтоогдож байгаа. Хамгийн доод жишиг нь бол 550 мянга. Түүнээс дээш тогтоогдож байгаа. Ер нь бол жилдээ нэг хувь тэнцүүлсэн тэтгэвэр гэдэг бол эрүүл мэндээр орон тоо, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөөр өөрөөс шалтгаалах шалтгаанаар хувь*



тэнцүүлсэн тэтгэвэр тогтоолгох эрх үүсдэг учраас энэ бол бас харьцангуй цөөн. Дунджаар нэг 40 орчим цэргийн албан хаагч жилдээ хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоолгодог ийм юм байгаа. Ер нь бүрэн тэтгэвэр тогтоолгодог хэмжээ бол үүнээсээ нэг 4-өөс 5 дахин илүү байдаг жилийн байдлаар.

Тэгэхээр энэ тэтгэврийн хэмжээтэй холбоотой асуудал байгаа. Ер нь сүүлийн жилүүдэд цэргийн алба хаагаад бүрэн тэтгэвэр тогтоолгосон алба хаагчдын тэтгэврийн хэмжээ харьцангуй өсөлттэй яваа. Ялангуяа сүүлийн энэ жил төрийн албан хаагчдын цалингийн шинэчлэл төрийн албаны шинэчлэл ялангуяа цалингийн шинэчлэлтэй холбоотой энэ жил тэтгэвэрт гарч байгаа хүмүүсийн тэтгэвэр бол бас харьцангуй өсөж, сайжирсан үзүүлэлттэй гарч ирж байгаа.

Одоо бид бол тэтгэвэрт гарч байгаа офицер ахлагч нарынхаа нийгмийн хамгаалал гэдэг юм уу орлогын түвшинтэй холбоотой асуудлаар яг энэ хуулийнхаа хүрээнд л Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийнхаа хүрээнд зэвсэгт хүчнийхээ болон Батлан хамгаалах багц хуулийнхаа хүрээнд л орлого энэ асуудлуудыг нь шийдвэрлээд явж байгаа.

Ер нь манай энэ эрх зүйн байдлын тухай хууль дэлхийн жишигт хүрсэн хууль байгаа. Энэ нэмэгдлүүд, тэтгэмжүүд, тэтгэврүүд, энэ бүх асуудлууд ялангуяа тэтгэвэр тэтгэмжийн төрлүүд нэлээн олон нэлээн олон санкцуудтай бас олон нөхцөл байдлуудыг нь харж тогтоосон нэлээн сайн хууль байдаг.

Тийм учраас энэ тэтгэвэрт гарах цэргийн албан хаагчтай холбоотой эрх зүйн байдлын хувьд бол нэлээн боломжийн хууль ингэж мөрдөгдөж явж байгаа. Тэр тусмаа энэ сүүлийн жилүүдэд төрийн цэргийн байгууллагуудын эрх зүйн

шинэчлэл хийгдсэнтэй холбогдуулаад хамгийн олон удаа хөндөгдсөн нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль бол Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль байгаа.

Баярлалаа.

**Т.Аубакир:** Хуулийг үндсэндээ дэмжиж байгаа. Бид нар бас төрөөс энэ цэргийн албан хаагчдынхаа тэтгэвэр тэтгэмж нийгмийн асуудлыг тодорхой хэмжээнд шийдээд ажиллах ёстой. Энэ дээр ганц 2 асуулт байна. Энэ батлан хамгаалах чиглэлээр цэргийн албан хаагчдын энэ тэтгэвэр, тэтгэмжийн асуудлыг ярьж байна л даа. Энэ дотор хилийн цэргийнхэн орсон юм уу? Батлан хамгаалахын зөвхөн яамны харьяа цэргүүд үү, эсвэл Хилийн цэргийн ерөнхий газраас хүн харагдахгүй байх юм. Энэ дээр бүгд яг орж байгаа юу гэдэг дээр 1 дүгээр асуулт. Хилийн цэрэгтэйгээ Батлан хамгаалахын цэрэгтэйгээ бүгд орж байгаа юу гэдэг нэг асуулт байна.

Ер нь бол хилийн цэрэг гэдэг бол бас их онцлогтой ийм байгууллага л даа. Одоо суурин газраас хол амьдардаг хэдэн сараар суурин газарт орж ирэх боломж байхгүй. Тэндээ одоо гэр бүлтэйгээ, үр хүүхэдтэйгээ үндсэндээ ингээд бүтэн жил амьдардаг нэг ийм л хүмүүс байдаг л даа. Бид нар тойрог дээр очно. Улсын хэмжээнд хилийн цэргүүдийн байгууллагуудаар явж байхад зарим заставууд энэ тэр дээр очиход бол бас л хүндрэлтэй л дээ одоо нийгмийн асуудлыг нь шийдэх хэд хэдэн асуудлууд байгаа юм. Манай Хууль зүйн сайд бас сууж байна. Энэ хилийн цэргийн энэ нийгмийн тал дээр бас анхаарах зарим зүйлүүд бас бий. Жишээлэх юм бол хилийн цэргийн тэр застав дээр ажиллаж байгаа тэр албан хаагчдын хүүхдүүдийн боловсролын асуудал аягүй тийм эмзэг болоод үлдчихсэн байдаг юм байна лээ. Сургуулийн өмнөх боловсрол эзэмших бололцоо байхгүй. Зарим заставууд дээр бол үлгэр жишээ болохуйц цэцэрлэгүүд

байгуулчихсан ажиллаж байгаа. Тэндээ хагас жил байдаг юм уу? Бүтэн жил болсон хүүхэд маань үндсэндээ тэр хэдэн томчуудынхаа хүмүүжлээр хүмүүжих маягтай. Нөгөө хүүхдийнхээ эзэмших сурах ёстой боловсролыг эзэмшээгүй нэг ийм байдалтай байгаад байдаг юм.

Тийм учраас энэ хүүхдийн нийгмийн асуудал энэ тэрийг нь яах вэ? Энэ бол асуулт биш зүгээр санал явж байгаа шүү. Эхний асуултаа би асуучихсан байгаа.

Тийм учраас энэ заставуудын гэр бүлийг нөхөр нь жишээлбэл албан хаагч байлаа гэхэд гэр бүлийнх нь хүнийг бас нэг ажилтай болгох нөхөр нь тэр застав дээр байгаад байдаг эхнэр нь бүтэн хэдэн жил ингээд л ажилгүй ганцхан нөхрийнхөө цалинг харсан байдалтай. Гэр бүлийнх нь хүнийг давхар ажлын байраар хангах асуудал.

Гурав дахь асуудал бол энэ Цэргийн албан хаагч бол эрт тэтгэвэрт гардаг. Яагаа ч үгүй байтал ингээд л 40 гараад л үндсэндээ тэтгэвэрт гарчихдаг. Гэхдээ ажил гүйцэтгэх чадвартай байгаад байдаг. Энэ тэтгэвэрт гарах нас нь хүрчихсэн ч гэсэн тэрийг цааш нь Сайханбаяр сайдаа цааш нь үргэлжлүүлээд ажиллуулах ийм бодлогыг бариад явмаар байгаа юм. Манай энэ Зэвсэгт хүчний байдаг юм уу энэ цэргийн байгууллагын бие бүрэлдэхүүн ямар байгаа билээ? Шинээр орж ирсэн хүн маань тэр тэтгэвэрт гарсан хүний мэдлэг чадвар, туршилагад хүрэх үү, үгүй юү? Хэдий тэтгэвэрт гарчихсан ч гэсэн тэр албан хаагчийн мэдлэг туршилагыг нь энэ байгууллагадаа ашиглаад явах энэ эрх зүйн орчныг нь бас бид нар бүрдүүлэх хэрэгтэй.

Түрүүн таны хэлдгээр бол энэ төсөвт ямар нэгэн өөрчлөлт орохгүй. Тэтгэврээ аваад явна, хажуугаар нь цалингаа аваад явна. Тэр хүн хэдий тэтгэвэртээ гарчихсан ч гэсэн шинэ

албан хаагч нь тэр цалинг нь аваад явах учраас яагаа ч үгүй эрт ингээд тэтгэвэрт гаргачхаад хаячихдаг. Тэр хүн маань нийгэмд эргээд буцаад ямар нэгэн ажил хийхэд сэтгэл зүйн хувьд ажлын байрны хувьд ийм бололцоонууд бий юу үгүй юү? Тийм учраас энд тэтгэвэрт гарсан хүнээ эргээд тэр албанд нь ажиллуулах тэтгэврийг нь өгөнгөө хажуугаар нь алба хаалгаад явах ийм эрх зүйн орчныг бид нар бас бодож олох ёстой юм.

Тэгээд миний эхний асуусан асуултад Сайханбаяр сайд эсвэл энэ манай Нийгэм хамгааллын сайд яамныхан байх шиг байна. Энд хилийн цэрэг яг орсон уу үгүй юү? Яг энийг тодорхой хэлээд өгөөч. Хуулийг бол үндсэндээ дэмжиж байгаа.

**Г.Занданшатар:** Сайханбаяр генерал дэслэгч генерал Сайханбаяр Батлан хамгаалахын сайд хариулна. 80.

**Г.Сайханбаяр:** Баярлалаа Аубакир гишүүний асуултад хариулъя.

Ер нь Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн үйлчлэл хамрах хүрээ гэдэг дотор маш тодорхой заачихсан байгаа л даа. Энэ бол төрийн цэргийн байгууллагууд, зэвсэгт хүчин, хилийн цэрэг, дотоодын цэрэг, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүхийн шинжилгээ, авлигатай тэмцэх онцгой байдлын асуудал болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн байгууллагын офицер, ахлагч, цэргийн албан хаагчидтай холбоотой харилцааг зохицуулж байгаа учраас хилийн цэрэг бол үүн дотор хамраад явж байгаа. Алслагдсан анги салбаруудад ажиллаж байгаа цэргийн албан хаагчидтай холбоотой маш чухал асуудал хөндөж байна. Тэгээд энэ асуудлаар бид одоо 2016 онд батлан хамгаалах багц хуулийн шинэчлэл хийсэн. Энэ хүрээндээ нэлээд олон асуудлуудыг бас авч үзэж бас эрх зүйн хувьд нь сайжруулсан заалтуудыг бас батлуулж хэрэгжүүлээд явж байгаа.

Тухайлах юм бол алслагдсан анги салбаруудын жагсаалтыг тогтоох нэмэгдлүүдийг олгох, хүнсний нэмэгдэл олгох, сургуульд хамрагдаж байгаа хүүхдүүдийн тоогоор нь мөнгөн тэтгэмж олгох, ажилгүй, ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй ар гэр гэрийн байдалд нь жилд 1 удаа бас тэтгэмж олгох гэх мэтчилнээр энэ асуудлууд бол 2016 онд нэлээн сайн хуульчлагдаж гарсан учраас энэ бол хуулийнхаа хүрээнд хэрэгжээд явж байгаа.

Хүүхдийн боловсролын асуудал бол зэвсэгт хүчин төрийн цэргийн байгууллагуудын хувьд хилийн цэргийн заставууд дээр ажиллаж байгаа алба хаагчдын хүүхдийн боловсролын асуудал нэлээн асуудалтай байдаг. Ялангуяа цэцэрлэг, сургуулийн асуудал бол нэлээн хүндрэлтэй. Тэгэхдээ застав дээр ажиллаж байгаа аав, ээж нар нь хүүхдүүдээ сумдын төвүүд дээр байгаа сургууль, цэцэрлэгийн байгууллагуудад хамруулах байдлаар дотуур байраар дамжуулан боловсрол эзэмшүүлэх талаар ийм л байдалтай явж байгаа.

Тэтгэвэрт гарсан хүмүүс эрт гардаг, цэргийнхэн. Цэргийнхэн бол үндсэндээ одоо 45 наснаас эхлээд л тэтгэвэр тогтоолгодог дунджаар. Тэгээд 60, 65 нас хүртэл ажлын чадвартай байдаг. Энэ хугацаанд нь аль болохоор энэ батлан хамгаалах салбар, төрийн цэргийн байгууллагууд бол ашиглахыг одоо эрмэлздэг. Ер нь бол тэтгэвэрт гарсан хүмүүсийг ажлын байраар хангах ажил мэргэжилд нь бэлтгэх дараагийн амьдралд нь мэргэжлийн хувьд нь болон практикийн хувьд нь бэлтгэдэг талаар нь мөн тодорхой ажлуудыг хийж явж байгаа.

Ер нь өнөөдөр ингээд аль ч хүчний байгууллага, цэргийн байгууллага дээр очиход тэтгэвэрт гарсан албан хаагчдын тодорхой хувийг нь эргүүлж ажиллах ийм нөхцөл бололцоогоор хангасан байдаг.

Зүгээр том утгаараа заавал ажлын байраар хангана гэсэн ийм эрх зүйн зохицуулалтыг хийх боломж байхгүй.

Яагаад гэвэл тэтгэвэр тогтоолгоод тэр хүн бол улсад бүрэн хэмжээгээр ажиллаад тэтгэврээ тогтоолгочихсон байдаг. Харин мэргэжил, туршилага чадварыг нь ашиглаад тодорхой албан тушаалууд дээр орон тоон дээр авчирч ашиглах асуудал байгаа.

Баярлалаа.

**Г.Занданшатар:** Наянтайн Ганибал гишүүн асуулт асууна.

**Н.Ганибал:** Энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дэмжиж байна аа. Ер нь аливаа улс орны батлан хамгаалах зэвсэгт хүчин нь ямар чадамжтай байна түүнээсээ хамаараад ард иргэдийн өөртөө итгэх итгэл, тэр итгэл улам нэмэгдэж байдаг. Тэгэхээр ер нь бидний хувьд өнгөрсөн цаг хугацаанд нэг алдаа гарсан гэж би хараад байдаг юм. Зүгээр манай Батлан хамгаалахын офицер ахлагч нар мэргэжлийн ахлагч нар маань өөр салбар луу шилжин ажиллах ийм сонирхол нэг хэсэг явсан. Мэдээж ер нь төрийн тусгай хамгаалалтын алба юу билээ нөгөө төрийн тусгай юу гэдэг билээ, тийшээ оруулж өгөөч, цагдаа руу оруулж өгөөч гээд тэгэхээр Монгол төрийн үнэхээр нууц гэж байдаг бол зэвсэгт зэвсэгт хүчин үнэхээр хүчтэй байя гэж бодож байгаа бол энэ цаг хугацаанд өнөөдөр ардын арми, ардын арми, хил хилийн цэрэгт алба хааж байгаа тэр мэргэжлийн боловсон хүчнээ бол олон улсын жишигт нь хүргэж чадахгүй юм байна лээ гэхэд Монгол Улсынхаа төрийн тусгай албадууд дотроос хамгийн өндөр тэр тэтгэвэр тэтгэмжтэй байлгах тал дээр ер нь нэг ийм бодлогын түвшинд бодлогоо гаргах нь зөв юм байна лээ. Тэгж байж өнөөдөр бид нар Батлан хамгаалахын хамгийн том жанжин шугам маань өнөөдөр энэ цагийн үед шүү

дээ энэ цагийн үед авах ийм чадамжтай болно.

Өнөөдөр яагаад манай залуучууд энхийг сахиулахын төлөө бүгдээрээ явахыг хүсэж байгаа юм бэ? Адилхан яг энд байгаа ажлаа хийж байгаа бас тэнд очоод яг л ажлаа хийж байгаа. Гэхдээ тэнд авч байгаа тэр орлого авч байгаа цалин бас тэр хүмүүсийн тэр хүслийг төрүүлээд байгаа байхгүй юу.

Ер нь бид бүхний хувьд төрийн хар хайрцгийн бодлого гэж үнэхээр байдаг бол энэ дээр ер нь хамгийн 1 дүгээрт батлан хамгаалахынхаа тэр цалингийн жишигийг хамгийн өндрөөр нь тогтоох энэ ажлаа хийх ёстой юм уу даа гэж боддог.

Тэгээд өнөөдөр бас энэ тэтгэвэр, тэтгэмжийн асуудал дээр эмэгтэйчүүдийн энэ тэтгэвэр авах дүйцүүлэх энэ асуудлуудыг оруулж ирж байгаа нь зөв. Энэнээс илүү ямар боломжууд байна. Эргээд бүгдийг нь л ер нь нэг мөр л батлаад л явчих ёстой юм байна лээ. Тэгж байж өнөөдөр Монголын батлан хамгаалах, хилийн цэрэг алба хааж байгаа тэр мэргэжлийн офицерууд, мэргэжлийн ахлагч нар, мэргэжлийн хилчид маань амьдралдаа баталгаатай, итгэлтэй, үнэхээр эх оронч тэр үзэл санаа бол илүү нэвт шингэсэн мэргэжлийн дайчид болно л гэж харж байна.

Баярлалаа.

**Г.Занданшатар:** Санал хэлчих вүү? Санал хэлчихлээ. Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Дэмжсэн дэмжээгүй үг хэлэх 3 хүртэл гишүүн үг хэлж болно. Бейсен гишүүнээр тасаллаа. Би дараа нь үг хэлнэ. Жамбын Батсуурь гишүүн үг хэлнэ.

**Ж.Батсуурь:** Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

хуулийн төслийг дэмжиж байна аа. Ер нь улс орны нүүр царай бол цэрэг арми түүний бааз суурь, байх ёстой. Тэгээд өнгө зүс, нүүр царай гээд ярихлаар асуудал юун дээр явж байв гэхээр эдийн засаг, хөрөнгө оруулалт дээрээ л очдог. Энэ бол хувь хүнээс авхуулаад бүх албан байгууллагуудын өнгө сүр бол явж явж эдийн засаг дээр байдаг. Эдийн засаг тусмаа хувь хүн, хүмүүсийн чадавх, ар гэрийн чадвар сайн байж байж ажил төрөлдөө идэвхтэй дан ялангуяа батлан хамгаалах тусгай албыг хийж байгаа хүмүүс бол цаг наргүй ажилладаг. Хэзээ ч үүрэг авахад бэлэн байдаг ард иргэдийн төлөө усан бороо, цасан шуурга, аагим халуун бүхий л нөхцөлд ингэж ажилладаг хүмүүс энийг тэр болгон мэддэггүй.

Баяр ёслолын үеэр сайхан хувцастай журамт хувцастай жагсаалыг нь хараад цэргийн хүн энэ тусгай алба хийдэг хүмүүс л гоё гэж хардаг уу гэхээс биш тэрний цаана нь дандаа амь эрсэдсэн үйлдлүүд рүү ордог гэсэн. Ийм зүйлийг тэр болгон хүмүүс мэддэггүй. Гэтэл хувь хүний байгууллагын улс орны сүр хүчгүй бол явж явж эдийн засаг Монгол орны эдийн засаг хэцүү байгаа ч гэсэн сүүлийн жилүүдэд төсвийн цар хүрээ нэмэгдэж байгаа. Эдийн засгийн чадавх бас нэмэгдэж байгаа. Яг энийгээ дагаж цалин хөлс нэмэхгүй байгаа.

Сүүлийн жилүүдэд бол зүгээр энгийн нөхцөл байдлыг бол инфляцын түвшинтэй уялдуулж эхэлсэн л нэг үг орж байна. Тэр нь инфляцынхаа түвшинтэй уялдаж чадахгүй байгаа.

Тийм учраас би энэ батлан хамгаалах байгууллага, дотоодын цэрэг, цэрэг тагнуул эдгээр зүйлээ бол анхаарах ёстой. Зөвхөн энэ цэрэг ч гэлгүй бааз суурийг нь онцгой анхаармаар байгаа юм даа. Ер нь Зэвсэгт хүчний анги салбарууд гэж хуучин бидний хүүхэд байхад ер нь цэргийн анги дээр очих цэргийн ангийн дээр ороод гарна гэдэг бол бас нэр төрийн

хэрэг байсан. Тэгэхэд бол энэ чинь олон жилийн явцад хилийн заставуудаар явах отрядуудаар явах аймгууд дээр байгаа барилгын бусад үүрэг гүйцэтгэгчийн анги салбар дээр очиход бол нийтлэг байшин барилга нь муудсан бааз суурь нь ерөнхийдөө ингээд хөгшрөлт орчихсон ийм зүйлүүд байдаг.

Тэгэхлээр энийг цаашаа авч явах хүмүүс нь эхний ээлжид хамгийн авч болох асуудал нь бол түүнд ажиллаж байгаа албан хаагчид хүмүүс байж байгаа. Тэгэхлээр энийг урам зоригтой болгох тэр том хэмжээний хөрөнгө оруулалтуудыг улс орон нэгэнт хийж чадахгүй болохлоор тэрийг шат шатад нь авч явах энэ шат шатны хүмүүсээ бас урам зориг өгөх тэтгэвэр тэтгэмжийг нь нэмэх, цалин хөлсийг нь нэмэх урамыг нь нэмэх. Энэ байдлаар төр халамж нөхцөлөө үзүүлэх нь зөв өө гэж ингэж үзэж байгаа юм. Энэ ч агуулгаараа цаашид бас эргээд энэ хүмүүсээсээ батлан хамгаалах энхийг сахиулах Монгол Улсын нэр хүндийг олон улсад гаргах дэлхий нийтэд гаргах тэр хэмжээгээрээ НҮБ бусад улс орнуудын хэмжээнд энэ батлан хамгаалах сүр хүчийг дээшлүүлэх энэ нөхцөлийг буцаад та бүхнээс ард түмэн төр бол нэхэх ёстой л гэсэн ийм байр суурьтай байгаа.

Тэгэхгүй бол нэг нь зүгээр авдаг зүгээр халамж хүртдэг ийм систем рүү орж болохгүй. Ер нь зүгээр би энэ халамжид дургүй. Ер нь Монгол Улсын хөгжихгүй байгаа нөхцөл байдал ерөөсөө халамжийн улс болсонтой холбоотой. Тэгэхдээ би энэ орж ирж байгаа энэ цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмж, цалин өөрчлөлтийн асуудлыг би халамж нэмэгдэл гэж харахгүй байна. Яагаад вэ гэхлээр өнөөдрийн хийж байгаа, хийх ажлуудад тусгай алба гүйцэтгэж байгаа хүмүүсийг бол энэ цаг үед нь урам зоригийг нь сэргээх цаашид хийх ажлынх нь суурь болох ёстой гэж ингэж үзэж байгаа юм.

Тийм учраас энэ хууль хуулийг үзэл баримтлалын хувьд дэмжиж, сайшааж, батлах нь зүйтэй гэсэн ийм санал бодолтой байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Буланы Бейсен гишүүн үг хэлнэ ээ.

**Б.Бейсен:** Энэ цэргийн албан хаагчдын тэтгэвэр, тэтгэмжид байгаа хуулийн төслийг дэмжиж байгаа юм. Бид орон нутгаар ажиллаад энэ хилийн заставуудаар явж байхад ер нь хил дээр ажиллаж байгаа цэргийн албан хаагчдын гэр бүлийн асуудал бүх мэргэжлийн эмч улсууд ч байна, нягтлангууд ч байна, инженер улсууд ч байж байна. Гэтэл ажилгүй гэртээ сууж байдаг. Энэ цаашидаа нийгмийн даатгал шимтгэл энэ тэрийн асуудал дараа нь тэтгэвэрт гарахад нь бас хүндрэл учруулдаг. Хил дамжаад ингээд шилжүүлээд явчихдаг. Хангамжийн асуудал муу. Энийг ажилтай болгох дээр тухайн аймгийн, сумын, хилийн заставуудыг бас хоорондоо яриад энэ ажилтай болгох аймгийн төвд мөн адилхан.

Ер нь цэргийн албан хаагчдыг тухайн аймаг нутагт нь заавал ажилтай болгох асуудлыг бүүр Засаг дарга нарт нь заавал гэрээ хийх шаардлагатай юм байна. Зарим их эмч нар оччихсон ажилгүй л байж байна шүү дээ. Энэ асуудлаар хатуу анхаарахгүй бол болохгүй. Нөгөө талаар тэр цэргийн албан хаагчдын хүүхдүүдийн сургуульд сурах, нөгөө тэр цэцэрлэгийн асуудал маш хүнд. Застав дээр барилга байшин хуучирчихсан. Сая Батсуурь гишүүний ярьдгаар үнэхээр хангамжийн асуудал муу. Ядахдаа хүүхдүүдийг нь сумын төв юм уу багийн төвийн сургуулиуд дээр хүргэж сургах авчрах асуудлыг хангамжийн асуудал дээр анхаарахгүй бол манай улсын хил аюулгүй байдал хангаж байгаа улсууд дээр онцгой анхаарах шаардлагатай юм шиг байгаа юм. Цалингийн асуудал сая нөгөө эрүүл мэнд, боловсрол, цэцэрлэгийн асуудлыг

шийдэхгүйгээр, нийгмийн асуудлыг шийдэхгүй байж энэ чинь болохгүй байна. Энэ дээр анхаарч ажиллана уу гэдэг санал хэлье.

**Г.Занданиатар:** Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалтай гишүүд чуулганы танхимд цуглаарай.

Асуулт, хариулт санал хэлэх хугацаа дууссан.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяагийн урилгаар БГД-ийн “скаут” хүүхдүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Хүндэт сурагчид, скаутууддаа сурлага, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе өө. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль учраас скаут гэдэг чинь ер нь цэргийн тагнуулч гэсэн утгатай үг шүү дээ. Нээрээ түрүүнд нь толгой сэргийлэх гэсэн утгатай үг байгаа. Скаутууд чинь скаутын андгайтай. Тэгээд их нууц зүйл сурч их мэдлэгтэй болж байгаа сайн хүүхдүүддээ амжилт хүсье. Ингээд санал хураалт явуулна.

Ер нь гишүүдийн гаргасан саналын дагуу Сайханбаяр сайд генералаа ер нь энэ цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн асуудлыг ихэвчлэн хөндөж ярилаа. Нэн ялангуяа энэ валютын сан, эдийн засгийн хямралтай үед валютын сангийн шаардлагаар дээд офицеруудын цалин хангамжид нэмэгдэл хангамж энэ тэрийг хассан асуудал бий. Тэр энэ тэрийг сэргээхтэй холбоотой ер нь одоогийн энэ орчин цагийн дэлхийн геополитикийн нөхцөл байдал байгалийн гамшигийн давтамж гэх юм бол бид энэ батлан хамгаалах цэргийн албан хаагчдын эрх зүйн байдлыг дээшлүүлэх. Энэ чинь илүү элит нэр хүндтэй алба байх улсын засвар сүр цэрэгтэй байдаг учраас, сөрөх хүч, эх оронч үзлийг хөгжүүлэхэд чиглэгдэх бүүр

нарийвчлан яривал дээр үед байсан энэ сая Израил ч гэсэн тодроод ер нь олон улсын Швейцар чиглэлийн хандлага бол энэ иргэний хамгаалалтын болон цэрэгжилтийн хичээлийг ЕБС-д ч гэсэн ордог байна шүү дээ.

Иймд цэрэг эх оронч үзлээр хүмүүжүүлэх ажилтай бас батлан хамгаалах салбарын нэг чиглэл бас болж хөгжих ёстой гэж судлаачид үздэг. Илүү эдийн засгийн хохирол учруулчих төрийн цэргийн эдийн засгийн чиглэл, нийгмийн чиглэл, улс төрийн чиглэл энэ бүхий л чиглэлүүдэд бас орон нутгийн хамгаалалтын асуудал иргэний хамгаалалтын асуудал чухлаар тавигдаж байгаа. Одоо орчин үеийн цэргийн дайны нөхцөл байдал гибрид шинж чанартай болж хосолмол болж байгаа энэ үед бол ард иргэдийн оролцоо, иргэний хамгаалалт, иргэний батлан хамгаалалтын асуудал их чухлаар тавигдаж байгаа үед энэ бас шинэчилж шаардагдах байх. Ер нь төрийн цэргийн бодлого цаашилаад иргэний цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулиуддаа өөрчлөлт оруулах асуудлыг бас яаралтай оруулж ирэх шаардлагатай.

Дээд офицеруудын асуудал нэлээн яригдсан та мэдэж байгаа. Энийгээ шийдээрэй.

Ингээд санал хураалт явуулна аа.

Байнгын хорооны саналаар Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. 73.9 хувийн саналаар санал дэмжигдлээ. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх

үзсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлж байна.

Дараагийн асуудалд орно оо.

### 11.55 цагт

*Хууль зүйн байнгын хорооны даргыг сонгох чөлөөлөх асуудлыг хэлэлцэнэ ээ.*

Бригадын генерал Дагвадоржийн Ганхуяг над дээр.

Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хүний эрхийн дэд хорооны дарга Цэрэнжамцын Мөнхцэцэг танилцуулна аа. Индэрт урьж байна.

**Ц.Мөнхцэцэг:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дарга Тогтохсүрэн, нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатарыг Улсын Их Хуралд сонгогдон ажилласан туршлага, төрийн ажлын мэдлэг, ур чадварыг харгалзан Хууль зүйн байнгын хорооны даргад нэр дэвшүүлэн хэлэлцүүлээ.

Дамдины Цогтбаатар 1988 онд Монгол Оросын хамтарсан 14 дүгээр

сургууль, 1994 онд ОХУ-ын Москва хотын ОУХДС-ийг улс төр судлалын мэргэжлээр, 1998 онд Австралийн Холбооны Улсын Үндэсний их сургуулийг олон улсын хуульч мэргэжлээр тус тус төгссөн. 1994-өөс 2002 онд Гадаад хэргийн яаманд 2002-оос 2008 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн гадаад бодлогын зөвлөх 2008-аас 2011 онд ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, 2011-2012 онд Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, 2012 онд Засгийн газрын гишүүн, БОАЖ-ын сайд, 2014-2015 онд Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд, 2016-аас 2020 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2016-аас 2018 онд Хүний эрхийн дэд хорооны дарга, 2017-2020 онд Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайд, 2020 оноос Улсын Их Хурлын гишүүнээр тус тус сонгогдон ажиллаж байна аа.

Байнгын хорооны хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Мөнхцэцэг хүүхдийн эрх хамгааллын асуудал болон ялын бодлогын талаар асуулт асууж хариулт авсан болно.

Хууль зүйн байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатарыг нэр дэвшүүлснийг хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэйгээр дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Мөнхцэцэг гишүүнд баярлалаа.

Зочид танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын 84 дүгээр сургуулийн

9 дүгээр ангийн багш сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Эрхэм хүндэт багш сурагчдадаа ирээдүй болсон хүүхдүүддээ эрүүл энх, сурлага, спорт, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Нэр дэвшигчээс асуулт асууж үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатарыг сонгохыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

73.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны даргаар сонгох саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Байнгын хорооны даргыг сонгох чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

Тогтоолыг уншиж танилцуулъя. Байнгын хорооны даргыг сонгох чөлөөлөх тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2 дахь хэсэг санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатарыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны даргаар сонгосугай.

2. Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаярыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Энэ тогтоолыг 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Хууль зүйн байнгын хорооны даргаар санал нэгтэй сонгогдсон Цогтбаатар гишүүнд ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөж хүний эрхийн чиглэлээрээ улам гүнзгийрүүлэн ажиллахыг хүсэн ерөөе.

Хүний эрхийн Европын холбооны дээд шагналтай хүн шүү дээ бас л.

12.01 цагт

Дараагийн асуудалд оръё.

Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Индэрт урьж байна.

**Ц.Сандаг-Очир:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Нийгмийн бодлогын байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны



хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцсэн болно оо.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир товлолт вакцины төрөлд нэмэгдэж байгаа 3 өвчний вакцины нийгэм эдийн засагт үзүүлэх үр нөлөө болон манай орны хувьд энэ төрлийн өвчлөл нь нийт өвчлөлийн хэдэн хувийг эзэлдэг энэ төрлийн вакциныг дэлхийн хэдэн улс оронд товлолт вакцин дархлаажуулалтад оруулсан талаарх судалгаа байдаг эсэх талаар асуулт асууж хариулт авсан болно оо.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Байнгын хорооны гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэгээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь хэсэгт заасныг баримтлан хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 66.7 хувийн саналаар дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг, ЭМЯ-ны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Сувдын Төгсдэлгэр, ЭМЯ-ны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Дангаагийн Баярболд, ХӨСҮТ-ийн

Дархлаажуулалтын албаны дарга Отгонбаярын Дашипагма.

Байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна. Гишүүдээс асуултгүй боллоо.

Байнгын хороо Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалтаа бэлдэнэ үү. Намын бүлгийн дарга нарыг дуудна уу.

Улсын Их Хурлын 2 дэд дарга ирцээ бүрдүүлье ээ.

Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр дарга аа. Энэ зарим нэг гишүүд чуулганы хуралдаанд тааллаараа оролцож байгаа асуудлыг та хянан шалгаж олон түмэнд мэдээлж, ер нь нэг танилцуулъя.

Ер нь бол парламентын бусад улсын жишигээр нөгөө вип буюу ташиурууд бол энэ оролцоог үнэлж, төсөв дэмжлэг бусад улс төрийн дэмжлэгийн асуудлыг шийддэг л дээ. Яг ингээд 30 гишүүн болчихлоо.

Санал хураалт явуулна.

Байнгын хорооны саналаар анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Өмнө нь анхны хэлэлцүүлгээр нь батлах гэсэн ийм томъёололтой байсан юм. Анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах гэж томъёолдог болсон юм байна лээ.

*Ингээд санал хураалт явуулна.*

*Энэ горимын саналгүй бол ингэж, зарчмын зөрөөтэй саналын томъёолол гараагүй бол ингэж явуулдаг.*

*Ингээд санал хураалт.*

*58.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.*

*Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлнэ. Ер нь Чинзориг сайдаа энэ дархлаажуулалтын үр дагавар ямар байна энэ тэр гэдэг дээр бас нарийвчлан судалгаа нэг хийх шаардлагатай л юм байна лээ дээ. Сүүлийн үеийн энэ ковидын дараах симптом нөлөөлөл энэ тэрийг Монгол хүнд яаж тохирч байгаа гээд тэ сүүлийн үед тийм бас их гомдол санал их гарч байна.*

### *12.10 цагт*

*Дараагийн асуудалд орно. Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэм нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.*

*Дамдины Цогтбаатар нарын гишүүдийн гаргасан хуулийн төсөл. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Хүрэлбаатарын Булгантуяа танилцуулна аа. Индэрт урьж байна.*

*Х.Булгантуяа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,*

*Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатараас 2022 оны 10 дугаар сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Хурлын чуулганы 2022 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.*

*Төсвийн байнгын хорооны 2022 оны 10 дугаар тогтоолоор хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, бэлтгэл ажлын хэсгийг байгуулсан байж байгаа. Тус ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Ц.Сандаг-Очир нар болон холбогдох бусад албан тушаалтнууд ажиллалаа.*

*Төсвийн байнгын хороо 2023 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцсэн байгаа.*

*Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын [dparliament.mn](http://dparliament.mn) цахим системээр дамжуулан олон нийтээс тухайн төсөлтэй холбогдуулан ирүүлсэн болон ажлын хэсгээс гаргасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.*

*Үүнд төсөлд татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээг зөвхөн хуулийн этгээд эрхлэх бөгөөд зөвлөх үйлчилгээ эрхлэхдээ бусад татварын мэргэшсэн зөвлөхтэй гэрээгээр хамтарч ажиллах нь нээлттэй байх,*

*Хоёрт, зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд нь даатгалын байгууллагаа өөрөө сонгож мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулах,*

*Гуравт, татварын мэргэжсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар олгох, 3 түвшний зэрэглэлтэйгээр буюу 1, 2 дугаар түвшний эрхийг 5, 5 жилийн хугацаагаар, 3 дугаар түвшний зэрэглэлийг хугацаагүй олгох,*

*Дөрөвт, татварын мэргэжсэн зөвлөхийн хүрээг нэмэгдүүлэх зорилгоор татвар нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 5-аас доошгүй жил их дээд сургуульд багшилсан багш 4-өөс доошгүй жил татварын асуудал эрхэлсэн төрийн байгууллагад ажилласан албан хаагчийг хамруулах,*

*Тавд, татварын улсын байцаагчийн ажил албан тушаалд 10-аас дээш жил ажилласан бол татварын эрх олгох,*

*Зургаа, Мэргэжсэн зөвлөхүүдийн Хариуцлага, ёс зүйн асуудлыг хуульчлах үүднээс хувьцаа эзэмшигч эцсийн өмчлөгч нь Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаал, хувь хүний нууцад халдах хувь хүний нууцыг задруулах, залилах, хөрөнгө завших болон эдийн засгийн гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлсэн болон ХХОАТ-ын тайланг хуульд заасан хугацаанд тайлагнаагүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох,*

*Долоод, Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийн орон тооны татварын мэргэжсэн зөвлөх, ёс зүйн зөрчил гаргасан талаарх Татварын мэргэжсэн зөвлөхийн нийгэмлэгийн тодорхойлолт болон бусад этгээдээс мэдээлэл ирсэн тохиолдолд тусгай зөвшөөрөл олгосон эрх бүхий этгээд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх хүчингүй болгох эсэхийг шийдвэрлэх,*

*Наймд, Татварын мэргэжсэн зөвлөх нь зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд харьяалагдахгүйгээр ганцаарчлан татварын мэргэжсэн зөвлөх үйлчилгээ эрхлэхгүй байх,*

*Ес, татварын мэргэжсэн зөвлөхийн чиг үүрэгт татварын хууль тогтоомж, түүний өөрчлөлт, татвар төлөгчийн татварын эрсдэлээс хамгаалах урьдчилан сэргийлэх талаар татвар төлөгчид мэдээлэл зөвлөгөө өгөхийг үүрэг болгох зэрэг болно оо.*

*Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын Ж.Батжаргал, Х.Булгантуяа нар болон ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрөөтэй саналын томьёоллуудаар санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.*

*Татварын мэргэжсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал дүгнэлт, зарчмын зөрөөтэй саналын томьёоллыг та бүхэнд хүргүүлээ.*

*Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,*

*Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.*

**Г.Занданшатар:** *Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга Будсүрэнгийн Болормаа, Татварын мэргэжсэн зөвлөхийн нийгэмлэгийн ерөнхийлөгч Гүнсэнгийн Алтанзаяа.*

*Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу?*

*Хассуурийн Ганхуяг гишүүнээр тасаллаа.*

*Баагаагийн Баттөмөр гишүүн асуулт асууна аа.*

**Б.Баттөмөр:** Энэ татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа нь зөв зүйтэй. Энэ Татварын ерөнхий хууль ААНОАТ-ын хууль тэгээд ХХОАТ-ын хууль багц хуулиуд 2019 онд шинэчлэгдсэн. Мөнгө угаах терроризмтой тэмцэх хуульд бас өөрчлөлтүүдийг хийгдсэн. Ингээд энэтэй уялдуулаад энэ мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээний хуульд өөрчлөлт оруулах нь зүйтэй байсан юм аа. Ер нь бол татвар гэдэг бол үндсэндээ улс орны эдийн засгийн суурь үндэс хөгжлийн баталгаа гэж үздэг.

Манайд энэ татвар төлдөг харилцаанууд тэгш бус яваад байгаа шүү дээ үндсэндээ. Тэгээд баахан хяналт шалгалт сул явж явж байснаа Өршөөлийн хууль гэж гаргаад л олон 10 тэрбумаар нь аваачиж өршөөл үзүүлдэг л. Энэ нөгөө шударга татвар төлж байгаа улсууддаа бол их буруу зүйл гэж ингэж үзэж байгаа юм л даа. Тэгээд ер нь бол олж байгаа орлогоо бол яг тэр албан ёсны хууль ёсны гэдгийг батлах юм бол татвар төлсний баримтаар л нотлогдоно гэж байгаа шүү дээ.

Тийм учраас бол энэ татварын харилцааг боловсронгуй болгоход энэ хууль бол онцгой чухал ач холбогдолтой ийм хууль юм аа. Ер нь энэ хувь хүний орлогын албан татвар гэдэг юм бол юу вэ гэхлээр тухайн улсын татварын бааз суурийн бас зонхилох хувийг бүрдүүлдэг. Манайд бол ерөөсөө хувь хүний орлогын албан татвар гэдэг юм бол маш бага байдаг. Хувь хүн өнөөдөр практик дээр яаж энэ тайлангаа гаргаж байна гэхээр зэрэг хөнгөлөлт чөлөөлөлт эдлэх суутган хийлгэх ийм л тохиолдолд л хувь хүн орлогын албан татвараа тайлагнадаг. Бусад тохиолдолд байдаггүй. Хувиараа

бизнес эрхлээд асар их хэмжээний орлого олчихсон байдаг. Асар том хэрэглээтэй, тэгсэн мөртөө тайлагнадаггүй гэх мэтийн олон асуудлууд байгаа юм.

Энийг бол зөв зохистой болгоход энэ ТМЗ нийгэмлэгийн ТМЗ-ийн татвар төлөх зөвлөх үйлчилгээний тухай энэ хууль ач холбогдолтой гэж ингэж үзэж байгаа юм аа. Энэ хуулийн өөрчлөлтөөр бол юу вэ гэхлээр татвар мэргэшсэн зөвлөх үйлчилгээг бол хуулийн этгээдээр гүйцэтгэнэ гэж ингэж орж ирж байгаа юм. Энийг бол зүйтэй гэж ингэж үзэж байна. Энд бол юу вэ гэхээр зэрэг хууль ёсны эрх ашиг бол хамгаалагдана. Татвар төлөгчийн. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх бас татвар төлөгчид өөрснөө татварын хууль тогтоомжоор эдлэх эрхээ эдлэхэд нь бол бас их чухал ач холбогдолтой гэж бодож байгаа.

Өнөөдөр бизнес эрхэлж байгаа хүн болгон санхүү бүртгэлийн мэргэжил байхгүй байгаа. Энэнээсээ болоод алддаг. Тийм учраас мэргэжлийн хүмүүсээр л хийж гүйцэтгэх нь бол зүйтэй. Энэ хуулийн утга санаатай нийцнэ ээ гэж ингэж ойлгож байгаа юм. Ингээд нэг асуулт байгаа юм. Энд бол юу вэ гэхээр энэ үйлчилгээтэй холбоотой энэ үнэ хөлсний асуудал байж байгаа юм. Татварын зөвлөх үйлчилгээ үзүүлдэг хүмүүсийг бол сургалтаар бэлдэнэ гэж байгаа юм. Энийг яаж тогтоох юм. Томоохон татвар төлөгчид, томоохон ААН-үүдэд татварын зөвлөгөө үзүүлнэ гэж байгаа юм. Энийг ил тод тэгш хүртээмжтэй болгохын тулд энэ чиглэлээр ямар үйл ажиллагаа энэ хуулийн юунд орж ирж байна аа? Энэ дээр бас шүүмжлэлүүд байдаг. Хуучин танил талууддаа ингээд өгөөд явуулчихдаг гэсэн ийм янз бүрийн шүүмжлэлүүд байдаг. Ийм 2 асуултад хариулт авъя.

**Г.Занданшатар:** 84.

**Г.Алтанзаяа:** Эрхэм гишүүдийн энэ өдрийг амрыг эрье.

*Баттөмөр гишүүний асуултад хариулъя.*

*Миний бие Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн ерөнхийлөгч Алтанзаяа гэж хүн байгаа. Тэгэхлээр татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээ 2004 оноос эхэлсэн. 2004 оноос Монгол Улсад эхлээд сургалт болон үйлчилгээний хүрээ маань ерөнхийдөө зах зээлийн зарчим дээр явж байгаа гэж үзэж болно. Тэгээд сургалтын процесс бол зайлиггүй сурвал зохих гээд 4 сургалт явж байгаа. Энэ дээр татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээний эрхийг авахад шаардагдах сургалтууд тэгээд дээр нь бол үйлчилгээ үзүүлэх хүрээг бол Татвар мэргэшсэн зөвлөхийн хуулийн дагуу үүсгэсэн хуулийн этгээдүүд үйлчилгээгээ гэрээн дээр тулгуурлаад явуулж байгаа. Тэгээд гэрээгээрээ бол үнэ хөлс тохь шийдэгдээд явж байгаа энэ агуулгаар явж байгаа.*

**Г.Занданшатар:** *Баагаагийн Баттөмөр гишүүн тодруулж асууна, нэг минут.*

**Б.Баттөмөр:** *Яах вэ ер нь татварын зөвлөх үйлчилгээ ойлгомжтой л доо. Үндсэндээ бас нэлээн олон жил үйлчилгээ бас бид нар үйлчилгээний хөлстэй холбоотой асуудал байж байгаа. Жишээлбэл гишүүнчлэлээр ороход ямар үйлчилгээ төлдөг юм, ямар хөлс төлдөг юм. Жилд ямар хэмжээний төлдөг юм. аж ахуйн нэгж ямар төлөх вэ? Тухайн аж ахуйн нэгжид татварын зөвлөх үйлчилгээг хийхэд ямар үйлчилгээний тариф байдаг юм. Энэ дээр ерөөсөө харагдахгүй л байна л даа. Тэгэхээр энийг яаж зохицуулах юм бэ яаж явж ирсэн юм бэ? Энийг л асуугаад байгаа юм.*

**Г.Занданшатар:** *Хэн хариулах вэ? Санал хэлчихлээ дээ тийм ээ? 84.*

**Г.Алтанзаяа:** *Одоогийн яг байж байгаа практик бол гишүүн маань жилдээ 120 мянган төгрөг байдаг юм. Сардаа 10*

*мянган төгрөг. Үйлчилгээний хувьд компаниуд өөрийнхөө дотоод чадамж юун дээрээ тулгуурлаад компани дотроо гэрээгээрээ зохицуулаад явж байгаа. Нийгэмлэгийн зүгээс бол үйлчилгээн дээр тийм тогтоосон тариф бол одоогоор байхгүй. Үйлчлүүлэгч болон үйлчилгээ үзүүлж байгаа этгээдүүдийн хооронд гэрээгээр зохицуулагдаж байгаа.*

**Г.Занданшатар:** *Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууна.*

**Х.Ганхуяг:** *Энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Надад нэг хэд хэдэн асуулт байгаа юм. Тэгээд яах вэ өнөөдрийн бид нарын нийгмийн харилцааг харахаар энэ ёс зүйтэй холбоотой асуудал нэлээн хүнд байдаг. Тухайлбал тав, зургаахан сарын өмнө шударга өрсөлдөөний зохицуулах газрын дарга байсан нөхөр үүрэн телефоны оператор компаниудаа торгож торгож байгаад тэгээд өөрөө нэг компанийнх нь захирал нь болоод очоод суучхаж байгаа юм. Тэгээд энэ яг л адилхан кэйс байхгүй юу.*

*Одоо ингээд энэ дээр харах юм бол татварын байцаагчаар ажиллаж байсан туршилагатай гэж байгаа юм. Тэгээд нөгөө компанийнхаа бүх нарийн мэдээллийг нь авна. Тэгээд энэ чинь эргээгээд тэр компанийг нөгөө мэдээллийг нь алдах, мэдээллийг нь худалдах, дарамт шахалтад оруулах ийм асуудал үүсвэл ямар хариуцлага хүлээх юм.*

*Зөвхөн тусгай зөвшөөрлийг нь цуцлаад л хаячихаар харагдаж байгаа байхгүй юу. Тэгээд манайд энэ манайхаас бусад оронд бол тэр шударга өрсөлдөөний нөхөр ингээд торгож байгаад өөрөө нэг компанийнх нь захирал нь болоод оччихвол эрүүгийн хариуцлагатай байхгүй юу. Манайд бол ингээд алга ташаад баяр хүргээд ингээд томилогдож л байна л даа.*

*Өнөөдөр яг энэ хууль орж ирлээ. Үгүй ээ нөгөө энэ зөвлөх үйлчилгээ үзүүлэх*

юм байна. Гэхдээ асуудал нь юу болох вэ гэхээр энэ чинь тэгээд нөгөө компаниудын бүх нарийн мэдээллийг нь аваад л тэгээд яадаг юм нөгөө компаниасаа шантаажилдаг юм уу эсвэл илүү торгуулдаг юм уу ингээд тэгээд эргээгээд тэр хүн нь өөрөө татварын байгууллагад 10 гаруй жил ажилласан туршилагатай байна гэдэг нь өөрөө татварынхантайгаа бүгдээрэнтэй нь нэвт сүлжээтэй хүнийг зөвшөөрөл өг гэж байгаа байхгүй юу. Тэгээд тэр компаниудыг бүгдийг нь эрсдэлд оруулна шүү дээ.

Зөвлөгөө өгч байгаа компаниудаа эрсдэлд оруулна. Энэ дээр ямар нэгэн эргээгээд тэр зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа этгээдээр хуулийн хариуцлагын асуудал юу байх вэ гэдгийг маш тодорхой оруулж өгөх өрсөлдөөн үүсэхгүй байх. Мэдээллийн чанад сахиулах. Ёс зүйг нь маш өндөр хэмжээнд барьж явуулахгүй бол та нар энд зүгээр шантаажны хууль батлах гэж байна шүү. Энэ асуудлуудыг энэ эрсдэлүүдийг яг юм яаж харж байгаа юм бэ? Энэ дээр нэг мэдээлэл өгнө үү?

Гурав дахь асуудал болохоор энэ зөвшөөрөлтэй холбоотой хэсэг ороод ирсэн байна л даа. Булгантуяа сайд зөвшөөрлийн ажлын хэсэгт бас жил гаруй хугацаанд маш идэвхтэй ажилласан. Тэгээд Зөвшөөрлийн хуулиар бол энэ Засгийн газрын дэргэд байгуулагдсан төр хувийн хэвшлийн хамтарсан үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэгдсэн байх ёстой. Салбар компани яг одоо тэр салбарын буюу аж ахуйн нэгжүүдийн хооронд ийм зөвшөөрөл байх шаардлагатай эсэх хэлэлцүүлэг хийчихсэн байх ёстой. Тэгээд ийм юм ерөөсөө харагдсангүй. Нэг хуулийг батлахдаа нөгөө хуулийг зөрчөөд яваад баймааргүй байна.

Зөвшөөрлийн хуулийг мөрдлөг болгохын тулд энэ чинь бүүр бүх байгууллагуудаар би хэчнээн ч удаа албан бичиг бичиж байна. Энэ 3 асуулт дээр би хариулт авчихмаар байна.

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ? Булгантуяа сайд хариулна.

**Х.Булгантуяа:** Ганхуяг гишүүний хэлж байгаа үнэн. Ганхуяг гишүүн нөгөө Нийтийн албанд ашиг сонирхлоос сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлд албан тушаалаас чөлөөлөгдсөний дараах эрхэлж болох ажлын хязгаарлалтуудыг бас тавьсан байдаг. Үүн дээр 21.1 дээр албан тушаалтан нь албан үүргээс чөлөөлөгдсөнөөс хойш 2 жилийн хугацаанд ашиг сонирхлын зөрчил үүсэж болох дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно гээд 21.1.1-д урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбоотой байсан аж ахуйн нэгж байгууллагад ажиллах 21.1.2-т урьд ажиллаж байсан байгууллагатай гэрээ онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, тухайн байгууллагаас олгодог зөвшөөрлийг хүсэх, 21.1.3-д урьд ажиллаж байсан байгууллагын өмнө аливаа хувь хүн хуулийн этгээдийг төлөөлөх гээд ийм байдлаар Нийтийн албаны тухай хуульд бас зохицуулалтуудыг нь тусгаж өгсөн байдаг.

Яах вэ, бид нар мэдээж манай бас тэтгэврийн нас юу билээ? Зарим салбараас бас нэлээдгүй эрт тэтгэвэрт гарч байгаа эдгээр хүмүүс үргэлжлүүлэн өөрийнхөө мэдлэг туршилагад үндэслэн ажил хөдөлмөр эрхлэхийг бид нар 100 хувь хорих бол бас энэ хүний хөдөлмөрлөх эрхэд бас нөгөө талдаа халдаж байгаа асуудал. Харин таны хэлж байгаа яг ашиг сонирхолтой байхын эсрэг байх ёстой гэдэгтэй бол санал бол нэг байгаад байгаа юм аа. Ер нь яах вэ энэ бас нэлээн нарийн зүгээр санхүүч болгон татварын мэргэжисэн зөвлөх байж чаддаггүй.

Тэгэхээр энд ажиллаж байсан татварын албанд ажиллаж байсан хүмүүс энэ чиглэлийн бас зөвлөх үйлчилгээ үзүүлээд явахад боломжтой юм аа. Харин эндээс гарч байгаа хүн болгон өмнөх ажил албан тушаалаа ашиглаад ингээд байна

гээж бас харж бас арай болохгүй байгаа юм. Бид нар яах вэ энд өөрчлөлт оруулж байгаа бас нэг гол шалтгаан нь 2020 оны 1 сарын 1-ээс хэрэгжиж эхэлж байгаа Татварын багц хуульд ялангуяа жишиг дунд бизнес эрхлэгчид маань жилд ганцхан удаа зарим нь хагас жилд ганцхан удаа тайлангаа мэдээлдэг, өгдөг болсон, тайлагнадаг болсон. Үүнтэй холбоотойгоор өөрөөр хэлбэл аж ахуйн нэгжүүд заавал нягтлантай байж тайлагнах энэ хэрэгцээ шаардлага нь багассан ч гэсэндээ нөгөө талдаа татвар төлөгч болоод бүртгүүлээд явж байгаа. 90 хувийнх нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлт нэг хувийн татвар төлж байгаа аж ахуйн нэгжүүд байгаа.

Тэгэхээр эдгээр аж ахуйн нэгжүүдэд татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ, санхүү тайлангийн ийм мэдээ, санхүү, тайланг нь гаргадаг татварын зөвлөх үйлчилгээний байгууллагатай хамтран ажиллах нь зүйтэй юм. Тэгэхээр энэ байгууллагын хууль эрх зүйн орчныг бид нар бас сайжруулж хариуцлагажуулах даатгалтай болох гэдэг. Ийм эрх зүйн орчнуудыг бид нар сайжруулж Цогтбаатар гишүүн гээд ингээд гишүүд тус хуульд хуулийн зохицуулалтыг тусгаж өргөн барьсан юм.

**Г.Занданшатар:** Хассуурийн Ганхуяг гишүүн тодруулж асууя. Нэг минут.

**Х.Ганхуяг:** Энэ манайхаас бусад оронд яах вэ манайх чинь мэргэшсэн нягтлан бодогчийн үнэмлэх гэж байдаг. Манайхаас бусад оронд мэргэжлийн. СРА, АСРА гээд л янз янзын үнэмлэхүүд бас олгож байдаг. Уг нь яг тиймэрхүү байдлаар шаардлага тавимаар байгаа юм аа.

Бид нар ингээд хууль хийхээрээ дандаа яг л төрийн нүдээр харж хууль хийгээд байгаа байхгүй юу. Яг л тэр хувийн хэвшилд нь ажилласан зовлон зүдгүүрийг нь мэддэг хүнээ энэ хуульдаа

орүүлж ажиллуулж энийг нь харж сонсдог болооч ээ. Яг ингээд энэ хууль чинь хэрэгжээд эхлэхээрээ яг саяын ярьсан зовлон үүснэ шүү. Цэрэг цагдаад ажиллаж байсан хүмүүс бүүр тэр өмгөөлөгч хийхээрээ эргээгээд л нөгөө хамгаалж байгаа хүнээ л хохироодог шүү дээ. Энэ талаасаа юмаа харж баймаар байна энэ хуулиа яг тэр талаас нь хардаг болгомоор байна аа.

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрөөтэй 24 санал байгаа.

Санал хураалт.

Тэлмүүн ээ чи НӨАТ-ын талаар надад мэдээлэл өгнө гээд уулзана гээд байхгүй байгаад байх юм. Чи нэг ийм асуултад хариулаадах л даа. Энэ жилийн 24 оны НӨАТ-ын буцаан олголтод 430 тэрбум төгрөг төсөвлөсөн байна тийм үү? НӨАТ-аас олгох нийт орлого 4.5 их наяд мөн үү. Мэдээж байна уу чи хуулиараа 20 хувийг буцаан олголтод зарцуулах ёстой юу. 4.5 их наядаас тооцвол 900 тэрбум байгаа биз. Та нар 430 тэрбум төсөвлөсөн байгаа биз. Тэгэхээр энэ чинь хууль зөрчиж байгаа юм биш үү? Буцаан олголтыг нэмэгдүүлэх боломж байгаа юм биш үү гэж би гээд хэлэх гээд байна. Энэ тооцоо судалгааг гаргаж танилцуулаарай за юу.

Та нар чинь зүгээр ингээд хатуу тоогоор ингэж бодож байдаг, хуультайгаа нийцүүлж бид нар шаардлага тавина.

Хоёрдугаарт нь бол далд эдийн засаг, татварын бааз суурийг өргөтгөх энэ үнийн өсөлт ард иргэдийн амьдралын хамгийн хүнд болчихоод байгаа үед энэ эдийн засгийг тэлэх, далд эдийн засгийг ил болгох татварын бааз суурийг

өргөжүүлэх тэгээд бүх юмыг л НӨАТ-аас чөлөөлөөд байдгаа бүгдийг нь НӨАТ төлөгч. Тэгэхдээ нийтээрээ НӨАТ-ынхаа ачааллыг бууруулах ийм бодлогыг боловсруулж танилцуулмаар байна. Энэ чинь жинхэнэ эдийн засгийг тэлэх либералчлахтай ч холбогдож гарч ирж байгаа л шүү дээ. Энэ дээр татварын мэргэшсэн зөвлөгөө өгдөг энэ үйлчилгээ чинь харин энэ Алтанзаяа Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн ерөнхийлөгч нар судалгаа хийгээд энэ ямар бололцоо байна гэдгээ яг бодитой гаргаж танилцуулмаар байна Алтанзаяа.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх ажлын хэсгийн зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.4.Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээг зөвхөн татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд эрхэлнэ.” Санал гарсан Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, Хүрэлбаатарын Булгантуяа. Санал хураалт явуулъя.

Санал хураалтын өмнө энэ Батжаргал гишүүн, Булгантуяа гишүүн 2 татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ гэдэг ингээд байна шүү дээ 12 үгтэй өгүүлбэртэй 10 татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээг 2 давтагдчихаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээг зөвхөн татварын

мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд эрхэлнэ ээ гэж байна шүү дээ тэ? Нэг үг хэмнэхэд татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээг зөвхөн тухайн тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд эрхэлнэ. Тэгвэл тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд эрхэлнэ гэх нь тухай асуудлаар гэдэг нь ойлгомжтой шүү дээ. Ингээд жоохон найруулчих асуудлыг бас хэлэлцүүлэгтээ анхаарна биз тэ.

Ингээд санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Энэ чинь ажиллахаа больчихсон байхад чинь. Төхөөрөмж ажиллахгүй байна. Санал хураалт тийм хүчингүйд тооцлоо. Үгүй ээ хүчингүй болгох санал хураалт явуулна. Яагаад гэхээр энэ санал Бат-Эрдэнэ гишүүн, минийх. Дэмжиж байгаа олон гишүүдийнх эсрэг гараад байна. Техникийн саатал, энийг хүчингүй болголоо. 26 санал хураалт.

53.7 хувийн саналаар хүчингүйд тооцлоо.

Санал хураалтыг дахиж явуулна яах вэ тэгээд татварын мэргэшсэн зөвлөгөө учраас бас тусгай зөвшөөрөл тэр ёс зүй нь ч бай, мэргэжлийн нь ч бай шаардлага тавигдах нь зүй ёсны л хэрэг байх л даа тийм ээ.

Ингээд санал хураалт явуулъя.

Саяын санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас санал хураалтыг дахиж явуулъя.

Санал хураалт 51.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ үдээс хойш бас хэлэлцэх асуудалтай. Тэгэхээр Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хууль гэж угаасаа байгаа байхгүй юу. Тэр хууль дээр нэмэлт, өөрчлөлтөөр л эрх



үүргийг нь л тодотгож байгаа тийм л заалтууд батлах гэж байгаа шүү дээ. 10 жилийн өмнө батлагдсан хууль.

2 дахь санал хураалтыг явуулъя.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.7.татварын тайлангийн нийцлийг хянах, шинжилгээ хийх.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Булгантуяа, Ганбаатар, Цэндийн Сандаг-Очир цаашид ажлын хэсэг гэнэ ээ.

Үг авахгүй. Дэмжсэн дэмжээгүй үг л хэлж болно. Амарсайхан гишүүн дэмжихгүй үг хэлэх. Сайнбуянгийн Амарсайхан гишүүн.

**С.Амарсайхан:** Энэ хууль бол хэрэгжээд явж байгаа. Нэмэлт, өөрчлөлт оруулж болно оо. Гэхдээ энд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа нэрээр татварын зөвлөх мэргэшсэн зөвлөх нэртэй хуулиар хамгаалагдсан хуульчлагдсан ийм аж ахуйн нэгжийн шимэгчид, бараг авлигачид гэж хэлж болох орон тоог бий болгож болохгүй ээ.

Энэ 4.3 дээр төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд энэ татвар хариуцсан ажилтан татварын мэргэшсэн зөвлөх байна гээд. Татварын ажилтан татварын төсөв санхүүгийн ажилтан, нярав, нягтлан байхад дээрээс нь заавал төрийн өмчийн компанид орон тооны зөвлөх гэж шахаад хэчнээн төрийн өмчит компани байгаа билээ. Орон нутгийн түвшинд хэчнээн 100 төрийн өмчит компани байгаа билээ. Энэ компани болгонд орон тооны мэргэшсэн зөвлөхүүд бий болох нь. Энэ нь өөрөө Засгийн газар, Их Хурлын нөгөө төрийн албан хаагчийн орон тоог цөөрүүлэх, мэргэшсэн, чадварлаг, цомхон байх, ил тод нэттэй байх гэдэг нөгөө бидний хуультай шууд зөрчилдөж байгаа.

Дараа нь дахиад цаашилах юм бол энэ 10 дугаар зүйл заалт ч бий. Хязгаарлагдмал хариуцлагатай компани салбартаа болон түүнд нэгээс багагүй орон тооны татварын мэргэшсэн зөвлөхтэй байна гэж. Энэ юу гэсэн үг юм? Яагаад заавал ийм заалт байгаа юм? Мэргэшсэн нягтлан бодохтой энэ ААН-үүд байна шүү дээ. Тайлан татвараа гаргаж өгдөг хязгаарлагдмал хариуцлагатай компани бол 3 түүнээс дээшгүй тооны хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл бол 2 түүнээс доошгүй тооны татварын мэргэшсэн зөвлөхтэй байна гээд.

Ингээд аж ахуйн нэгж, төрийн өмчит болон төрийн бус бүгд ААН-үүд хүчээр энэ хуулиар багадаа 3-аас 4 орон тоо бий болгох шаардлага болж байна. Тэрийг дагаад цалин хөлс зардал нь нэмэгдэнэ. Энийг дагаад нөгөө дарамт шахалт нь нэмэгдэнэ. Тэгээд зөвлөх нэртэй баахан татварын байцаагчид ирж аж ахуйн нэгж болгон дээр чимээгүй авлига авдаг, дээрээс нь захиргааны хэргийн шүүхийн ажлыг хийдэг хүртэл ийм буруу тогтолцоо руу орж байна шүү дээ.

4.6, 6.1.6 дээр үйлчлүүлэгчтэй холбогдсон татварын маргааныг шүүхийн болон захиргааны журмаар хянан шийдвэрлэхэд итгэмжлэлийн үндсэн дээр түүнийг төлөөлөн оролцоно оо гэж байгаа юм. Гэтэл энэ чинь өөрөө Иргэний болон захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуультай давхардаж үйл ажиллагаатай давхардаж байгаа ийм асуудал болчихоод байгаа байхгүй юу. Ийм заалтууд огт байж болохгүй. Энэ бол бид нар урагшлах биш ухарсан заалт. Энэ цэвэр хэдэн татварын мэргэжилтэн аягүй бол нэг л аудит хийдэг компаниудын лобби явж байна. Тэр битгий хэл одоо бид энэ улирал болгон ААН-үүд аудитаар тайлангаа батлуулдгийг болиулах хэрэгтэй. Тодорхой заалт юу зааж өгөөд, хэмжээ зааж өгөөд, тэрнээс дээших нь

хувьцаат юм уу эсвэл олон нийтийн болж байгаа бол аудитаар оруулдаг байхгүй бол бүх ААН-үүд үйл ажиллагаа явуулдаг ч бай, явуулдаггүй ч бай заавал аудитаар орж ирж тайлангаа татварт өгдөг. Тэрний цаана дандаа хүнд суртал, дандаа авлигал, дандаа нөгөө дарамт шахалт тэгээд дандаа үргүй зардал ААН-үүдээр гарч байгаа.

Хэрвээ бид олон улсын жишигээр явъя гэж байгаа бол энийгээ авч хаях хэрэгтэй өөрчлөх хэрэгтэй. Тэдэн тэрбумаас дээш орлоготой бол аудитаар орно, тэчнээн төгрөгийн борлуулалттай бол аудитаар орно гэж. Ингэхгүй болохоор бид нөгөө эхлэлийн бизнесүүд жижиг дунд бизнес эрхлэгч чинь ерөөсөө хөгжихгүй. Энэ татварын өмнөх аудитын тайлан, энэ татварын өмнөх дарамтууд, татвар аудит дагасан элдэв янзын үргүй зардлаас болж бүгд сөхөрч унаж байгаа. Энэ зах зээлийн эдийн засгаас ухарсан асуудал болж байгаа. Яг энэ бол лоббины хууль байна шүү. Энэ би бүүр зориуд тодорхой хэлчихье. Лоббины хуульчлагдсан авлигал хээл хахуулийн сүлжээ бий болгох энэ дунд татварын байгууллага шүүхийн байгууллагуудыг хүртэл чирэх хэмжээний ийм буруу жишигийн хууль болж байна шүү. Энийгээ санаачлагч нь энэ заалтуудаа татаж аваарай гэдгийг хэлье.

Үг хэлэх хүмүүс, Булгантуяа гишүүн, Цогтбаатар гишүүн.

Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн.

**Х.Булгантуяа:** Амарсайхан гишүүний саяын хэлсэн энэ нөгөө манай Байнгын хороон дээр Төсвийн байнгын хороон дээр дэмжигдээгүй санал байж байгаа. Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн татвар хариуцсан ажилтан татварын мэргэшсэн зөвлөх байна гээд. Энэ яах вэ төрийн болон төрийн өмчийн оролцоотой томоохон хуулийн компани, томоохон

ААН-үүд бол улсын томоохон хэмжээний ААН-үүд татвар төлөгчид байдаг. Ингээд мэргэшсэн биш, чадварлаг биш хүмүүсээс болоод бас үнэнийг хэлэхэд яах вэ? Жижиг ч тэр том ч тэр ААН-үүд татварын маргаан үүсдэг алдаа оноо гаргадаг ийм зүйлүүд байдаг учраас хэрвээ нэгэнт л татварын мэргэшсэн зөвлөх гэдэг ийм нарийн мэргэжил, мэргэшил байгаа юм бол ялангуяа ТӨК-удад бас байх нь зүйтэй юм гэж ажлын хэсэг дээр манай ажлын хэсгийн зарим гишүүд бас санал гаргасан юм аа. Гэхдээ энэ юун дээр бол дэмжигдээгүй.

Таны түрүүний хэлж байгаа нөгөө тэдэн хүнтэй байна энэ тэр гэвэл энэ мэргэшсэн зөвлөхийн эрхтэй компани хэрвээ салбар ажиллуулах юм бол аймаг орон нутагт ч байдаг юм уу, салбар ажиллуулах юм бол тэндээ заавал нэг мэргэшсэн зөвлөх ажиллуул гэсэн ийм санаа нь хувийн хэвшилд өөрөөр хэлбэл үүрэг өгөөгүй. Энэ үйлчлүүлэгчид үүрэг өгөөгүй. Мэргэжлийн зөвлөгөө үзүүлэх гэж байгаа компани юм бол үүнд үүрэг өгсөн гэсэн ийм үүрэг даалгавраар орж байна гэсэн үг.

Ер нь яах вэ манай одоо энэ шинэ татварын хуулиар чинь компани болгон заавал нягтлантай, санхүүгийн нарийн мэргэжлийн хүнтэй гэсэн ч компаниуд ААН-үүд заавал тайлагнадаг бүртгэлтэй бас байдаг. Тэгэхээр ийм хүмүүсээр авч зөвлөгөө өгнө. Харин зөвлөгөө өгч байгаа энэ хүмүүс маань илүү их мэргэшсэн байна гэдэг утга агуулгыг л агуулж байгаа юм. Итгэмжлэлээр татварын маргаанд компани бас өөрөө ч орж ордог зөвлөгч оруулдаг. Нарийн төвөгтэй татварын эрсдэл өндөртэй хяналт, шалгалт, акт, маргаанд зөвлөхийн туслалцаа зайлигүй шаардлагатай байдаг. Төр хүртэл ийм маргаанд шүүхийн маргаан дээр манай төрийн зарим байгууллагуудаас жишээлбэл Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газраас гэх мэтчилэн мөн Татварын ерөнхий газраас гээд энэ

нарийн мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулдаг.

Тэгэхээр аудит дээр бол бүх компани дээр бас энийг үүрэг болгоогүй байж байгаа. Цэлмүүн дарга нэмж хариулах уу? Энэ нөгөө тусгай зөвшөөрөлтэй ААН-үүдийн хувьд гэсэн үг үү?

**Г.Занданшатар:** Энэ Засгийн газраас өгсөн саналд энэ асуулт хариулт байхгүй л дээ. Үгүй ээ дэмжсэн, дэмжээгүй гэж байгаа. Засгийн газраас дэмжсэн санал дээр Засгийн газраас тийм санал өгчихсөн юм байна шүү дээ. Өөрөөр хэлбэл энэ монополийг зарлах хуулийн этгээд зөвхөн хуулийн этгээдэд татварын зөвлөх үйлчилгээ өгөх зөвшөөрөл өгдөг байсныг иргэн, хувь хүн олгож болно. Зөвхөн том компаниуд л сайн татварын мэргэшсэн нягтлан бодогчтой байгаа болохоос биш жижиг компаниуд нягтлан бодогч ажиллуулдаггүй. Тэрийгээ зөвлөх үйлчилгээгээр байнгын мэргэшсэн нягтлан бодогч ажиллуулахгүйгээр гэрээгээр ажиллуулдаг. Зөвлөх үйлчилгээ авдаг ийм дэлхий нийтийн жишиг бусад бүх улсад л татварын зөвлөх үйлчилгээ гэж байж байдаг.

Тэгээд тэрийг нь ингээд өрлөг хувь хүнд өгөх юм бол тусгай зөвшөөрөлтэй хариуцлагатай байна гээд Засгийн газрын санал өгчихсөн юм байна шүү дээ. Тэгээд энэ чинь зөвхөн татварын тооцоолол хийх асуудал чинь зөвхөн тэр компаниудыг дэмжиж байгаагаасаа гадна татварын албаны ажлыг хөнгөвчилж байна шүү дээ. Зөв зүйтэй мэргэшсэн түвшний тайлангууд ирж байвал энэ татварын албаныхаа ажлыг хөнгөвчилнө гэж үзэж аль аль талаасаа л энэ хэрэгцээтэй шаардлагатай зах зээлийн нийгэмд байдаг л ийм үзүүлэх үйлчилгээний арай мэргэшсэн төрөл л гэж үзсэн юм шиг байна. Ингээд энэ Засгийн газрын санал хуулийн танилцуулга үзэхээр. Гучин наймхан компани байгааг

1500 гаруй хувь хүнд тийм ч зөвшөөрөл олгож болох бололцоотой.

Мэргэшсэн зөвлөх хуулийн тодорхой нөхцөл шаардлага хангасан бол тэгэхээр тэр нь тэр нь бас нэг тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай л гэсэн тийм л агуулгаар санал өгөгдөөд л анхны хуулийн төсөл дээрээ Цогтбаатар гишүүний санал дээр тийм саналууд нэмэгдээд л тэрнийг нь үзэж харж байгаад л энэ Ажлын хэсэг нэмсэн юм шиг байна л даа. Зөвшөөрөл нь одоо байгаа юм уу? Зөвшөөрлийн хуульд одоо байгаа юм байна тэгээд? Тэгэхээр зөрчил нь гайгүй. Тэгээд Татварын мэргэшсэн зөвлөгөө өгөх үйлчилгээний нийгэмлэг нь бас тэр хариуцлага энэ тэр дээрээ хамтарч хүлээдэг байх энэ тэрнийг нь үндэслэж зөвшөөрөл энэ тэр олгодог байх зохицуулалт л хийсэн юм байна л даа. Тэлмүүн дарга.

Татварын бодлогын газрын дарга Сангийн яам. 82.

**Б.Тэлмүүн:** Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн. Цогтбаатар гишүүний өргөн барьсан хууль дээр Сангийн яамнаас Засгийн газраас бол ажлын хэсэгт ороод ажилласан. Манай дийлэнх саналууд туссан байгаа. Эдгээр саналууд яг гишүүдийн хэлж байгаа үндсэн асуудлууд бүгд туссан. Жишээлэх юм бол Амарсайхан сайдын хэлж байгаа энэ заалтыг бид нар дэмжихгүй. Энэ өөрөө энэ хуулиар ямар нэгэн байдлаар хувийн хэвшилд зардал нэмэгдүүлэх ийм хүчилсэн үүрэг болгосон заалт огт байж болохгүй гэдэг агуулгаар энэнтэй холбоотой заалтуудыг хассан. Түрүүний хэлдэг тэр салбар төлөөлөгчийн газартаа мэргэшсэн зөвлөхтэй байна гэдэг нь одоо бид нар орон нутагт ийм мэргэшсэн зөвлөхүүд 37 мэргэшсэн зөвлөх компани байдаг. Орон нутагт салбар ажиллуулахад тэндээ заавал нэг мэргэшсэн зөвлөх эрхтэй хүн ажиллуулаарай гэдэг. Ийм компанид нь үүрэг болгосон заалт байгаа.

Ёс зүйтэй холбоотой заалтуудыг бид нар энд саналын томъёоллын нэлээн олон газар тусгасан байгаа. Тэгэхээр ёс зүйтэй холбоотой хариуцлагын асуудал бол нийгэмлэг дээр бол үүрэг нь нэмэгдэж байгаа.

Дараагийн нэг асуудал нь татварын байцаагчтай холбоотой асуудлууд сая 1 хэд хэд хөндөгдсөн. Энэ дээр залруулж хэлэхэд татварын байцаагчид шууд энэ мэргэшсэн зөвлөхийн эрх олгох тухай энд огт байхгүй.

Татварын байцаагч ажил эрхэлснээсээ хойш 2 жилийн хугацаанд өмнө нь эрхэлж байсан ажилтайгаа холбоотой ажил угаасаа эрхлэх хуулиараа хориотой байдаг. Тэгэхээр энэ хуулийн төсөлд юу гэж орсон бэ гэхээр энэ мэргэшсэн зөвлөхийн шалгалт өгөхөд баас 7 төрлийн хичээлийн шалгалт өгдөг. Үүнээс зөвхөн татварын удирдлага, татварын онол гэсэн шалгалтыг нь чөлөөлж болох юм. Олон жил ажилласан татварын байцаагч гэсэн ийм агуулгаар орсон.

Тэгэхээр өөрөөр хэлэх юм бол энэ хуульд хувийн хэвшилд ямар нэгэн дарамт ачаалал нэмсэн заалт байхгүй. Энэ цэвэр хувийн хэвшил өөрсдийн сонголтоор энэ зөвлөх үйлчилгээг авах эсэхээ шийддэг. Энэ харилцаа нь хэвээрээ байгаа гэж хэлмээр байна аа. Баярлалаа.

**Г.Занданишатар:** Цогтбаатар гишүүн үг хэлэх юм уу? Дамдины Цогтбаатар гишүүн.

**Д.Цогтбаатар:** Энэ нөгөө зөвхөн компаниудаар өгдөг байсныг ер нь зүгээр энгийн зах зээлийн зарчим. Гучин хэдхэн компани байсныг олон болгоод ирэхлээр үнэ шууд л буурна. Харин гучин хэдхэн байгаа гэдэг чинь жинхэнэ хязгаарлагдмал тоотой нэг төрлийн монополь маягийн болчхож байгаа байхгүй юу. Тэр гучин хэд дотор орлоо.

Зах зээл дээр шууд давамгайлах байр суурьтай. Өнөөдрийн байгаа тогтолцоо чинь энэ. Энэ нөгөө хувь иргэдийг зөвлөгөө өгөх боломжийг нээж өгч байгаа чинь хамгийн гол нь хөдөө орон нутагт ажиллаж байгаа хүмүүст энэ том хотод байгаа компаниуд чинь зөвлөгөө өгдөггүй байхгүй юу. Тэнд зөвлөгөө хэрэгтэй байгаа байхгүй юу.

Тэгэхлээр тэр хөдөө орон нутагт хүмүүс зөвлөгөө өгөх боломжийг нь гаргаж өгөх үүднээс энэ салбар нь өөрөө энэ асуудлаа оруулж ирсэн байхгүй юу. Тэгэхлээр энэ бусад орнуудад яг үнэн яг ийм юм байдаг байхгүй юу. Хувь хүмүүс өгдөг тэр нь хамаагүй хямдхан оюутнууд хүртэл аваад НӨАТ-ын буцаан олголтоо авч байдаг байхгүй юу. Оюутан гэдэг чинь төлбөрийн чадвар маш багатай хүмүүс. Гэхдээ НӨАТ-аа буцаан авах юун дээрээ энэ зөвлөгөөгөө авах боломжууд байж байдаг байхгүй юу.

Тийм учраас л энэ дээр тэр хувь хүмүүс өгөх боломж нээгдэж байгаа чинь зах зээл дээр тэр зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа хүмүүсийн тоог нэмж өгч нийлүүлэлтийг нь нэмж өгч байгаа. Тэгэхлээр үнэ буурна л гэсэн үг.

**Г.Занданишатар:** Санал хураалт явуулъя.

Энэ чинь байна шүү дээ 2 дахь санал хураалт шүү дээ.

Татварын тайлангийн нийцлийг хянах шинжилгээ хийх гэдгийг өөрчлөн найруулж байгаа юм байна шүү дээ.

Төслийн санал нь бол төсөл дээр 6.1.7 чинь татварын тооцоо бүртгэл тайлангийн эрх зүйн нийцлийг нягтлах, шинжилгээ хийх татварын төлөвлөлт хийх гэсэн заалтыг татварын тайлангийн нийцлийг хянах шинжилгээ хийх гэж өөрчилж байгаа л юм байна.

Ингээд санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Энэ санал дэмжигдсэнгүй. Төслөөр үйлдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 10.1.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.1.9.хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч нь Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын, хувь хүний нууцад халдах, хувь хүний нууцыг задруулах, залилах, хөрөнгө завших болон эдийн засгийн гэмт хэрэг үйлдэж, шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Энэ санал уначихаар чинь энэ төслөөрөө үлдэх юм бол энэ тавигдах шаардлагыг бүүр сулруулаад авлигал, албан тушаал, хувь хүний нууц задлах, залилах, хөрөнгө завших энэ тэр гэдгийг чинь бүгдийг нь ингээд чангаруулсан заалтыг дэмжсэнгүй шүү дээ. Ингээд 13 цаг болсон учраас энэ чуулганы нэгдсэн хуралдааныг завсарлалаа.

14 цагаас чуулганы нэгдсэн хуралдааныг үргэлжлүүлбэ.

## ЗАВСАРЛАГА

**Г.Занданшатар:** Гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 10 дугаар сарын 12-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан эхэлснийг мэдэгдье ээ.

Санал хураалт үргэлжилж байгаа.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 10.1.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.1.9.хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч нь Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын, хувь хүний нууцад халдах, хувь хүний нууцыг задруулах, залилах, хөрөнгө завших болон эдийн засгийн гэмт хэрэг үйлдэж, шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх.” Санал гаргасан ажлын хэсэг.

Энэ татварын мэргэшсэн зөвлөгөө үзүүлж буй төв этгээдэд тавигдаж байгаа нийтлэг шаардлага байна. Ажлын хэсгийг оруулаарай.

Үдээс өмнө нэг цагаас энэ цаг болсон ирц шаардлага хангахгүй байна гэж энэ санал хураалтыг хойшлуулчихсан байгаа. Хүчингүй болгох санал хураалт явуулах ёстой. Дэмжсэн, дэмжээгүй тухай асуудлаар 3 хүн үг хэлж болно. Цогтбаатар дарга Сайнхүүгийн Ганбаатар. Картаа уншуулаагүй юм биш үү? Сайнхүүгийн Ганбаатар гишүүн үг хэлнэ. Өөр үг хэлэх хүн бий юу? Сайнхүүгийн Ганбаатар гишүүн үг хэлнэ.

Биш Дамдины Цогтбаатар гишүүн үг хэлнэ.

**Д.Цогтбаатар:** Би гишүүддээ хандаад бас энэ нөгөө хуультай холбогдуулаад нэг юм тайлбарламаар байгаа юм. Харин энэ салбарынхан чинь энэ ингээд нэг өөрсдөдөө тусгай эрх олж авах гэсэн хүмүүс орж ирж байна гээд энэ чинь 10 жил энэ хууль чинь тусгай зөвшөөрөлтэйгөөр угаасаа явж ирсэн тэгээд тэр тусгай зөвшөөрлийнхөө хуульд тусчихсан байгаа юм шүү. Түүнээс нэг энэ хэдэн хүмүүс тусгай зөвшөөрөлгүй байсан юмыг тусгай зөвшөөрөлтэй болгож оруулж ирж байгаа юм шиг ийм бас жоохон ташаа ойлголт явсан байна.

Тэгэхлээр энэ дээр энэ угаасаа ийм хуультай цаад Тусгай зөвшөөрлийн хуулиараа зохицуулагдсан байж байгаа зүйл шүү. Нөгөө талаасаа энэ үнэхээр зах зээлээ харин либералчилж өгч энэ хүмүүс чинь 39 байна уу даа компани. Монголын

бүх аж ахуйн нэгжүүдэд үйлчилгээ үзүүлдэг тусгай эрхтэй хэдэн хүмүүс сууж байгаа байхгүй юу. Харин энийгээ задалж өгөөд энд оролцогчдын тоог нэмэх тухай ялангуяа хувь хүмүүсээр зөвлөгөө өгүүлэх тэр боломжийг нь нээж өгсөн ийм хуулийн санаачилга орж ирж байгаа.

Энэ чинь тэгэхлээр ахиад л нөгөө ёстой хөдөө орон нутагт захын аймгууд эд нарт хүмүүс бизнес хийж л байгаа. Тэрэн дээрээ хариуцлага одоо тайлан тооцоогоо нэг буруу гаргачихвал тэгээд тэр хүн чинь эрүүгийн хариуцлага хүлээгээд явчих аягүй эрсдэлтэй. Тэгэхэд тэнд нь харин мэргэшсэн зөвлөгөө үзүүлэх хүн байж байвал тэндээсээ зөвлөгөөгөө аваад бизнест нь харин хэрэгтэй тэр бизнесийг нь хөдөө орон нутагт хүргэж өгч байгаа. Буруу байвал бизнес биш нөгөө тусгай зөвшөөрөлтэй хүн буруу зөвлөгөө өгснийхөө хариуцлагыг хүлээнэ шүү дээ. Ийм юутай.

Энэ төрийн өмчит ААН-үүд дээр нэг шинэ орон тоо нэмэх гэж байгаа юм шиг ийм юм яригдаж байна. Огт тийм биш шүү. Төрийн өмчит угаасаа ААН-үүд дээр татварын ажилтан гэж байгаа. Тэрэн дээр нь шаардлагыг нь л нэмж өгч байгаа. Өөрөөр хэлбэл тэр төрийн өмчит аж ахуйн нэгжийн татварын ажилтан нь харин мэргэшсэн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг хүн байна шүү гээд. Тэгэхгүй бол харин ёстой энэ төрийн өмчит ААН-үүд дээр чинь цүнх баригчид очоод байгаа байхгүй юу. Тэгэхлээр тэд нар чинь ёстой буруу тооцоо хийнэ, тоог нь нууна, нуун дарагдуулахад оролцоно. Тэгэхэд энэ тусгай ийм зөвшөөрөлтэй хүмүүс чинь 1 тэгчихвэл насныхаа хоолноос салах байхгүй юу. Тэр хүмүүс чинь тэгэхлээр амьдралаа бодоод тийм худлаа тоо баримтад оролцохгүй шүү дээ.

Тэгээд угаасаа байгаа орон тоог нь л шаардлагыг нь нэмж өгч байгаа ийм зүйлүүд орж ирж байгаа шүү. Тэгээд энийг манайхан бас зөвөөр нь ойлгоод яг л

баруунд байдаг энэ татварын тогтолцоо хөгжсөн орнуудад байдаг энэ тогтолцоогоо зүгээр боловсронгуй болгож л оруулж ирж байгаагаас тэр аймаар суурь юмнууд эд нарыг бас өөрчлөөд байсан юм байхгүй шүү.

**Г.Занданшатар:** Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

**С.Ганбаатар:** Энэ хуулийг дэмжиж байгаа, дэмжээсэй гэж бодож байна. Учир нь гэвэл 2013 онд шиг санаж байна. Энэ хууль орж ирэхэд би бас санаачлагчдынх нь нэг явсан. Тэгээд энэ ингээд энэ талаар бас ингээд хөөцөлдөөд явж байсан.

Нэг жишээ ярья. Америкт хамгийн том мафийн гэмт хэрэгтнүүд бүүр айхтар том том хэргүүд хийчихсэн байхад ганцхан зүйлээр бурууддаг нь улсад татвар төлөөгүй ээ л гэдэг юм байдаг. Энэ өөрөө төр л байгаа татвар байгаа гэсэн үг. Энэ мэдээж энгийн хүн болгонд ойлгомжтой байх. Гэхдээ татварыг өнөөдөр стандарттай, хариуцлагатай, мэргэшсэн байлгах бол энэ төрийн үүрэг байдаг аа. Тэгээд өнөөдөр төрийн өмчийн компаниуд дээр орон тоо нэмэх гээгүй. Ерөөсөө л татвар хариуцсан хүн нь мэргэшсэн байгаач ээ, хариуцлага үүрэх чадвартай байгаач ээ. Ямар ч байсан мэргэжлийн байгаач ээ гэдгийг л бий болгох гэж энэ хууль орж ирж байгаа юм.

Өөрөөр хэлбэл дараа нь хариуцлага тооцоход би мэдээгүй, би чадваргүй, би энэ тухай ойлгоогүй гэж хэлэх ямар ч үндэслэлгүй болгох гэж энэ хууль орж ирж байгаа.

Хоёрдугаарт ерөөсөө энэ 2 дугаар асуудал нь жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид одоо хувийн хэвшил дээр бүгдээрээ татвар хариуцсан заавал нэг мэргэжилтэнтэй байгаарай гэж энэ хууль орж ирээгүй. Харин татварын талаар мэргэшсэн, хариуцлагатай, хэлж байгаа үгийнхээ төлөө төрийн өмнө

хариуцлага үүрэх чадвартай тийм мэргэшсэн хүмүүсээс зөвлөгөө аваарай гэж энэ хууль орж ирж байгаа юм. Энэ утгаараа энэ хуулийг дэмжээд явах нь Монгол Улсад татвар нэмэгдэнэ. Татварын асуудал илүү хариуцлагатай илүү мэргэшсэн байдалтай болно гэдэг энэ байдлаар дэмжиж өгөөсэй гэж дэмжиж үг хэлж байна.

**Г.Занданшатар:** Баагаагийн Баттөмөр гишүүн үг хэлье.

**Б.Баттөмөр:** Энэ Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийг бид нар өнөөдөр ингээд хэлэлцээд явж байгаа. Энэ бол байх ёстой хууль. Түрүүн ярьсан шүү дээ нөгөө татварын шинэчлэлүүд хийгдчихсэн. Татвартай холбоотой энэ мөнгө угаах болон бусад хууль тогтоомжийн шинэчлэлүүд бол ингээд хийгдээд яваад байгаа. Тэр ФАТФ энэ тэр гээд 40 зөвлөмж, мөнгө угаахтай тэмцэх гээд энд шинэчлэлийн юмнууд хийгдээд яваад байгаа юм. Тэгээд ингээд энэтэй зэрэгцэж хийх ёстой юмны нэг нь зөвлөх үйлчилгээний юм байгаа юм. Хүн болгон санхүүч байж чадахгүй ээ. Компани бизнес эрхэлж байгаа хүн болгон нь санхүү бүртгэл мэдэхгүй байгаа шүү дээ.

Тийм учраас тэдэнд тусалдаг ийм байгууллага энэ утгаар нь. Зүгээр энийг дагуулж ингээд л нэг тийм мэргэшсэн байна заавал хүн байна гэсэн ийм юм байж болохгүй ээ. Энэ татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээг хуулийн этгээд гүйцэтгэнэ гэж. Энэ зүйтэй. Хувь хүмүүс гүйж очоод л энд тэнд очоод ингэх нь хариуцлагагүй явдал болно.

Тийм учраас энэ заалт зүйтэй. Энэ хуулийн этгээд гэдгийн цаад талд хариуцлагын асуудал. Ёс зүйн асуудлууд ингээж гарч ирж байгаа юм. Тэгээд энийг бол ингээд дэмжээд явах нь зүйтэй гэж ингээж бодож байгаа юм. Энэ татварын мэргэшсэн үйлчилгээгээр татвар төлөгч үүргээ биелүүлэх татвар төлөгчийн хууль

ёсны эрх ашгийг хамгаалах тэгээд дээрээс нь энэний бас нэг онцлог нь юу вэ гэхээр зэрэг татварын мэдлэг олгох. Санхүү эдийн засгийн мэдлэг олгох үйл ажиллагаа. Энэ чинь бас явагдаж байгаа шүү дээ. Маши их боломжууд байгаа.

Энэ боломжуудыг бол манай бизнес эрхлэгчид бол ашиглаж чадахгүй байгаа. Санаатай санамсаргүй татвар нуусан хэрэгт ордог татварын нөгөө ноогдох орлогоос хасагдахгүй зардлуудыг санаатай санамсаргүй байдлаар хасдаг. Энэнээс болоод асуудлууд үүсдэг. Ийм л юм байгаа юм л даа. Тэгээд энэний бас нэг онцлог нь юу вэ гэхээр энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийн бас нэг сайн хэлбэр энд явж байгаа юм аа.

Төр бол бас энэ хяналтын үүргээ, төрийнхөө үүргийг хувийн хэвшил болон бусад байгууллагуудаар хийх ийм боломжууд энэ дээр гарч ирж байгаа юм. Энэ анх орж ирсэн саналууд их аятайхан саналууд орж ирсэн. Тэгээд баахан юмнууд л нэмээд л 24 саналтай гээд ингээд явчихсан байгаа. Энэ тэрийг шүүж үзээд энэ хуулийн өөрчлөлтийг нэмэлтийг гаргах нь зүйтэй гэж би ингэж бодож байна.

**Г.Занданшатар:** Санал хураалтад бэлтгэе.

Ер нь хэлэлцэх эсэх асуудлыг бол хэлэлцээд дэмжчихсэн, 1 дүгээрт.

Хоёрдугаарт анхны хэлэлцүүлэг явуулж байгаа. 24 зарчмын зөрүүтэй саналтай. Гэтэл саяын энэ 3 дугаар саналыг бол энэ хууль бараг хэрэгтэй юм уу хэрэггүй юм уу гэж байгаад ингээд унагаачихлаа л даа. Тэгэхээр хүчингүй болгож дахин санал хураалт явуулна.

Тэгэхдээ 1 мэдээлэл өгөхөд манай ажлын хэсэг ч тэр, гишүүд ч тэр бас хариуцлагатай хандмаар байгаа юм. Сая Баттөмөр гишүүн хэлж байна. Энэ 10 жилийн өмнө батлагдсан хууль. Тэгээд

энэ хуульд Зөвшөөрлийн тухай хуультай нийцүүлээд өөрчлөлт оруулчихсан байгаа юм.

Тухайлбал Татварын зөвлөгөө өгөх үйлчилгээний тухай хуулийн 2.1-д энэ харилцааг Үндсэн хууль, Татварын хууль, Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна гээд. Тэгээд Зөвшөөрлийн тухай хууль гэж хуучнаар ААН-ийн тухай Зөвшөөрлийн тухай хууль гэж энд өөрчлөөд Зөвшөөрлийн тухай хууль гээд заачихсан.

Хоёрдугаарт нь 12.2-т нь татварын мэргэшсэн зөвлөгөө үзүүлэх тусгай зөвшөөрөл олгох хугацааг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна гээд заачихсан. Тэгээд ийм яамны юмнуудыг энэ ажлын хэсэг ч хариулдаггүй хоорондоо ч ярьдаггүй. Ингээд нэг буруу ойлголцол үүсгээд хуулийн хэлэлцүүлэгт их хариуцлагагүй хандаж байгаа гээд зарим гишүүдэд ийм асуудал яриад байгаа гишүүд сайд нарт бас онцгой анхааруулж хэлмээр байна.

Энэ чинь 10 жилийн өмнө харилцаа нь яваад хэрэгжээд тендерээ сайжруулах заалтууд нь ороод Засгийн газрын саналын дагуу саналууд ороод хэлэлцэгдээд явж байхад ингээд тэс хөндлөн юм яриад ингээд унагаагаад байдаг. Тэгээд энэ тухайлсан заалтын хувьд бол 11-ээс зүгээр л энэ хуулийн Татварын мэргэшсэн хуулийн тэдэд заасан шаардлагыг хангасан байх ёстой гэсэн тийм шаардлага байсныг л илүү чангаруулж хувь хүн болж байгаа учраас хувьцаа эзэмшигч эцсийн өмчлөгч нь Эрүүгийн хуульд заасан авлига албан тушаалын хувь хүний нууцад халдах, хувь хүний нууцыг задруулах, залилах, хөрөнгө завиших эдийн засгийн гэмт хэрэг шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байна гэсэн ийм л заалт байгаа юм.

Санал хураалтдаа бэлдэнэ үү.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнийн урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын 51 дүгээр сургуулийн 11-ийн Б ангийн багш сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Хүндэт сурагчид та бүхэндээ сурлагын, спортын соёлын, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе өө.

Сурах чиглэлийг эрхэм болговол хандах зөв чинь өөрөө тогтоно.

Ингээд санал хураалт явуулахад бэлэн болж байна уу?

Аубакир гишүүн орж ирсэн.

Санал хураалтыг эхлүүлэе. Аубакир гишүүн 36 минут 27 секунд хоцорлоо. санал хураалт явуулъя.

Баделхан гишүүн үүнээс хойш Аубакир гишүүнийг цагт нь чуулганд ирүүлж байя. АН-ын бүлгийн гишүүдийг дуудъя.

Санал хураалт.

56.1 хувийн саналаар өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцно. Санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас санал хураалтыг дахиж явуулъя.

Санал хураалт.

56.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 11.2, 11.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.2.Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд нь татвар төлөгчийг татварын эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар татвар төлөгчдөд мэдээлэл өгөх үүрэгтэй бөгөөд



Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн гишүүн байна.

11.3.Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд нь даатгалын байгууллагаа өөрөө сонгож, мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулна.” Санал гаргасан ажлын хэсэг.

Булгантуяа гишүүн үг хэлнэ.

**Х.Булгантуяа:** Дарга энэ дээр дахин боловсруулах чиглэл авах гэсэн юм. Энэ дээр нэмэх юм байна ажлын хэсгийн зүгээс.

**Г.Занданшатар:** Энэ татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийг ингэж бас түрүүний яриа шүүмжлэл гараад байсныг сайн үзэхгүй бол, статусыг нь сайн үзэхгүй бол өөрөө ямар хариулттай байгууллага юм.

Тийм учраас энэ асуудлыг гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 12.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.1.8.хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч, орон тооны татварын мэргэшсэн зөвлөх нь ёс зүйн зөрчилгүй талаарх Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн тодорхойлолт.” Санал гаргасан ажлын хэсэг. Ёс зүйн зөрчлийг татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг гэж тодруулах юм уу?

Санал хураалт.

Тэгвэл татварын мэргэшсэн зөвлөх нийгэмлэг нь ёс зүйн хороотой байх хэрэгтэй.

53.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын “12.1.9”, 10 дахь заалтын

“18.2.9” дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

53.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ёс зүйн зөрчилгүй эсэх талаар татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн тодорхойлолтыг.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 14.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.7.Татварын улсын байцаагчийн ажил, албан тушаалд 10-аас дээш жил ажилласан бол татварын албаны тодорхойлолтыг үндэслэн энэ хуулийн 15.1.3-т заасан хоёроос дээшгүй шалгалтаас чөлөөлж болох бөгөөд уг харилцааг татварын мэргэшсэн зөвлөхөд эрх олгох, сунгах, шалгалт авах журмаар зохицуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Энийг гүйцээн боловсруулах чиглэл өгье. Энэ шударга тэгш байх зарчим. Татварын улсын байцаагчид давуу байдал олгож байгаа юм. Гүйцээн боловсруулах чиглэл өгье.

Санал хураалт.

8.Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтын 16.1.7, 9 дэх заалтын 17.1.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.1.7.татварын хууль тогтоомж, түүний өөрчлөлт, татвар төлөгчийг татварын эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар татвар төлөгчдөд сурталчлан таниулах, мэдээлэл өгөх.

17.1.6.Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаал, хувь хүний нууцад халдах, хувь хүний нууцыг задруулах, залилах, хөрөнгө завших болон эдийн засгийн гэмт хэрэг үйлдэж,

шүүхээр ял шийтгүүлсэн, хувь хүний орлогын албан татварын тайланг хуульд заасан хугацаанд гаргаагүй.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

51.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Шуурхай явъя. Дараа Төрийн байгуулалтын байнгын хороо санал, дүгнэлтээ бэлдэж байгаарай. Орон нутгийн сонгуулийн тухай хуулиа хэлэлцэнэ.

9.Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 18.2.10 дахь заалтын “шаардлагын хэм хэмжээг” гэснийг “шаардлагад холбогдох журмыг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

53.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн 2 дугаар зүйлийг төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалт болгон шилжүүлж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.5.тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд нь өөрчлөн байгуулагдсан, татан буугдсан, эцсийн өмчлөгч өөрчлөгдсөн болон энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан мэдээлэл өөрчлөгдсөн бол энэ тухайгаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр мэдэгдэх.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Балжиннямын Баярсайхан гишүүн.

**Б.Баярсайхан:** Дарга төхөөрөмж ажиллаагүй тул миний санал орсонгүй. Саналыг хүчингүйд тооцож дахин хураалгаж өгнө үү. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Энэ төхөөрөмжийг ер нь нэг шинэчлэхгүй бол болохгүй байгаа юм. Энэ төхөөрөмж маань хугацаа нь дуусчихсан байгаа юм.

Хугацаа нь дуусчихсан тэгээд ахиж үйлдвэрлэхээ больчихсон төхөөрөмж юм байна лээ.

Баярсайхан гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Хүчингүй болгох санал хураалт.

56.1 хувийн саналаар саналыг хүчингүйд тооцсон байна.

Ингээд саналыг дахин хураалт явуулъя аа.

Энэ чинь 11 дэх заалт. 10 дахь заалт. Аубкир гишүүн сүүлийн 3 санал зориуд эсэргүүцэж байгаа юм. Яах вэ тэгж л байг. Энэ жоохон шүүмжлүүлчхээд нэг үг даахгүй байна уу үгүй юу? Тэгээд үндэсний цөөнх гээд хайрлаж энхрийлээд байх тусам жоохон.

Тэгвэл Аубакир гишүүн.

**Т.Аубакир:** Би сая дэмжиж санал өгсөн юм. Энэ аппарат уул нь гайгүй ажиллаад байсан сүүлийн үед жоохон гацаад байх шиг байна. Дарга дахиад санал хурааж өгнө үү.

**Г.Занданшатар:** Энэ сүүлийн үед ингээд байгаа нь энэ аппаратдаа байна уу эзэнд нь байна уу гэдгийг тодруулаарай.

Аубакир гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Хүчингүй болсонд тооцно. 56.1 хувийн саналаар санал дэмжигдлээ. АН-ын бүлгээс Дашидондогийн Ганбат гишүүн ганцаараа оролцож байгаад сайн байна. Бусад бүлгийн гишүүдээ дуудаарай.

10-ыг хүчингүйд тооцсон учраас дахин санал хураалт явуулъя.

*Санал хураалт дахин.*

58.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 3.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.3. “зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд” гэж татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хязгаарлагдмал хариуцлагатай компани, нөхөрлөлийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Яг уг хуульдаа энэ заалт байлаа шүү дээ. Энэ яг ингэж оруулах хэрэг байгаа юм уу? Энэ тэгээд хөндөөгүй заалт байх.

*Санал хураалт.*

Энэ төсөл дээрээ өөрчилчихсөн юм байна. Яг хууль дээр яг энэ заалт байсан юм. 61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Х.Булгантуяа нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 9 дүгээр зүйлийн гарчиг болон 9.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“9 дүгээр зүйл.Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд**

9.1.Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд нь татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хязгаарлагдмал хариуцлагатай компани, нөхөрлөл байх бөгөөд зөвлөх үйлчилгээ эрхлэхдээ бусад татварын мэргэшсэн зөвлөхтэй гэрээгээр хамтран ажиллаж болно.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, Хүрэлбаатарын Булгантуяа 2 байна.

*Санал хураалт.*

Батжаргал гишүүн ажлын хэсгийн гишүүн биш.

58.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 10.1.1, 10.1.2, 10.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.1.1.эцсийн өмчлөгч нь татварын мэргэшсэн зөвлөх байх;

10.1.2.эрдэм шинжилгээ, сургалтын чиглэлээс өөр ажил давхар эрхэлдэггүй 2-оос доошгүй орон тооны татварын мэргэшсэн зөвлөхтэй байх;

10.1.8.хуулийн этгээд салбартай бол түүнд нэгээс доошгүй орон тооны татварын мэргэшсэн зөвлөхтэй байх;” Санал гаргасан ажлын хэсэг.

*Санал хураалт.*

61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалтын 11.1.4 дэх заалт, мөн зүйлийн 6 дахь заалтын 12.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.4.үйлчлүүлэгчийн өмнөөс үйлдсэн, шалгасан татварын тайлан, холбогдох бусад баримт бичигт зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал болон орон тооны татварын мэргэшсэн зөвлөхийн эрхтэй албан тушаалтан гарын үсэг, эсхүл тоон гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулах;

12.2.Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрлийг 5

жилийн хугацаатай олгох, сунгах бөгөөд энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

58.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ эх хууль дээрээ 12.2-т байна шүү дээ 5 жилийн хугацаагүй зүгээр олгож байсныг 5 жилийн хугацаатай болгодог нь яаж байгаа юм. Зөвшөөрлийн тухай хууль дээр Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна гээд.

15.Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 14.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.5.Татварын мэргэшсэн зөвлөхийн эрхийг гурван түвшний зэрэглэлтэй олгох бөгөөд нэг, хоёрдугаар түвшний зэрэглэл тус бүрийг 5 жилийн хугацаагаар, гуравдугаар түвшний зэрэглэлийг хугацаагүй олгоно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

56.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16 дугаар саналыг гүйцээн боловсруулъя гэсэн үү?

16, 17 дугаар саналуудыг гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

18. Төслийн 4 дүгээр зүйлийн 13.3 дахь хэсгийг төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт болгон шилжүүлж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.3.Зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийн орон тооны татварын мэргэшсэн зөвлөх ёс зүйн зөрчил гаргасан талаарх Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн тодорхойлолт болон бусад

этгээдээс мэдээлэл ирсэн тохиолдолд тусгай зөвшөөрөл олгосон эрх бүхий этгээд түдгэлзүүлэх, хүчингүй болгох эсэхийг шийдвэрлэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

58.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг төслийн 2 дугаар зүйл болгон шилжүүлж, “авахад” гэсний дараа “болон татварын мэргэшсэн зөвлөхийн эрхтэй холбогдсон харилцаанд” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

20. Төслийн 5 дугаар зүйлийг төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт болгон шилжүүлж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.1.6.хуулийн этгээд, түүний эцсийн өмчлөгч нь татварын өргүй талаарх тодорхойлолт;” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

56.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21.Төслийн 7 дугаар зүйлийн дагаж мөрдөх хугацааг “2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

56.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Одоо найруулгын саналаар санал хураалт явуулна.

Найруулгын саналын нэг.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын “4.3, 4.4 дэх заалт” гэснийг “4.3, 4.4 дэх хэсэг” гэж өөрчилж, 3 дугаар зүйлийн “хэсэг,” гэсний өмнө “зүйл,” гэж нэмж, төслийн 4 дүгээр зүйлийн “зөвлөх үйлчилгээ эрхлэх” гэсний ард тохиолдол бүрт “хуулийн” гэж нэмж, мөн зүйлийн “11.1 дэх хэсэг” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

56.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг хөндөхгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналаар санал хураалт явуулъя.

Төсвийн байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.3.Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн татвар хариуцсан ажилтан нь татварын

мэргэшсэн зөвлөх байна.” Санал гаргасан ажлын хэсэг.

Сайнхүүгийн Ганбаатар гишүүн. Санал гаргасан гишүүн өөрийн саналыг тайлбарлаж үг хэлж болно дэгийн дагуу.

Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

**С.Ганбаатар:** Эрхэм гишүүд ээ энэ бол төрийн өмчийн компаниуд дээр орон тоо нэмэх тухай ерөөсөө биш. Татвар мэргэшсэн ажилтан нь татварын талаар хариуцлага үүрэхүйц мэдлэгтэй, мэдээлэлтэй, тодорхой тэр шат шатын курс дамжаануудыг нь төгссөн мэдлэгтэй байх ёстой шүү л гэсэн төрийн буюу татварын энэ үйл ажиллагааг стандартжуулж хариуцлагажуулж байгаа л механизм шүү. Төрийн өмчийн компаниуд дээр нэг ч орон тоо нэмэх тухай ярихгүй. Зөвхөн хэрвээ тэнд хариуцаж байгаа хүн байгаа бол мэргэшсэн хүн байгаарай л гэсэн ийм санал байгаа юм.

Дэмжиж өгөөсэй гэж хүсэж байна аа.

**Г.Занданшатар:** Тэгэхдээ энийг байна шүү дээ Төсвийн байнгын хороонд гүйцээн боловсруулах чиглэл өгье. Тэр агуулгаараа байна шүү дээ Мэргэшсэн нягтлан бодогч гэдэг ийм статус бас бий. Татварын мэргэшсэн нягтлан бодогч гэж бас тусдаа бий.

Тэгэхээр тийм томъёоллоор өөрчлөхгүй бол татварын мэргэшсэн зөвлөх байна гэхээр түрүүн Амарсайхан сайд шүүмжлээд байсан л даа. Төрийн өмчийн компанид нэг орон тоо нэмж авах гээд энэ тэр гээд.

Гүйцээн боловсруулах чиглэл өгье.

Тэгвэл тэр байгаа хүн нь байна шүү дээ хариуцсан ажилтан нь татварын талаар мэргэшсэн сургалтад авна гэсэн юм байна. Энэ төрийн өмчийн компаниуд

бол татвараас зайлсхийх юм харьцангуй гайгүй байдаг юм шүү дээ.

Тэгээд тэрнийгээ хариуцлагажуул тэгэхдээ тийм агуулгаар нь бичье. Ингээд тийм агуулгаар нь гүйцээн боловсруулах чиглэл өгье.

Зочид танилцуулъя. Дэлхийн цагаан таягтны эрхийг хамгаалах өдрийг угтан Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатарын урилгаар СБД-ийн 116 дугаар сургуулийн багш, сурагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа.

Хүндэт багш сурагчдадаа сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Та бүхэн маань бас ер нь бас манай Улсын Их Хурлаас энэ орох, гарах гарцаас авхуулаад тэгээд брайль үсгээр Үндсэн хууль холбогдох бичиг хуулиудыг хэвлэх ажлууд зохион байгуулж байгаа. Тэгээд энэ юмнууд дээр бас манай Цогтбаатар гишүүн, Хууль зүйн байнгын хорооны даргаар шинээр сонгогдсон их идэвх чармайлтай ажиллаж байгаа. Энэ чиглэлээр улам сайн ажиллах хэрэгтэй нэн ялангуяа зөвхөн цагаан таягтны өдрөөр биш цаашидаа бүр бүхий л чиглэлээр эрхийг хамгаалах чиглэлээр ажиллах хэрэгтэй.

Амжилт хүсье.

Дараагийн асуудалд орно оо.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууссан.

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна.

15.00 цагт

Дараагийн асуудалд орно.

Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлөөр шийдвэрлэсний дагуу *Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна аа.*

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд танилцуулна. Индэрт урьж байна.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Бат-Амгалан, Амартүвшин, Энхтүвшин нараас 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн *Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 10 сарын 12-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хорооны шилжүүлсэн Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 10 сарын 12-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухайд хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцлээ.*

Тус Байнгын хороо хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Энхболд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь хэсэгт заасныг баримтлан хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн

батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

*Их Хурлын эрхэм гишүүд ээ,*

*Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслийг эцэслэн баталж өгөхийг та бүхнээс хүсье.*

*Анхаарал тавьсанд баярлалаа.*

**Г.Занданшатар:** *Ажлын хэсгийг танилцуулъя.*

*Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн бөгөөд Ажлын албаны дарга Дугардоржийн Баяндүүрэн. Сонгуулийн ерөнхий хорооны Хуулийн хэлтсийн дарга Доржсүрэнгийн Бат-Эрдэнэ.*

*Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна.*

*Байнгын хороо Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна аа.*

*Ганбат гишүүн асуулт асуух уу? Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууна.*

**Д.Ганбат:** *Ингээд хугацаа нь тулчихсан асуудал байгаа байх. Хурдан хэлэлцээд оруулж ирж байна. Нэг талдаа*

*сайшаамаар нөгөө талдаа бас бодмоор асуудал шүү.*

*Тэгэхээр СЕХ-ныхонд маань ороод ирчихсэн байна. Бид чинь одоо 2023, 2024 оны улсын төсөв дээр энэ аймаг орон нутгийн сонгууль болон Улсын Их Хурлын сонгууль 2024 онд явагдана. Та нар маань хэр бэлтгэлтэй байгаа вэ?*

*Бид нар баахан 2020 онд байна уу даа баахан баталгаагүй программтай машиныг ажиллуулж сонгуулийг санал хураалтыг явуулсан байгаа. Энэ явдал 2024 онд хэрхэвч давтагдаж болохгүй ээ. Хуулиараа нөгөө нэг чернилээр тэмдэглэх энэ тэр гээд л баахан асуудлууд байгаа. Хэр зэрэг бэлтгэл хангаж байгаа вэ? Холбогдож байгаа юу?*

*Бүх машинуудаа программыг нь баталгаажуулсан уу, шинэчилсэн үү, энэ талаар ямар ажил явагдаж байна вэ гэдгийг бас нэг энэ далимд асуучихъя.*

*Дугардоржийн Баяндүүрэн. СЕХ-ны гишүүн, ажлын албаны дарга.*

**Д.Баяндүүрэн:** *Ганбат гишүүний асуултад хариулъя.*

*СЕХ-ны хувьд бол саяын батлагдсан 2 хууль Улсын Их Хурлын Сонгуулийн хууль, Улс төрийн намын тухай хууль тогтоомжтой холбоотой бэлтгэл ажлын төлөвлөгөө гаргаад ажиллаж байгаа. Өчигдөр Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгаа хийсэн.*

*Санал тоолох төхөөрөмжийн хувьд бол одоогийн байдлаар бэлэн байгаа бол 2493 санал тоолох төхөөрөмж бэлэн байдалтай байгаа 257 төхөөрөмжийг бол акталсан. Сая төсвийн тодотголоор бол 507 төхөөрөмж авах зардлыг батлуулсан гэрээ хэлэлцээр хийгдсэн. Одоо 11 сарын 30-ны дотор бол шинэ төхөөрөмжийг бол хүлээж авна аа. Энэ төхөөрөмж маань ICP-2 гээд бидний хэрэглэж байгаа*

төхөөрөмжийн дараагийн хувилбарын төхөөрөмж 500 ширхгийг худалдаж авахаар ингээд хийгдэж байгаа.

Программ хангамжийн хувьд лицензийн төлбөрийг бол байнга төлж байгаа. 2020 оны сонгуулиар бол ашигласан машин болгондоо лицензийн төлбөрийг төлж явж байгаа. Одоо ч гэсэн энэ 2024 оны сонгуулиар ирэх сонгуулийн зардлын төсөвтэй бол лицензийн төлбөрөө тусгаад явж байгаа. Нийтдээ 3 мянган машин ажиллуулахаар бол тооцож байгаа. Энэ төлбөр бол бүгд төсөвтэй явж байгаа.

Сонгуулийн зардлын хувьд бол бид нар төсвөө бол бэлтгээд өгчихсөн байгаа. Их Хурлын сонгуулийн зардал, орон нутгийн сонгуулийн зардал нийлээд нэг нийтдээ манай сонгуулийн зардал 65 орчим тэрбум төгрөгөөр төсөвлөгдсөн явж байгаа гэдгийг танд хэлье ээ. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хороо Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалт.

58.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн учраас Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төрийн

байгуулалтын байнгын хорооны шилжүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу маргааш өглөө 10 цагаас буюу баасан гаргийн 10 цагаас эцэслэн батлах санал хураалт явуулна.

Гишүүд идэвхтэй оролцоорой.

Зочид танилцуулаадахъя. Ерөнхий боловсролын Шинэ Монгол сургуулийн 8 дугаар ангийн багш сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Хүндэт сурагч, багш нартаа сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөгөөд сурах чиглэлийг эрхэм болговол хандах зүг өөрөө тогтохын учир сур сур бас дахин сур гэсэн тэр сургаалыг санаж шинэ Монголынхоо ирээдүйг бүтээхийн төлөө сайн сурлагатай байхыг хүсэн ерөөгөөд тэгээд сурлага, хөдөлмөр спортын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр төлөвлөсөн асуудлууд үндсэндээ дууссан.

Тэгэхдээ даргын дэд зөвлөл дээр яаралтай хэлэлцэх нэг асуудлын горимын санал ирсэн байгаа. Ер нь бас эртхэн ажилд нь оруулж байвал. Тийм учраас Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд түр завсарласныг мэдэгдье. Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүд бэлэн байгаарай.

15.10 цагт

## ЗАВСАРЛАГА

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 10 дугаар сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаан үргэлжилж байна.



*Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.  
Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх  
тухай асуудлыг хэлэлцэнэ.*

Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд танилцуулна.

Хэлэлцэх асуудалдаа ингээд оръё. Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд танилцуулна аа. Индэрт урьж байна.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Хишгээгийн Нямбаатар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ Монгол Улсын Их Хуралд 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр ирүүлсэн Төрийн байгуулалтын байнгын хороо Улсын Их Хурлын гишүүнийг чөлөөлөх тухай асуудлыг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ. Улсын Их Хурлын гишүүн Хишгээгийн Нямбаатараас ирүүлсэн Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтийг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүнийг чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Үг хэлж болно л доо.

Ингээд асуултын дараа үг хэлнэ. Асуух уу, үг хэлэх үү? Асуулт байхгүй гэвэл шууд үгэндээ ороод үг хэлж болж байна тэгэх үү? Тийм асуугаад л хариулаад л. Тэгээд л асуулт хариулт алга байна. Үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ бүртгүүлнэ. Баттөмөрийн Энхбаяр гишүүнээр тасаллаа. Сандагийн Бямбацогт гишүүнээр тасаллаа. Балжиннямын Баярсайхан гишүүн үг хэлнэ ээ.

**Б.Баярсайхан:** Ингээд Нямбаатар сайд маань өнөөдөр Нийслэл хотын Засаг дарга болохоор асуудал хэлэлцэгдэж байна. Ямар ч байсан өнөөдөр Улсын Их Хурлын 2020-2024 онд Нямбаатар сайд маань Хууль зүйн сайдаар ажилласан. Энэ ажиллах хүрээндээ бас сүүлийн 30 жил төдийлөн олон нийтэд ил болоогүй байсан авлигын асуудлуудыг илчлэхэд нийгмийн одоо энэ хүсэн хүлээж байгаа энэ шударга байдлыг тогтооход магадгүй хэзээ ч илрэхгүй байсан хэзээ ч сонсохгүй байсан тэр асуудлуудыг илрүүлэхэд бас манлайлж ажилласан сайн ажилласан гэж ингэж үз үздэг. Тэгээд би Нямбаатар сайдад нэг зүйлийг онцгойлон хэлмээр байна. Энэ нийслэл хот бол өнөөдөр Монгол Улсын хамгийн их хүн ам төвлөрсөн ялангуяа хүүхдүүдийн аюулгүй байдал төдийлөн хангагдаж чадаагүй ийм хот байгаа.

Тийм учраас НЗД-аар ажиллахдаа мэдээж түгжрэлийн асуудал чухал. Энэ утааны асуудал бол хамгийн тулгамдсан асуудал боловч энэ асуудлуудын нэн тэргүүнд нь хүүхдийн асуудлыг та бас анхаарч ажиллаасай. Энэ 9 дүүрэг ялангуяа энэ нийслэлийн Гэр бүл, хүүхэд залуучуудын газар өнөөдөр төдийлөн үр дүнтэй бас ажиллаж чадахгүй байгаа.

Энэ ажил дээр маш их анхаарлаа хандуулж хүүхдийг 1 дүгээрт тавьж. Хүүхдийн аюулгүй байдал хүүхдийн эрхийг нь хангах хамгаалах ажил дээр манлайлж бас яг энэ Хууль зүйн сайд байсан шигээ бусад энэ асуудлуудыг онцгойлон анхаарсан шигээ нийслэлд амьдарч байгаа хүүхдүүдийн сайн сайхны төлөө бас таныг хичээнгүйлэн ажиллаасай гэж хүсэж байна аа.

Ингээд одоо таны Хууль зүйн сайдын ажлыг Энхбаяр сайд маань үргэлжлүүлнэ. Тэгээд Энхбаяр сайддаа бас хамтарч энэ хүүхдийн эрхийг хамгаалах тал дээр энэ чухал хуулиуд дээр бас хамтарч ажиллана байх гэдэгт итгэж байна. Тэгээд амжилт хүсье.

Баярлалаа.

**Г.Занданшатар:** Цэрэн Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн үг хэлнэ.

**Ц.Мөнхцэцэг:** Тэгэхээр Монгол Улсын хүн амын Монгол Улсын улс төр нийгэм соёлын гол төв болсон Улаанбаатар хотын Засаг даргаар томилогдож байгаа Нямбаатар гишүүнд бас баяр хүргэе. Тэгэхээр Монгол Улсын хүн амын хамгийн том төвлөрөл болсон нийслэл Улаанбаатар бол хүн амын төвлөрөл, боловсролын ачаалал, замын түгжрэл, утаа гээд асар олон асуудалтай байгаа. Тэгэхээр энэ хүнд энэ асуудлыг шийдэхэд бодлогын болон томоохон реформууд хийх ийм зориг хүч чадал бол Нямбаатар гишүүнд байгаа гэдэгт итгэж байна.

Тэгээд Улаанбаатар хотын хүн ам маань байнга нэмэгдэж байна аа. Бид нарт байгаа тооцоогоор бол 2040 он гэхэд манай Улаанбаатарын хүн ам 2.6 сая болох нь ээ. Тэгэхээр үүнийг дагаад бид нар энэ боловсролын асуудлууд, сургууль цэцэрлэгийн хүртээмж, зам, нийтийн тээврийн хүртээмж, эрүүл мэндийн үйлчилгээ, өрхийн төвүүд гээд

асар олон нийгэм, эдийн засаг, хүний хөгжлийн асуудлууд байгаа. Тэгээд энэ тал дээр манай нийслэлээс сонгогдсон Улаанбаатар хотын гишүүд маш сайшаалтай ажиллаж Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг батлуулсан.

Энэ хуулийн дагуу бол нийслэлд газар чөлөөлөлт болон бусад асуудал дээр бас нийслэлийн маань эрх зүйн статус нэлээн нэмэгдсэн байгаа. Ингээд нийслэлээс сонгогдсон гишүүний хувьд бид нарын хамгийн хэцүү зүйл бол энэ хүн амын төвлөрөл ихтэй сургууль цэцэрлэгийн хүртээмж муутай эсвэл цэцэрлэггүй хорооддоо цэцэрлэг шинээр барих улсын төсөвт оруулах ажил дээр хамгийн хэцүү юм нь газрын асуудал байгаа. Тэр газар чөлөөлөлт нийслэлийн газрын асуудлын тал дээр бас Улсын Их Хурлын гишүүд ажиллаж газрын хууль болон нийслэлтэй холбоотой энэ асуудлаар нэлээн анхааран ажиллана. Тэгээд энэ нийслэлийн төсөв нийслэлийн татварын асуудал дээр бас Засаг даргын хувьд та бас анхаарч ажиллах байх гэдэгт итгэж байна. Ер нь бол их хотын хувьд манай Улаанбаатар хотод иргэд маань чөлөөт цагаа зөв болсон өнгөрүүлэх спорт болон гүйлт дугуй гэж маш олон төрлөөр хичээллэх юм нь нэмэгдсэн.

Тийм учраас энэ сүүлийн жилүүдэд нийслэлд хийгдэж байгаа дугуйн замууд иргэдийн амрах зугаалах талбай стадионы тоог нэмэх ажлууд дээр та бас илүү анхаарч өгөөрэй.

Ер нь Улаанбаатар хот бол Азийн том метропол том хот байгаа. Тийм учраас бид нар бас хотын соёлыг нэвтрүүлэх асуудлаар анхаарна гэдэгт итгэж байна. Мөн хотын стандартыг бас яаралтай баталж мөрдүүлэх шаардлагатай байна. Улаанбаатар хотын барилга байшин, үйлдвэр үйлчилгээний газрууд тэгээд гэр хороолол дахь ингээд эрүүл, аюулгүй орчинд амьдрах нийслэлийн өнгө үзэмж нүүр царай болсон түүхэн дурсгалт газруудаа

хамгаалах зэрэг их олон асуудлаар та бас саналтай ажиллаж энэ дээр Нийслэлийн гишүүд бид нар бас эрх зүйн хувьд Улсын Их Хурлын түвшинд дэмжин ажиллана.

Ингээд таны ажилд амжилт хүсье.

**Г.Занданшатар:** Хассуурийн Ганхуяг гишүүн үг хэлнэ.

**Х.Ганхуяг:** Нямбаатар сайдад амжилт хүсмээр байна. Тэгэхдээ уг нь ингээд санал хураагаад ингээд явдаг бол бараг эсрэг өгмөөр байна. Явуулмааргүй л байна яг ний нуугүй хэлэхэд. Тэгээд яалт ч үгүй одоо хот дээр хотын ажлын үр дүнгээс хамаарч бас бид нарын ажлын бас үр дүн хамаардаг болохоор яалт ч үгүй гал асчихсан байгаа цэг дээр ингээд ажиллаж байхад нь ажиллах болж байгаад нь бас амжилт хүсье ээ.

Тэгээд хот дээр бид нар бол энэ утаа, түгжрэл, авлигал гээд аягүй олон асуудал шийдэх ёстой стандарт гээд аягүй олон асуудал шийдэх ёстой. Шинэ хотхонуудтай холбоотой сургууль, цэцэрлэг, хүүхдийн эрх зам гээд яривал асар их юм байна. Тэгээд тэрийг Нямбаатар сайд бол очоод ямар ч байсан нэг юм учрыг нь олчих байх гэж итгэж байна тэгээд амжилт хүсье ээ.

**Г.Занданшатар:** Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

**Б.Энхбаяр:** Нямбаатар сайд хотын хувьд бол шинэ хүн биш. Улаанбаатар хотын хамгийн их том хүн амтай Сонгинохайрхан дүүрэгт бас иргэдийн Хурлын даргаар ажиллаж байсан. СХД-ийг одоогийн Сонгинохайрхан 10 жилийн өмнөх Сонгинохайрхантай харьцуулах юм бол шал өөр болсон. 10 жилийн өмнө бол СХД-ийг хотын захын хаягдсан ийм л дүүрэг байдлаар төсөөлдөг байсан бол одоо Сонгинохайрхан дүүрэг бол одоо миний сонгосон Баянзүрх дүүргээс илүү

хөгжилтэй дэд бүтэц бусад сургууль цэцэрлэгийн асуудал ер нь олон асуудлуудыг бас шийдвэрлэсэн. Бүүр хотын төвийн дүүргийн хэмжээнд бас ингэж хөгжсөн байдаг. Сонгинохайрхан дүүрэг бол одоо 400 мянган хүн амтай. Яг Нямбаатар гишүүний өөрийнх нь сонгогдсон тойрог бараг 200 мянга хүрэх байх.

Тэгэхээр одоо Улаанбаатар 200 мянган хүнийг төлөөлж байсан бол 1.7 сая буюу түүнээс даруй 8 дахин их цар хүрээтэй их хотын айлыг хариуцаж явна. Би нэг зүйлийг бас хэлмээр байгаа юм.

Сумъяабазар даргын хотын дарга байхдаа хийсэн маш том асуудал бол нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийг баталж урьд урьд нь сүүлийн 20 жил Улаанбаатар хотын асуудал бол ерөөсөө л нэг хотын даргын асуудал гэж бүгд хаядаг байсан. Улсын Их Хурлын түвшин ч тэр, Засгийн газрын түвшин ч тэр. Тэгээд энэ олон жил ингээд орхигдоод бодлогын түвшинд орхигдоод явсны гор маш их олон асуудлууд хурсан.

Тэгээд анх удаа одоо Ерөнхий сайд хотын асуудал дээр бас нэлээн онцгой анхаараад Улсын Их Хурал дээр бас Бат-Амгалан гишүүн ахлаад Улаанбаатар хотын хөгжлийн түр хороо байгуулагдаад бодлогын түвшинд Улсын Их Хурал, Засгийн газар хот гэсэн энэ асуудлаа хамтдаа шийдье гэдэг чиглэл рүү явж байгаа. Энэ их үр дүнгээ өгнө. Яг энэ агиинд мөн хотод бас ажиллаж байсан Улсын Их Хурал Засгийн газарт бас одоо ингээд бүх юмаа мэддэг, тэгээд хурдтай, зоригтой. Энэ туршилага бол хот дээр гарах байх гэж ингэж итгэлтэй байгаа.

Гол нь хотын иргэд маань сайн дэмжээсэй гэж бодож байгаа. Манайхан чинь юм л бол тэгээд л нэг өөнтөглөдөг яадаг яах вэ Нямбаатар маань тэрийг тоодоггүй. Бас нэг чанартай, нэг онцлог чанар бол тийм жижиг яг гол том

зорилгоо хараад явдаг тэрнийхээ ард гардаг ийм бас давуу талтай. Би сая Хууль зүйн яаман дээр очоод танилцаж байхад бол хэдийгээр ковидын ийм хязгаарлалттай 2 жил байлаа гэхэд нийтдээ 27 хуулийг бас бодлогыг батлуулж чадсан байна. Тэгээд энэ бол өөрөө бас том хууль зүйн салбарын бас нэлээн олон том реформуудыг батлуулсан байна. Энийг бас тасалчихгүй юмсан гэсэн ийм одоо их ачаа бас дотроо бодогдож байгаа.

Тийм учраас одоо хотын шинэ дарга Нямбаатар сайдтай бол нягт хамтарч ажиллаж тулгамдсан асуудлуудыг шуурхай шуурхай шийдвэрлэх дээр бас гар нийлж ажиллана гэдгийгээ илэрхийлье. Тэгээд танд амжилт хүсье ээ.

Сандагийн Бямбацогт гишүүн үг хэлнэ.

**С.Бямбацогт:** Би бас Энхбаяр гишүүнтэй санал нэг байна. Бололцоо боломжоороо Монгол Улсын Их Хурал, Засгийн газар хотын иргэд ерөөсөө бүхий л түвшиндээ бид нар бас дэмжмээр байгаа юм. Баяр хүргээд байх тийм юу гэдэг юм том албан тушаал дээр, их эрх мэдэл дээр очоогүй. Маш хүнд хүчир, маш хэцүү, олон жил ужгирсан зовлонтой бэрхшээлтэй хэр баргийн аавын хүү аваад явчхаж чадахгүй ийм л ажил дээр очиж байгаа.

Одоо ингээд л утааны асуудал, агаарын бохирдлын асуудал, ингээд л түгжрэлийн асуудал нөгөө саяын бөөн асуудал болдог нийтийн тээвэр гээд л өдөр тутам Монгол Улсын нийслэл, Монгол Улсын нийт иргэдийн дийлэнх нь оршин сууж байгаа олон жил асуудалтай байсан олон жил асуудлыг шийдэх гэж оролддог байсан. Чадахгүй л байгаа ийм асуудал руу өөрийнхөө хүслээр биш Монгол Улсын Их Хурлаас даалгавар аваад, Монгол Улсын Засгийн газраас даалгавар аваад, Монгол Улсын Ерөнхий

сайдаас санал болгосных нь дагуу даалгавар аваад очиж байгаа.

Хэрвээ надад санал тавьсан би хэзээ ч үгүй л гэж хэлэх байсан. Яах аргагүй энэ цаг үед үнэхээр Нямбаатар сайдад Нямбаатар гишүүнд итгэл үзүүлж үнэхээр энэ ажлыг хийгээд бас нэг хотынхонд бас нэг нар өөд нь харуулчих болов уу? Бас нэг гэрэл гэгээ тусгачих болов уу? Бас энэ бухимдсан ард түмнийг бас нэг тайвируулах ажил арга хэмжээ хийчих болов уу? Богино хугацаанд бас нэг жсоохон үр дүн гаргаад бүүр тодорхой үр дүн гардаггүй юм аа. Ядаж нэг хонгилын үзүүрт нэг гэрэл гэгээ асаачих болов уу гэдэг л одоо сүүлчийнхээ итгэл сүүлчийнхээ горьдлого итгэлийг л бид нар тээж явж байгаа. Тийм болохоор Нямбаа сайдыгаа бас бололцоо боломжоороо бүхий л чадлаараа дэмжиж ажиллана аа.

Үнэхээр хүнд хүчир, хэцүү, хүчир ажил дээр очиж байгаа. Яах аргагүй энэ цаг үед ер нь хэр баргийн аавын хүү хийчих ажил биш ээ. 2016 онд бас би Хууль зүй, дотоод хэргийн сайд байхад өнөөдөр манай Их Хурлаар орж ирсэн маш том эрүүгийн эрх зүйн, иргэний эрх зүйн, захиргааны, эрх зүйн гээд олон том хуулиудын ажлын хэсгийг ахалж байсан. Тэр цаг үеэс л ажилласан. Урьд нь бас хотын нийслэлийн хамгийн том дүүрэгт Тамгын газарт ажиллаж байсан. Дүүргийн иргэдийн Хурлын төлөөлөгч байсан. Дүүргийн иргэдийн Хурлын дарга байсан. Энэ дүүргээс СХД-ээс 2 удаа Их Хуралд сонгогдсон. СХД-ийн бас нүүр царай сүүлийн 8 жилийн дотор өөр болж байгаа. Тийм болохоор л одоо, бас дүүрэгтээ ч хийсэн ажилтай энэ дүүргийнхээ төлөө хотын жаргал зовлонг мэддэг нөгөө талд нь бас энэ Улсын Их Хурал, Засгийн газрын түвшинд бас томоохон ажлуудыг хариуцуулчих юм бол бас хийж чаддагаа бас харуулсан.

Дөнгөж өнөөдөр Монгол Улсын Ерөнхийлөгч Хүрэлсүх Франц улсад айлчлал хийж байгаа. Энэ айлчлалын

хүрээнд үндсэндээ олон жил дундсан бас л хориод жил яригдсан гацсан гэрээг зурж байх шиг байна. Мааш том түүхэн бичиг баримтад. Энэ бичиг баримтыг бас боловсруулж өнөөдрийн түвшинд аваачих ажлыг бас Нямбаатар сайд ажлын хэсгийг ахалсан. Олон жил яригдаж байсан гэрээ гэх мэтийн олон бас гацчихсан том том төслүүдийг бас хөдөлгөхөд Засгийн газар дээр бас ачаа үүрч байсан.

Улсын Их Хурал дээр ч томоохон хуулиудыг явахад бас ажлын хэсгийг нь ахалж бас ачаа үүрдэг байсан. Тийм болохоор л энэ одоо бас өмнө нь хийж бүтээсэн ажлын бас дадлага туршлага, бас нэг ажил хариуцуулах юм бол бас зүтгэчихдэг. Энэ зүтгээд чанар энэ бүгдийг нь үнэлж байж л Монгол Улсын Их Хурлаас, Монгол Улсын Ерөнхий сайдаас, Засгийн газраас бас өнөөдөр бас итгэл үзүүлж байгаа. Дуртайдаа очоогүй шүү нэг их баярлаад байх ажилд очоогүй байдаг юм.

Үнэхээр одоо маргаашинаас эхлээд ханцуй шамлаад л мааш хүнд хүчир ажилд орно оо. Тийм болохоор бас Нямбаатар гишүүнийгээ, Нямбаатар сайдыгаа, бас бүх бололцоо боломжоор бас дэмжиж ажиллана, хамтарч ажиллана гэдгээ бас хэлье ээ. Тэгээд Их Хурал ч гэсэн Засгийн газар бүх түвшиндээ Монголын Улаанбаатарт иргэд ч гэсэн бас бүх бололцоо боломжоор бас дэмжээсэй. Өнөөдөр бас ажил хийхэд бас тодорхой хугацаа хэрэгтэй. Тэр болтол нь бас хүлээж хараасай. Бүх бололцоо боломжоор бас дэмжээсэй. Маргааши томилогдлоо гээд янз янзын байдлаар бас хэлээд эхлээсэй л гэдгийг бас нийт иргэдээсээ хүсье ээ.

Тэгээд амжилт хүсье.

**Г.Занданшатар:** Цагаанхүүгийн Идэрбат гишүүн.

**Ц.Идэрбат:** Өнөөдөр ингээд нэг Их Хурлын гишүүн маань сайд хийж байсан хүн маань нийслэл хот руу ер нь томилогдож байна л даа. Сая одоо тэгээд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр бас гарч байна. Ингээд Ерөнхий сайд баталгаажуулснаар ингээд Улаанбаатар хотын захирагч гэдэг энэ хариуцлагатай том албанд л очиж байна. Тэгээд өнгөрсөн хугацаанд энэ Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ажиллах энэ явцдаа хууль, эрх зүйн салбар мөн улс орны хөгжлөөс хойш нь татаж байсан олон чухал албыг бас нэр төртэй гүйцэтгэж байсанд би туйлын бас талархалтай байдаг.

Одоо шинэ сайд ч гэсэн энэ үйл ажиллагааг цааш нь үргэлжлүүлээд ингээд улс орны энэ эдийн засгийн гол боомлоод байгаа энэ авлигал албан тушаалын олон асуудлууд бас цаашаа эрчээ аваад ингээд явах байх гэж ингэж бас бодож байгаа юм.

Тэгээд нийслэл бол одоо бас үнэхээр том айл. Тэгээд л хог шороо, нохой, гахай, гэрэлтүүлэг тэгээд л орохгүй ч юм байхгүй. Их л том салбар аж ахуйн гол ажлууд энд бас явж байдаг. Гэхдээ Улаанбаатар хотын иргэн болоод би 2 жил боллоо. Олон юмыг ингээд харж байхад аж ахуй ажлын араас хөөцөлдөөд бол энэ болгоны ард гарахад ер нь туйлын хүнд юм байна. Энэ Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийг ер нь яаралтай хэлэлцүүлэх ёстой юм байна. Энд аж ахуйн ажил хийхээсээ гадна бас улс төрийн том манлайлууд бас их үгүйлэгддэг дутагддаг юм байна гэж ингэж бас хараад байгаа юм.

Дээрээс нь энэ хууль эрх зүйтэй холбоотой энэ газартай холбоотой энэ олон асуудлууд дээр бас зоригтой шийдвэрүүдийг гаргаасай гэж ингэж хүсэж байгаа юм. Ингэхгүй бол явахгүй юм байна аа. Өнгөрсөн 2023 онд Монгол Улсын Их Хурал төсөв батлахдаа орон

нутагт нэг ч шинэ юм тавихгүй байж байгаад Улаанбаатар хотын нийтийн тээврийг сайжруулна гээд л ингээд л төсөв тавиад өгөхөд өнөөдөр бид нар шинэ автобустайгаа золгож чадаагүй байгаа нийслэлийн ард иргэд.

Тэгэхээр энэ мэтээс авхуулаад ер нь хаанаа асуудал нь явдаггүй юм. Хаанаа гацаагаад байдаг юм. Хаанаа хууль бус юм нь яваад байдаг юм гэдгийг бас би гаргаж ирж. Энэ нэг нийслэлийн ард түмэн аятай тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд саад болоод байгаа олон хүчин зүйлүүдийг илрүүлж гаргаж ирэх байх. Шийдэх байх гэж. Ингэж бас бодож энэ одоо хариуцлагатай томилолтыг авч байна л гэж ингэж бас ойлгож байгаа.

Тэгээд улс төрчийнхөө хувьд бас их юу гэдэг юм их мундаг шийдвэрийг бас гаргаж чадаж байна л даа. Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн гэдэг энэ улс төрийн өндөр эрэмбэн дээрээс хотын дарга гэдэг энэ хариуцлагатай албанд ингээд томилогдоод ингээд явж байгаад би бас улс төрийн манлайлал гэж ингэж бас харж байгаа. Тэгээд таны ажилд амжилт хүсье.

Энэ хотын сая гаран хүний ажил амьдрал, аятай тухтай орчин нөхцөл гээд танаас шалтгаалах болж байна. Сая Бямбацогт сайд бас хэлж байна. Тэгээд таныг маргааш томилогдоход нөгөөдөр утааны асуудал дэгдэнэ олон асуудлууд байгаа тэгээд нийслэлийн ард түмэн бас энийг ойлгож, хүлээцтэй хандаж, шийдвэрүүдийг нь дэмжиж, хамтдаа бас урагшлах нь зүйтэй болов уу гэж ингэж бас боддог.

Ер нь нийтээрээ мөрдөх энэ шийдвэрийг гаргахад олон түмнээсээ асуух олон түмний дэмжлэгийг авна гэдэг бас энэ шийдвэр цаасан дээр биш амьдрал дээр хэрэгжээд явахын бас жишээг олон зүйлүүд дээр харж байсан. Тэгээд энэ болгоныг Нямбаатар гишүүний хувьд бас

хэрэгжүүлээд явна гэдэгт итгэлтэй байна. Амжилт хүсье.

**Г.Занданшатар:** Цэвэгдоржийн Туваан гишүүн.

**Ц.Туваан:** Улаанбаатар хотын дарга, захирагч гэдэг том албан тушаал, том ажил. Энэ бол Монгол Улсын хүн амын тал засаг захиргааны нэгж ингээд бүгд оршиж байгаа яамдууд оршиж байгаа энэ томоохон газар. Тэгэхээр энэ бол мэдээж амаргүй ажил. Манай Төв аймгийн хувьд бол Улаанбаатар хотыг бүслэн оршдог. Энэ юу хэлж байна вэ гэхээр улс доторх улс гэдэг шиг яг 100 хувь Улаанбаатар хотыг эргэн тойронд Төв аймгийн газар нутаг оршдог гэсэн үг.

Тэгэхээр ер нь бол Улаанбаатар хот, Төв аймаг 2 бол хоорондоо маш уялдаа холбоотой хамтарч ажиллах ёстой гэсэн ийм агуулгаар би хэлж байгаа юм. Улаанбаатар хоттой Төв аймгийн 7 сум газар нутгийн маргаантай. Нийслэл маань ингээд л тийм ч шийдвэр ийм ч шийдвэр гээд л ингээд шийдвэрүүдээ гаргаад ингээд байнга ийм тэлэх бодлогыг явуулж байдаг. Тэгэхээр энэ дээр бас ингээд айл саахалт ингээд оршиж байгаа аймагтайгаа энэ дээр уян хатан байж харилцан концесс хийж ингэж ажиллана байх гэж ингэж бодож байна. Монголчууд бас хуучны их амьдралын ухаантай улсууд. Салхин доорх айлтайгаа мууддаггүй ээ гэж. Яагаад вэ гэхлээр адуу үхэр мал нь салхинд уруудаад очихоор муу айл бол тэрийг нь хэлдэггүй юм байна л даа. Тэрэн шиг эргэн тойроод амьдарч байгаа яг энэ Төв аймагчуудтайгаа бас нягт хамтарч ажиллаарай гэж ингэж хүсэх байна.

Нийслэлийн хүн амын бүх хоол тэгээд л гараад хотоос гараад амрах аялал жуулчлах энэ асуудал мэдээж манай Төв аймгийн нутаг дээр явдаг аа. Тэгэхээр энэ дээр Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн байсан хүнийхээ хувьд бас энэ чанартай сайн чанарын эрүүл хүнсийг

бэлтгэж авах ажил дээр бас Төв аймгийнхантай дэмжиж хамтарч ажиллана гэдэгт найдаж байна.

Яагаад вэ гэхлээр төмс, хүнсний ногоо, сүү, цагаан идээ, мах энэ өөр газруудаас ирдэг. Тэгэхдээ бараг 70 80 хувийг нь Төв аймгийн нутаг дэвсгэр дээр бэлтгэгдэж ингэж явдаг аа. Тэгэхээр энэ дээр энэ Төв аймгаас орж ирж Төв аймаг ч гэлтгүй ер нь энэ малчид, тариаланчид, ногоочдоос орж ирж байгаа энэ асуудал энэ намар намартаа нэг мал таргалсан үе. Ногоо тариа хураах үе дээр бол энэ борлуулах асуудал маш хүндэрдэг. Тэгэхээр энэ нийслэлд тулгамддаг асуудал юу гэхлээр хаана борлуулах вэ гээд. Тэгээд л сүүлийн үед мэдэж байгаа шүү дээ. Машиныхаа багаажид хийчхээд л энд тэнд зогсож байдаг болсон. Тэгэхээр энийг тэр борлуулах асуудал дээр бас нэг ахиц дэвшил гаргасан ийм шийдэл гаргаж ажиллавал энэ хаа хаанаа их чухал асуудал болно оо.

Улаанбаатар хот үндсэндээ дөрөвхөн гарцаар Төв аймгийн нутаг дэвсгэрээр бусад газрууд руу гарч байгаа юм. Зүүн тийшээ Налайх, урагшаа Дундговь, баруун тийшээ Өвөрхангай, хойшоо Дархан, Сэлэнгийн замаар. Тэгэхээр энэ юу хэлж байна гэхлээр Төв аймгийн нутаг дэвсгэр дээр бас малын гоц халдварт янз бүрийн гоц халдварт өвчин энэ тэр гарлаа гэхэд бас л Улаанбаатар хот руу орох гарах энэ асуудал бас нэлээн үүсдэг юм. Тэгэхээр энэ нийслэлийн мал эмнэлгийн албаа энэ төв мал эмнэлэгтэй бас ингэж хамтарч ажиллуулах асуудал нэлээн хүн амын эрүүл мэндтэй холбоотой бас ийм чухал асуудал байдаг гэдгийг бас энэ дацрамд хэлье. Ингээд нохой нэг гудамжинд хүүхэд урчихаас өгсүүлээд л жижиг гэлтгүй энэ асуудлаас өгсүүлээд л, тэгээд л утаа, түгжрэл гээд л бүх асуудал таны толгой дээр ирнэ ээ.

Тэгэхээр хүнд ажлыг бас авч байгаа. Амаргүй шийдвэр гаргаж байгаа.

Сайн ажиллаарай. Өмнөх дарга нарынхаа алдааг битгий давтаарай гэж хэлье ээ.

**Г.Занданшатар:** Хишигээгийн Нямбаатар гишүүн.

**Х.Нямбаатар:** Баярлалаа. Юуны өмнө надад өндөр итгэл хүлээлгэж Монгол Улсын Их Хуралд хоёронтоо сонгож итгэл зориг дэмжлэг үзүүлж ирсэн СХД-ийнхээ иргэд, сонгогчдодоо чин сэтгэлээсээ талархал илэрхийлье ээ.

Нийслэл хотод тулгамдсан ужгирсан олон асуудлуудын шийдлийг гаргаж шийдэх, шийдэмгий шийдвэрүүд гаргах ийм үүрэг даалгаврыг хүлээлгэсэн Монгол Улсын ерөнхий сайдын үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх итгэл өвөрлөж миний бие Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн албан тушаалд сонгогдох энэ саналыг хүлээж авч өнөөдөр Монгол Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ гаргаж байна аа.

Миний бие 2 удаа Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдохын зэрэгцээ Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол улсын ерөнхий сайд нарын дэмжлэгээр Монгол Улсын Хууль зүйн байнгын хорооны дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайдын албан тушаалуудыг хавсран гүйцэтгэж ирлээ. Миний бие Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллах хугацаандаа 100 орчим хуулийн төсөл санаачлах болон ажлын хэсгийг ахлах, хамтарсан баг ахалж боловсруулалтын ажлуудыг хийж ирлээ.

2020 оноос хойш миний бие Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ажиллах хугацаандаа нийтдээ 60 орчим хуулийн төсөл дээр ажиллаж түүний 27 хуулийг Улсын Их Хурлаар батлуулж, 13 хуулийг Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн ширээн дээр ирүүлсэн байгаа гэдгийг бас та бүхэндээ дуулгая аа. Үлдсэн 20 хуулийг Хууль зүй, дотоод хэргийн сайдаар

сонгогдон ажиллаж байгаа журмын нөхөр Энхбаяр гишүүн нягтлан боловсруулж өргөн барих ийм бас боломж нөхцөлүүд бүрдээд байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй байх.

Дээрх хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд нийтийн эрх зүйн салбарын шинэчлэлийг гүнзгийрүүлэх, эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн шинэчилсэн найруулгуудыг батлуулах эрүүгийн болон зөрчил шалган шийдвэрлэх процессын зарим анхдагч хуулийн төслүүдийг батлуулах ийм ажлууд амжилттай хийгдсэн. Үүнээс гадна үүний зэрэгцээ шүүх эрх мэдлийн шинэчлэлийг гүнзгийрүүлэх Шүүхийн тухай хууль батлагдан эдүгээ 2 жилийн нүүрийг үзэж байна. Шүүх эрх мэдлийн шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд цаашид шүүх байгуулах хуулийг энэ намрын чуулганаар хэлэлцэх ийм асуудлын дараалалд орсон байгааг бас дуулгах нь зүйтэй.

Хамтран зүтгэж хууль тогтоох байгууллагад зүтгэсэн эрхэм Их Хурлын гишүүддээ цаашидынх нь улс төрийн ажилд өндрөөс өндөр амжилтыг хүсье. Цаашид бид нар Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын хууль, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн хууль, Олборлох салбарын ил тод байдлын хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх хуулиудыг цаг алдалгүй хэлэлцүүлэх нь улс орны нийгмийн харилцааг зохицуулж байгаа хууль эрх зүйн салбарын томоохон шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд тустай гэдгийг би энэ удаа бас хэлэхийг хүсэж байна.

Ерөнхий сайд Засгийн газрын шийдвэрээр 55 ажлын хэсгийг ахалж ажилласан. Тухайлах юм бол Оюу Толгойн төслөөс Монгол Улсын хүртэх эрх ашгийг, үр өгөөжийг нэмэгдүүлэх ураны томоохон төсөл хөтөлбөр болох Орона компанитай байгуулах хэлэлцээр, Чайна Энержи компанитай олон жил гацсан Гашуунсухайт-Ганц модны төмөр замын

хил холболтыг хийхтэй холбоотой гэрээ хэлэлцээрүүдийн ажил нэлээдгүй урагшилсан гэдгийг би бас итгэл төгс хэлэхийг хүсэж байна аа.

Цаашид Монгол Улсын эдийн засгийн гол тулгуур болсон уул уурхайн салбарын томоохон төсөл хөтөлбөрүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулах ажил цаашид үргэлжилнэ гэдэгт итгэл төгс байна. Миний бие Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүнээр ажиллах хугацаандаа хууль тогтоомжийг боловсронгуй болгох, эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэхэд та бүхэнтэй хамтран ажиллаж ихээхэн зүйлийг суралцсан гэдгээ би бас энэ даширамд хэлэхийг хүсэж байна.

Нийслэл хотын 1.7 сая хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрах орчин нөхцөлийг сайжруулахын төлөө миний бие хоёргүй сэтгэлээр хичээн зүтгэж ажиллах болно. Нийслэл хотын хөгжил цэцэглэлтэд Их Хурал, Засгийн газар, иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын өргөн их дэмжлэгтэйгээр тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх учиртай. Ийм учраас Их Хурал, Засгийн газар та бүхэн бидний оруулж ирэх шинэчлэлийн бодлогуудыг цаг алдалгүй дэмжиж өгөхийг эцэст нь та бүхнээсээ хүсье ээ. Та бүхний ажил хөдөлмөрт өндрөөс өндөр амжилтыг хүсэн ерөөе. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Хишигээгийн Нямбаатарын Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх хүсэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Төрийн байгуулалтын байнгын хорооны саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор илээр санал хураалт явуулна. Кнопоор санал хураалт.

Санал хураалт.

Байнгын хорооны саналыг 60.5 хувийн саналаар дэмжсэн байна. Байнгын хорооны санал дэмжигдсэн тул “Улсын



*Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.*

*Тогтоолыг уншиж танилцуулна.*

*Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалт 10.2, 10.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:*

*Хишигээгийн Нямбаатарыг өөрийнх нь хүсэлтийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлсүгэй. Энэ тогтоолыг 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр эхлэн дагаж мөрдсүгэй.*

*Энэ манай Хишигээгийн Нямбаатар гишүүн маань 2019 оноос хойш бид Хууль зүйн байнгын хорооны даргаас эхлэн хамтран ажиллаж Улсын Их Хурлаар үндсэндээ 300 гаруй хууль тогтоомж дээр хамтран ажиллаж, манлайлж, санаачилж ажилласан. Хууль зүйн байнгын хорооны дарга, гишүүнээр ажиллаж байхдаа 100 гаруй хууль, сая 67 хууль, сая 27 хууль өргөн мэдүүлээд байна. Ингээд үндсэндээ энэ олон хуулийн эрх зүйн реформ шинэчлэлийг хийхэд Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөс эхлээд манлайлж ажилласан. Энэ хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр авлигатай тэмцэх 5 ш ажиллагааг зохион байгуулах авлигын эрх зүйн орчныг авлигатай тэмцэх эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр манлайлж ажилласан явдалд Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс энэ хууль тогтоох эрх зүйн шинэчлэлийг манлайлж ажилласан явдалд нийт Улсын Их Хурлын Тамгын газрын нэрийн өмнөөс бас талархаж байна.*

*Үнэхээр энэ хэцүү амаргүй цаг үед ч, ковидын цаг үед ч олон чухал асуудлыг нугалж манлайлж ажилласан. Сая ч бас дурдаж байна. Засгийн газрын олон ажлын хэсгүүдийг хамгийн хүнд хэцүү сорилттой ажлын хэсэг болгоныг ахалж, манлайлж тодорхой үр дүнд хүргэж*

*бүтээлч ажилласан. Үүний жишээ нь Оюу Толгойн гэрээнээс авхуулаад саяын Орано мөн Чайна Энерджи гээд олон чиглэлээр санаачилгатай манлайлагч байж ажилласан. Тэгээд улс төрийн манлайлал, үлгэр дуурайллыг нь, энэ улс төрийн капиталыг нь үнэлж Монгол Улсын Ерөнхий сайд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын захирагчаар, хотын даргаар томилох саналыг дэвшүүлж улс төрийн эр зориг гаргаж өнөөдөр Улсын Их Хурлын гишүүнээсээ чөлөөлөгдөж байна.*

*Улаанбаатар хот Монгол Улсын хүн амын 48.1 хувь, их, дээд сургууль, үйлчилгээний салбарын 80-аас 90 хувь Монгол Улсын эдийн засгийн 65 хувь төвлөрсөн. тэр хэмжээгээрээ түгжрэл, хөрс, агаар, усны бохирдол маш олон хуримтлагдсан асуудал хуримтлагдсан ийм хот, нийслэл хотын энэ бүх тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх томоохон эрс шинэчлэл, хөдөлгөөн өрнүүлэх нь зүйтэй. Энийг бол Улсын Их Хурлын зүгээс бүх талаар Нямбаатар гишүүнийгээ дэмжиж ажиллана. Манай Улсын Их Хурлын гишүүд дэмжиж ажиллах ёстой.*

*Үнэхээр энэ Улаанбаатар хотын түгжрэл, төвлөрөл, агаар, ус, хөрсний бохирдол, бохирдлын суурь шалтгаан бол энэ төвлөрлийн бодлогын алдаа. Ийм учраас Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн дагуу Улаанбаатар хотын дүүргүүд хот байх эрх зүйн үндсийг бас бүрдүүлсэн байгаа. Ийм учраас Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчлэлийн эх нь болох болов уу гэж бодож байна.*

*Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг бол шинэчлэн батлаад удаагүй байна. Ингээд Хотын эрх зүйн байдлын тухай хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль. Нийслэл хот бол хотуудаас бүрддэг олон улсын жишиг ч гэсэн тэр яагаад Сонгинохайрхан хот болж болохгүй гэж. Яагаад Баянзүрх хот*

болж болохгүй гэж. Ингээж байж төвлөрлийг сааруулж шинэ төвүүдийг бий болгож энэ шинэ төвлөрлийн төвүүд маань сургуулийн тойрог, эмнэлгийн тойрог төрийн үйлчилгээний тойргууд болж энэ зөвхөн Сүхбаатарын талбайгаа тойроод төвлөрчихсөн төвлөрлийг задалж энэ бол төвлөрлийг түгжрэлийг сааруулах нэг шийдэл болох төдийгүй энд төвлөрлийг сааруулах ажиллагаа дүүргүүдээс цаашид тэлж бүх аймгийн төвүүд хот болох ёстой.

Энэ бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн бүх аймгийн төвүүд хот болж ингээд нэ зөвхөн нэг хотод төвлөрч суудаг ард түмэн биш. Үндэсний эрх ашиг аюулгүй байдлын хувьд ч гэсэн тэр Улаанбаатар хот улс болчих гээд байна шүү дээ. Хүн амын 48.1 хувь. Удахгүй 50, 60 гээд ингээд өсөөд тэр хэмжээгээр бүх проблем нэмэгдээд л байна.

Өнөөдөр хөрсний бохирдол аюулын түвшинд хүрчихсэн байна. Зарим газруудад усны бохирдол ямар байна? Ийм учраас Үндсэн хуульд заасан хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг

хангахын хүрээнд бол ийм бодлогын өөрчлөлтүүдийг хийх талаар Улсын Их Хурал бас манлайлж дэмжиж хамтарч манай Нийслэл хотын хөгжлийн түр хороо бүгд ажиллах ёстой. Ингээд ийм хүнд хүчир ачааг асар богино хугацаанд авч үүрэх хариуцлагатай үүрэг ноогдож ноогдуулж Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөгдөж байгаа Нийслэл хотын захирагч, Улаанбаатар хотын захирагч, Нийслэл хотын даргаар томилогдож байгаа Хишигээгийн Нямбаатартаа Улсын Их Хурлын гишүүдийнхээ, нийт гишүүдийнхээ нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт хүсье ээ.

Баяр хүргэе гэхээсээ илүү бид ажлын өндөр амжилтыг хүсэж бүх талаар дэмжин ажиллах болно оо. Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье ээ.

17.47 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН:ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА